

“Хүн чанар” ажилд авна





Mongolian Cashmere

100% CASHMERE COAT

MADE IN MONGOLIA



ONLY FOR GOBI FACTORY STORE:

Tel: (976-11)343677, Fax: (976-11)343081, Web site: www.gobi.mn E-mail: marketing@gobi.mn

Grand
OPENING CEREMONY
2010.04.08



NEW MONGOLIAN
CHOICE 



KIA MOTORS
MONGOLIA

Эрхлэгчийн зурвас



Монголын эдийн засаг, бизнесийн салбарт “Mongolian Economy” нэртэй шинэлэг, өвөрмөц, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн баг бүхий мэргэжлийн сэтгүүл мэндэлж байгаад баяр хүргэе гэсэн мессэж манай редакцид олноор ирж байгаад бид маш их баяртай байна.

Улс орныхоо эдийн засаг, бизнесийн салбарт өрнөсөн олон чухал үйл явдлыг энгийн үгээр товч бөгөөд тодорхой хүргэхэд анхаарч ажилласан бидний зүтгэл хүмүүст хүрсэн нь дээрх мессэжүүдээс харагдах болов уу. Мөн түүнчлэн цөөнгүй хүн утсаар баяр хүргэж ярихын зэрэгцээ олон чухал санал зөвлөгөө өгсөн нь

хамгийн үнэтэй байлаа. Та бүхний өгсөн тэрхүү санал зөвлөгөөг авч, бид хоёр дахь дугаараа ийн хүргэж байна.

Монгол орныхоо хөгжлийн ирээдүй, шийдлийг ярилцсан Монголын эдийн засгийн чуулганы үеэр манай сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэж таарсанд бид бас баяртай байгаа. Тиймээс ч “Mongolian Economy” сэтгүүл Монголын эдийн засгийн чуулганыг сурвалжлан хүргэж байна. Бид тус чуулганаар хэлэлцсэн 15 асуудлыг зөвхөн нэг дугаартаа бөөнөөр бичихийг зорьсонгүй, цаашдаа дугаар бүртээ нэг нэг асуудлыг дэвшүүлэн хүргэж, хамгийн гол нь оролцогчдын хэлсэн шинэлэг санаа оноог төрөөс хэрэгжүүлэхэд хэр анхаарч ажиллаж байгааг сурвалжлан нэхэх болно. Тухайлбал, төр, засгийн түшээдийн зүгээс өндөр өсөлт, хөгжил, мөнгө төгрөг ихэд ярьсан бөгөөд нөгөө талдаа ядуурал Монголд буурсан эсэх нь эргэлзээтэй зарим нэг баримт дэлгэсэн нь манай сэтгүүлч И.Отгонжаргалыг гэр хорооллоос амьд сурвалжлага хийлгэхэд хүргэсэн юм. Нийслэлийн ядуурал улам газар авч, хавтгайрсан тухай Та энэ нийтлэлээс унших болно.

Мөн өдөр тутмын сониноор дүүрэн ажлын зар нийтлэгддэг мөртлөө яагаад ажилд тэнцэх хүн олдохгүй байгаа, ер нь улс орны хөгжлийн эх үндэс болсон боловсрол, хүний хөгжил, хүн чанарын талаар Д.Мөнхчимэг тэргүүн өгүүллийг бичлээ. Малчин Доржийн амьдралаар хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, тулгамдсан асуудлыг ч харууллаа.

“Байгаль эх” буландаа усны асуудлыг мөн л сөхөж тавилаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид манай сэтгүүл хэдийнэ хүрсэн бөгөөд тэрбээр эдийн засгийн мэдээллийг үнэн бодитой хүргэх сэтгүүл төрж байгааг сайшаагаад “Байгаль эх” булангаа улам өргөжүүлээрэй хэмээсэн нь бидэнд илүү сайн ажиллах урам боллоо.

Мөн түүнчлэн гадны олон хүн Монголын эдийн засгийн салбарын талаар тодорхой ойлголт өгөхүйц сэтгүүл гарч байгаад олзуурхан хүлээж авснаа хэлсэн юм. Ингээд “Mongolian Economy” сэтгүүлийг Монголын эдийн засаг, бизнесийн сайн сэтгүүл болоосой гэж санаа оноо, бодлоо харамгүй хайрласан бүх хүн, уншигч захиалагч нартаа талархснаа илэрхийлье.

Д.Бэхбаяр

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:
J.Itoto

Сэтгүүлч:
Д.Мөнхчимэг
9191 3154
Ц.Болормаа
9976 6275

Дизайнер:
Б.Пүрэвсүрэн

Маркетингийн менежер:
Б.Энхцэцэг
8881 4870

Утас/Факс: 976 - 7011 0064

Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn

Хаяг:
Улаанбаатар, СБД VI хороо,
Бага-Тойруу
37Б, Байр - 206 тоот

Борлуулах цэгүүд:

“Интер ном”
“Majestic” их дэлгүүр
“Цэцэг төв”
“Зиг заг” автосервис
“Grand plaza” мир салбар
“Metro mall” мир салбар

“Улаанбаатар принт”
ХХК-д хэвлэв

6-29 Эдийн засаг

- 6 Хүний хөгжилд чиглэсэн “Монгол Давос”
- 7 “Хүн чанар” ажилд авна
- 9 Халуун мөнгө
- 10 Малчин Доржынх сумын төвийн айл болсон нь
- 11 Нүүрээ угаая
- 12 Санхүүгийн шинэ тоглогч Хөгжлийн банк
- 14 Уул уурхайн орлогоороо урлаг соёлоо услая
- 18 Ядуурал буурсан уу?
- 23 Монголчууд юун дээр алдаж байна вэ?
- 24 Агаарын бохирдол иргэдийн эрүүл мэндийг “хямрааж” байна
- 25 Улаанбаатар хотын агаарын бохирдлыг арилгахад ямар хугацаа хэрэгтэй вэ?
- 28 Оюу Толгой Монголын хөгжилд юу авчрах вэ?

30-34 Хөрөнгийн зах зээл

- 30 “Их цэвэрлэгээ”
- 33 Санхүүгийн салбарыг хурдан хөгжүүлэх нь маш чухал

35-36 Дэлхийн эдийн засаг

- 35 Цунами

37-40 Ногоон эдийн засаг

- 37 Бурхнаас илгээсэн байгалийн эм

- 39 Усны эрчим хүчний нөөц

41-45 Ногоон эдийн засаг

- 41 Нүүрсний эрин юу авчрах вэ
- 43 “Шар нунтаг” үнэд орох цагаар...

46-63 Бизнес

- 46 Түүхэнд байгаагүй өндөр ханштай туулай жилийн ноолуур
- 49 Монгол орны Хөдөө аж ахуйн салбарын хөгжилд миний оролцоо
- 49 Монгол орны Хөдөө аж ахуйн салбарын хөгжилд миний оролцоо
- 50 Тахиа, пицца захиалмаар байна уу?
- 52 Гэр бүлийн бизнес ойлголцоход амар байдаг
- 56 PPP түншлэлээр 10 орчим төслийг хэрэгжүүлэхэд бэлэн боллоо
- 58 Тэрбумтнуудын халаас руу өнгийе
- 61 “Би дэлхийг илүү нээлттэй болгохыг хичээж байна”
- 63 Хөрөнгө оруулалт ба лидер байхын “урлаг”

64-40 Байгаль эх

- 64 Улаанбаатарчууд нүүх үү, үлдэх үү?
- 67 Туулын хөндий дэхь бидний соёл иргэншилд хэр хугацаа үлдсэн бэ ?
- 67 “No water no business”

69 Номын булан

70-73 Market Data



... Ноолуур 70.000 төгрөгийн ханштай байна гэвэл Та битгий гайхаарай..... (46)



...Газар хөдлөлт, цунами, атомын цахилгаан станцуудад нүүрлэсэн аюул... (35)



...Цэвэр усны нөөцтэй улс орон дэлхийн хамгийн баян орон болох тухай эрдэмтэн судлаачид тэмдэглэж байна.... (67)

Хүний хөгжилд чиглэсэн “Монгол Давос”



Давос дэлхийд юугаараа танигдсан бэ? Дэлхийн хамгийн том цанын бааз сэтгэлд бууж мэднэ. Гэвч эдүгээ олон улсын эдийн засгийн чиг хандлагыг тодорхойлдоггоороо Швейцарийн Давос хот зартай. Улс орнуудын төр, засгийн үе үеийн удирдагчид энд чуулж, эдийн засгийн бодлогоо боловсруулсаар 40 жил улирчээ. Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт зүгээр л “Давосын чуулган” гэдэг хоёрхон үгээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн брэнд болж чадсан юм. Тэгвэл бөмбөрцгийн хөгжлийн чиг хандлагад өөрийн нөлөөгөө тусгадаг уг байгууллагын төлөөлөгчид Улаанбаатарт ирж, Монголын эдийн засгийн форумд оролцсон нь нэгийг бодогдуулна. Төр, засаг, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын төлөөллөөс гадна бизнес эрхлэгчид, гадаадын хөрөнгө оруулагчид Төрийн ордонд цуглаж, хоёр өдрийн турш “хөгжлийг тодорхойлов”. Үүнийг онцлохын учир энэ удаагийн форумд оролцогчид тулгамдсан асуудлуудаа сөхөж, болохгүй бүтэхгүйгээ ярьж гомдоллохыг чухалчилсангүй. Харин болгохын төлөө юу хийх вэ гэдгээ хэлэлцэж, хөгжлийн загвараа гаргахыг зорьсон юм.

Монголын эдийн засгийн форум хүний хөгжлийг хэрхэн хангаж, чинээлэг дундаж давхаргыг хэрхэн бий болгох вэ гэсэн эцсийн зорилго агуулж байсныг Ерөнхий сайд С.Батболд онцолж байв. Харин Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хоёр дахь өдрийн чуулганыг нээж үг хэлэхдээ “Ашигт малтмал зөвхөн хөрсөн дээр мөрөө үлдээдэг биш, хүний хөгжилд мөрөө үлдээх ёстой” хэмээн тэмдэглэсэн билээ.

Өнөөдөр Монгол орныг үсрэнгүй хөгжлийн гараандээрээ байна гэж мэргэжилтнүүд ярьдаг. Нэгдсэн хуралдааныг удирдсан CNN-ийн олон улсын сурвалжлагч Стан Грант Монголын эдийн засгийг “Чоно эдийн засаг” хэмээн томъёолсон нь оролцогчдын сонирхлыг татсан болов уу. “Азийн дараагийн бар”, “Монголын чоно”, “Төв Азийн Кувейт” гэх мэт олон сайхан нэршилд бид хэдийнэ дасчээ. Гэвч юу юуны духанд хүрэлгүй “хошироход” эрт байна.

“Уул уурхай шууд эерэг үр дүн гаргаж чадахгүй. Хэрхэн удирдахаас л бүх зүйл шалтгаална” хэмээн Дэлхийн эдийн засгийн форумын төлөөлөгч Катрин МакПайл сануулсан юм. “Чили улс ашигт малтмалын

орлогоо боловсрол, хүний хөгжилд зарцуулсан. Тиймээс ч одоо Чили зөвхөн ашигт малтмалаараа биш, уул уурхайн техник, технологийн нийлүүлэлтээр дэлхийд толгой цохиж байна” гэж уг байгууллагын Дэлхийн үйлдвэрүүдийн төвийн тэргүүн Алекс Вон тайлбарласан юм. Тийм ээ, тэдний үгийг сонсч, бусад орны хөгжлийн туршлагаас судалж, дэлхийн жишигтэй хөл нийлүүлэн алхахын тулд л “Монгол Давос” төрж, хоёр нас хүрээд буй.

“Уул уурхайгаас олон жил мөнгө орж ирнэ. Энэ хугацаанд эдийн засгийн бүтцээ оновчтой болгохгүй бол бид голланд өвчнөөс өөр юу ч үгүй хоцрох вий” хэмээн Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг онцолсон бол Ерөнхий сайд С.Батболд “Монгол хүний боловсрол, мэдлэг, ур чадварыг эрс дээшлүүлж байж л бид улс орноо хөгжүүлж чадна” гэж тэмдэглэсэн билээ. “Засаг байгаа учраас иргэн байгаа биш, иргэн байгаа учраас засаг байгаа юм. Тиймээс манай төр, засгийн гол үүрэг бол иргэндээ үйлчлэх. Энэ туулай жилд иргэд рүү, орон нутаг руу эрх шилжих учиртай. Хүн эрхтэй байж л хөгжинө. Хүмүүсийн өмнөөс төр засаг нь, удирдагч нар нь, Ерөнхийлөгч нь боддог оронд бол хүний хөгжлийн тухай асуудал байхгүй” хэмээн Ерөнхийлөгч тэмдэглэв.

Монголын эдийн засгийн форумын хүрээнд “Хүний хөгжил”, “Хөгжлийн бодлого”, “Засаглал”, “Дэд бүтэц” гэсэн дөрвөн гол сэдвээр 15 салбар хуралдаан өрнөсөн юм. Бүх хэлэлцүүлэг монгол хүнд, тодруулбал монгол хүний сурч боловсрох, ажиллах, амьдрах сайхан орчныг хэрхэн бүрдүүлэхэд чиглэж байлаа. “Чуулганаас гарсан шийдлүүдийг Засгийн газар шийдвэр гаргахдаа тусган ажиллана” хэмээн С.Батболд амласан.

Байгалийн баялгаа ашиглан хүний баялгаа хөгжүүлэх нь төр, засгийн бодлого болох хүлээлт нэгэнт бий боллоо. “Монгол Давос”-ын энэхүү шинэлэг санааг “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон олзуурхан дэмжиж, энэ дугаартаа “Ядуурал буурсан уу, үгүй юу”, “Нүүрээ угаая”, “Хүн чанар ажилд авна”, “Уул уурхайн орлогоороо урлаг соёлоо услая” зэрэг нийтлэлийг оруулсан бөлгөө. Хүний хөгжил-хүнд өгөөжтэй өсөлт цаашдаа ч манай сэтгүүлийн байнгын сэдэв байх болно.

“Хүн чанар” ажилд авна

Д.Мөнхчимэг

“Ажилд урьж байна”, “Vacancy notice”... Ийм гарчиг өдөр тутмын сонинуудын нийт сурталчилгааны талаас илүү хувийг эзэлж байгааг анзаарсан уу? Үүний зэрэгцээ зурагтаар, радиооор, интернэтээр ажилд авах зар хөвөрсөөр. Олон улсын байгууллагуудаас эхлээд барилга, банк, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, мэдээлэл технологийн компаниуд ажиллах хүчний эрэлд хэчнээн их цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулж байна вэ? Хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн хувьд гол орлого нь болоод буй “Ажилд шалгаруулж авна” гэсэн заруудыг уншаад үзэхнээ захирлаас эхлээд засварчин хүртэл эрэлт хэрэгцээтэй байна. Хаа сайгүй ажилтан хайж байна. Гэтэл ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэхгүй байгаа нь гайхалтай бус уу?

Үндэсний статистикийн хорооноос мэдээлж буйгаар эдүгээ Монголд 106.1 мянган хүн ажил эрхлээгүй байгаа бөгөөд ажилгүйдлийн түвшин 9.4 хувьтай байна. Ажил идэвхтэй хайж байгаа хүний тоо энэ оны хоёрдугаар сарын эцэст 38.5 мянгад хүрсэн нь жилийн өмнөхөөсөө 7.1 хувиар өссөн үзүүлэлт гэнэ. Бүр ч хачирхалтай. Нэг нь ажилтан хайгаад байдаг, нөгөөх нь ажлын байр эрээд байдаг. Тэгсэн хэрнээ ажилгүйдлийн түвшин буурч өгдөггүй. “Албан бичиг боловсруулах чадвартай, англи хэлний өндөр мэдлэгтэй, ачаалал даах чадвартай, мэргэжлээрээ хоёроос дээш жил ажилласан” гэдэг нь “Ажилд шалгаруулж авна” гэсэн заруудын гол түлхүүр үгс. Уг нь хэрээс хэтэрсэн шаардлага биш л юм шиг санагдана. Даанч ийм чадвартай хүн олдохгүй байна хэмээн ажил олгогч эзэд гомдоллох ажээ.

2010-2011 оны хичээлийн жилд төрийн болон хувийн өмчийн нийт 113 их, дээд сургуульд 170 гаруй мянган оюутан сурч байна. Гэтэл дээд сургууль төгсөгчдийн ердөө 40 хувь нь ажлын байртай золгодог гэх статистик бий. Өөрөөр хэлбэл, энэ онд шинэхэн димплом өвөртөлсөн 100 гаруй мянган хүн ажилгүйдлийн эгнээнд орох нь. Дээд боловсролтой хүмүүст яагаад ажлын байр олдохгүй байна вэ? “Монголын их дээд сургуулиуд оюутнуудаа сургаж чадахгүй байна. Нэг их мундаг диплом харуулсан хүн ирчихээд л, албан бичиг ч боловсруулж мэдэхгүй байна шүү дээ. Тиймээс захирлууд шинээр авсан ажилчдаа эхнээс нь сургаж, цаг, мөнгө зарцуулж байна” хэмээн ажил олгогч эзэд учирлах аж. Эндээс их, дээд сургуулиуд яагаад оюутнуудаа сайн сургахгүй байна вэ гэдэг асуулт гарч ирнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр “АНУ-д дээд боловсрол эзэмшихэд 30 орчим мянган ам.доллар, Хятадад 3-5 мянган ам.доллар байхад Монголд 800-900 мянган төгрөг төлөөд л их сургуульд суралцаж байна шүү дээ. Өнөөдөр сургуулиуд төлбөрөөрөө л амьдарч байгаа. Нэгэнт сургалтын төлбөр нэмэхийг төрөөс хязгаарладаг учраас сургуулиуд чанар биш, тоо харж байна” хэмээн Монголын эдийн засгийн форумын үеэр онцолсон юм. “Манай сургуульд төсвөөс




ердөө 6.8 хувийн санхүүжилт ирдэг. Үлдсэнийг нь бид оюутны төлбөрөөс л гаргаж байгаа. Гэтэл орлогын 70 хувь нь зөвхөн багш нарын цалинд явчихдаг. Сургалтын орчин, тоноглолоо сайжруулахад ямар ч хөрөнгө оруулалт хийж чадахгүй байна. Энэ чигээрээ явах юм бол бид дэлхийн түвшинд хүрэх биш, одоогийнхоос ч дордоно” гэж МУИС-ийн захирал С.Төмөр-Очир тэмдэглэв. Тэрбээр цааш хэлэхдээ “Оюутнуудын 70 хувь нь их, дээд сургууль, 30 хувь нь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж байна. Гэтэл ажлын байр гэхээр яг эсрэгээрээ дүр зураг гарч ирдэг” хэмээн онцоллоо.

Хүний хөгжил, хөдөлмөрийн зах зээл энэ жилийн Монголын эдийн засгийн форумын нэгэн чухал сэдэв болсон билээ. Гэвч бид энэ сэдвийг хөндөхдөө мэргэжилтэй ажилчдын сургалтын тал дээр анхаарахгүй өнгөрч боломгүй.

2010-2011 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсрол, сургалтын 63 байгууллагад 46 мянган хүн суралцаж байна гэсэн мэдээ бий. Жилдээ 15 мянга орчим хүн төгсөж байгаагийн 70 гаруй хувь ажлын байртай болдог аж. “Нэг үе мэргэжилтэй ажилчид гээгдэж байсан. Одоо түүхийн шинэ хуудас нээгдэж байна” хэмээн Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд Ч.Куланда онцлов. Үйлдвэрлэл-Урлалын сургуулийн захирал Ж.Юра “Энэ бол мэргэжлийн сургалт хамгийн оргил цэгтээ хүрч байсан 1991 оныхоос ч давж, рекорд эвдсэн үзүүлэлт. Гэхдээ ажил эрхлэлтийн түвшин бага байгааг анхаарах хэрэгтэй” хэмээв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд Д.Нямхүү “Хөдөлмөрийн зах зээлд зохицуулалт алга. Уул уурхайн салбарт хүн хэрэгтэй байхад хөдөө аж ахуйн чиглэлээр хэтэрхий олон мэргэжилтэн бэлдчихэж байх жишээтэй. Ийм байхад НХХЯ тэр хүмүүсийг нь ажилд зуучилж чадахгүй байна шүү дээ. Бидэнд хөдөлмөрийн зах зээлийн судалгааны байгууллага хэрэгтэй байна. Мэргэжилтнүүдийн сургалтыг ажил олгогч эздийн захиалгатай нийцүүлэх ёстой. Ер нь энэ бүх асуудлыг нэг гарт нэгтгэвэл яасан юм бэ?” гэсэн санал дэвшүүлсэн



юм.

Үнэхээр хөдөлмөрийн зах зээлд бодлого, зохицуулалт үгүйлэгдэж байгааг Монголын эдийн засгийн форумын хүрээнд зохион байгуулагдсан “Мэргэжлийн боловсрол, эдийн засгийн өсөлт” салбар хуралдааны үеэр өрнөсөн хэлэлцүүлэг гэрчлэв. “Өнөөдөр Монголд хэдэн гагнуурчин хэрэгтэй байна вэ? Хэдэн хүнийг энэ чиглэлээр бэлдэж байгаа вэ? Ер нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаар тодорхой судалгаа, тоо баримт байна уу?” гэсэн асуултад хэн ч тодорхой хариулт өгсөнгүй. БСШУЯ баахан мэргэжилтэн бэлдээд байдаг, гэтэл НХХЯ тэднийг нь ажилд зуучилж дийлдэггүй. “Яамд, төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байна. Өнөөдөр бид гурван байшингийн хооронд ажлаа уяж чадахгүй байгаа бол хөгжлийн тухай ярихад хэцүү” хэмээн УИХ-ын гишүүн Д.Оюунхорол дүгнэв. Нэг нь ажилтан хайгаад, нөгөөх нь ажлын байр эрээд байгаа ч хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэхгүй байгаагийн гол шалтгаан энэ байж болох. Өөрөөр хэлбэл, ажил олгогч эздэд хэрэгтэй мэргэжилтэн ховор, хэрэггүй нь олон байна. Үүний хажуугаар монголчууд ажилдаа сэтгэлээсээ ханддаггүй гэх шүүмжлэл ч гарч байлаа. “Мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүдээс нэг барилга дээр 38 хүн ажилд авлаа гэхэд жилийн дараа хоёр нь л тунаж үлдэж байна” хэмээн “Атимос” группийн ерөнхий захирал Я.Батцэцэг тэмдэглэв. Ингээд л мөнөөх ур чадвар, сургалтын чанарын асуудал дахиад хөндөгдөх нь тэр.

“Ур чадварын тухай ярихаа больё. Бид өөрсдөө хүнээ сургаад авч чадна. Гэтэл хүн чанартай хүн олдохгүй байна шүү дээ. Монголчуудын ихэнх нь архи ууна, ажлаа тасална. Хулгай хийгээд алга болох явдал ч гардаг” хэмээн зарим компанийн захирал бухимдах аж. “Би монгол ажилчдыг архичин, хулгайчаар нь дуудуулмааргүй байна. Цалинг нь олигтой өгөхгүй, хугацаанд нь тавихгүй, барилгын талбайд ажиллах ахуйн нөхцөлийг нь бүрдүүлж өгөхгүй байснаас барилгын материалаа хулгайлах, зөөх тохиолдол байсан л байх. Гэхдээ тасралтгүй их ажлаар хангаад, цалин мөнгө өгөөд байвал монголчууд бүгд архидаад байна гэж юу байх вэ дээ” гэж Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч М.Батбаатар ярьж байсан билээ.

“Оюутолгой” компанийн ерөнхийлөгч Камерон МакРэй “Монголын хамгийн том баялаг ашигт малтмал биш, хүний баялаг юм” хэмээн тэмдэглэж байв. Тиймээс бид хүний баялгаа хэрхэн эдийн засгийн эргэлтэд оруулах вэ, яаж монгол ажилчдыг ур чадвартай, хамгийн гол нь “хүн чанар”-тай болгох вэ гэдэг сорилтын өмнө

нүүр тулаад байх шиг.

Америкийн эрдэмтэн Роберт Ректорын хийсэн нэгэн сонирхолтой судалгаа бий. Хүний хэрэгцээг эрэмбэлвээс таван үе бүхий гурвалжин байдгийн доод сууринд нь физиологийн анхдагч шаардлага оршдог аж. Хоол, хүнсний гачигдалд орсон хүний дараа, дараагийн хэрэгцээ үхжиж, “хүн хүнээ алддаг” байна. Юун боловсрол, юун соёл, ийм хүний хувьд гол зогоох хоол нь л чухал. Тиймээс “өлсгөлөн” хүн юу ч хийхээс буцахаа байж, эдийн бус, араншны ядууралд өртдөг гэнэ. “Араншны ядуурал нь арчаагүй байдал, ажлын ёс зүйн доройтол, мэдэж, сурах тэмүүллийн хомсдол, гэмт хэрэг, архины дон зэрэг нийгмийн гажгуудын багц юм” гэж Роберт Ректор тайлбарлажээ.

Тэгвэл Монголд араншны ядуурал газар авсныг мэдэж цөхөх юмгүй. Ажлын байр байсаар байтал ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь нийгмийн тогтолцоо нэг л биш болсныг илтгэх буюу. Монголд ажилгүйдэл гаарч байхад гаднаас ажиллах хүч оруулж ирээд байгаа нь бас л нэгийг өгүүлнэ. Эдүгээ энгийн монгол хүний сарын дундаж цалин 300 мянган төгрөг байна. Нэг цагийн хөдөлмөрийн хөлс 1875 орчим төгрөг гэсэн үг. Үүнээс мөн татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлнө гээд бод доо! Бүтэн цаг ажиллаж олсон мөнгөөрөө хоёр ширхэг талх ч авч чадахгүй байгаа болохоор монголчууд залхуу болчихсон байж магадгүй. Өглөөнөөс үдэш хүртэл ажиллачихаад, цалингаас цалингийн хооронд өл залгуулан амьдрахын оронд гэртээ зурагт үзээд хэвтэх нь зарим хүний хувьд дээр байгаа бололтой.

“Энэ бүх асуудлыг шийдвэрлэхийн тулд хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх хэрэгтэй. Өнөөдөр Монголын бараа, бүтээгдэхүүний үнэ хөгжингүй орнуудынхтай адил өндөр байна шүү дээ. Гэтэл цалин ямар байгаа билээ? Монголчууд үнэхээр тийм ур чадваргүй байна гэж үү? Тэгвэл яагаад Солонгост очоод сайн ажиллаад, Монголд болохоор тэгж чаддаггүй юм бэ? Миний бодлоор монголчуудын ур чадварт биш, цалин урамшуулалд учир их байна” хэмээн “Их засаг” их сургуулийн захирал Н.Ням-Осор учирлалаа.

Өнөөдөр БНСУ-д 30 гаруй мянган монгол хүн ажиллаж байна. Манай Гадаадад ажиллах хүч илгээх төв өнгөрсөн онд тус улсад гэрээгээр хөдөлмөр эрхлэх сонирхолтой 14600 хүнийг бүртгэж, 3000 гаруйг нь зуучилжээ. Харин үлдсэн 11 мянган монгол нь сэтгэлээр унаж, гудамжаар лааз өшиглөн алхаж байж мэднэ. Ийнхүү монголчууд залхуу, чадваргүйгээрээ цоллуулж, цалинтай золгож амжихгүй явах зуур эх оронд нь гадаад ажилчны тоо нэмэгдсээр. 2002 онд оруулж ирсэн 458 хятад ажилчны тоо 2010 онд 10 мянгаас давсан байгааг сануулах юун. Засгийн газар энэ оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” хэмээн зарласан. Энэ хүрээнд улсын хэмжээнд 60 мянгаас багагүй тооны ажлын байр бий болгох бодлогыг НХХЯ боловсруулаад буй. Харин хөдөлмөрийн зах зээлд бий болсон хачин жигтэй дүр зургийг хэрхэн залруулах талаар бодсон, төлөвлөсөн юм байгаа болов уу? Дээр дурдсан бүх асуудлыг Монголын эдийн засгийн форумын үеэр хэлэлцсэн билээ. “Чуулганаас гарсан шийдлүүдийг Засгийн газар шийдвэр гаргахдаа тусган ажиллана” хэмээн Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд амласан. Түүний үг бат оршиж, төр, засаг хөдөлмөрийн зах зээлийг тодорхой бодлогоор цэгцлэхийг ажил олгогч эзэд, ажилчид хийгээд ажилгүйчүүд хүлээж буй за.



Мөнгө

Халуун мөнгө

Монголбанкны тэргүүн дэд захирал Б.Жавхлан Эдийн засгийн форумын үеэр “Макро эдийн засгийн эрсдэл” сэдвийг хөндөх үед “Хямрал дуусдаггүй юм байна. Хямрал сорилтоор үргэлжилдэг юм байна” хэмээн онцлоод, “Монгол Улсад орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт 520.4 сая ам. доллар болж, өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өссөн. Энэ валютын урсгалын 40 хувь нь богино хугацаанд ашиг олох гэсэн хөрөнгө оруулалт байна” гэж тэмдэглэсэн.

Энэ нь Монголын гадаадын хөрөнгө оруулагчдад ямар эрсдэл байгаа болон дотоодын макро эдийн засагт гадаадын хөрөнгө оруулагчид ямар эрсдэл учруулж байгааг ярих хэрэгтэйг сан уулсан. Энэхүү халуун мөнгө нь эцсийн бүтээгдэхүүн бий болгосон, жижиг, дунд үйлдвэрийг дэмжсэн, ажлын байр бий болгосон эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, сөрөх чадварыг дээшлүүлсэн байна уу. Эсвэл дунд, богино хугацааны ашиг хайсан хөрөнгө оруулалт уу? Үүнийг ялган салгаж, түүнд зориулсан бодлогын арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай юм. Богино хугацаанд их ашиг олох гэсэн гадаадын хөрөнгө оруулагчдын мөнгөний урсгалыг “хот мани” буюу “халуун мөнгө” гэж нэрлэдэг.

2010 онд төгрөгийн ханш ам.долларын эсрэг 17 хувиар чангарсан нь хувийн хэвшилд том дарамт учруулж буй. Өнгөрсөн онд зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн тогтвортой байдлыг хангахын тулд 180 тэрбум төгрөг буюу 140 сая ам.доллар зарцуулсан тухай Б.Жавхлан дурдсан. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах нь Төвбанкны гол зорилго гэдгээ ч тэрбээр хэлсэн.

“Ethical investment fund” компанийн эдийн засагч Жеймс Тайер “Монголын мөнгөний ханшийн өсөлт, хөрөнгийн биржийн үр ашигтай байдал нь хэдийгээр эдийн засгийн тодорхой амжилт боловч эцэст нь олон зүйлээр хохирч магадгүй” хэмээн зовниж буйгаа онцолсон. Хүүгийн зөрүүнээс ашиг олох гэсэн тоглолтыг “Халуун мөнгө” гэх бөгөөд энэ нь орж ирсэн шигээ амархан гараад явчихдаг, үр дүнд нь санхүүгийн тогтворгүй байдал үүсдэг тухай “Wikipedia”-д тайлбарлажээ. Тэгвэл Монголд энэ урсгал ороод

ирчихсэн байгааг гэрчлэх зүйл олон.

“Халуун мөнгө”-ний урсгал манай хөрөнгийн зах зээлд ч нүүрлэсэн гэдгийг ажиглахад хялбар. 2010 онд шинээр нээсэн дансны ихэнх нь гадаадын иргэд, аж ахуйн нэгжүүдэд харъяалагдаж байсныг Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгалмжийн төв тайландаа дурдсан байна. Өнгөрсөн оноос манай компаниудын үнэлгээ байж боломгүйгээр тэнгэрт хадаад, одоо шалдаа бууж эхлээд байгаагийн шалтгаан энэ ч байж болно. Өөрөөр хэлбэл, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны ханш ид шидээр өсөөгүй.

Хаана ашиг их гарч болохыг отоод сууж байсан хөрөнгө оруулагчид манай хөрөнгийн зах зээлд “халуун мөнгө” цутгаж, ашиг олчихоод эргээд гарч явж байна.

Монгол Улсын гадаад валютын нөөц 2.4 тэрбум ам.долларт дөхөж очжээ. Засгийн газар энэ мөнгөнөөс зарцуулах хүсэлтэй байгаа ч илүү урт хугацааны, тогтвортой болтол нь хав дарж, хашир байх байр суурийг Төвбанк баримталж байгааг Б.Жавхлан онцолсон. “2014 оноос уул уурхайн томоохон төслүүдийн үйл ажиллагаа жигдрээд ирэхээр бид айх хэрэггүй болно. Учир нь, тэр үед халуун мөнгө биш, жинхэнэ мөнгө орж ирэх юм” хэмээн тэрбээр тайлбарласан юм.

Монголбанк долоо хоногт хоёр удаа гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулдаг бөгөөд сүүлийн үед энэ нь зах зээлд илүүдээд буй ам.долларыг татан авч, төгрөгийн ханшийг тогтворжуулах гол хэрэгсэл болсон нь нууц биш ээ. Гэхдээ Төвбанк энэ янзаараа “халуун мөнгө”-ний урсгалыг хазаарлаж чадна гэдэгт эргэлзэх хүн цөөнгүй байна.

Эдийн засгаараа дэлхийд тэргүүлэх Япон, Хятад зэрэг орон үндэсний мөнгөн тэмдэгтийнхээ ханшийг сул байлгах гээд ядаж буй нь гайхал төрүүлнэ.

Манай улс шиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, ийм механизм боловсронгуй болоогүй орнуудад валютын ханшийн талаар судалгаа хийж, сургалт явуулдаг ТСХ сангийн тэргүүн дэд ерөнхийлөгч Харальд Хиршофер валютын ханшийн эрсдэлийн талаар сайтар тооцоолж байхыг анхааруулсан юм.

Эдийн засаг



Хөдөө ба хотын хөгжил

Малчин Доржынх сумын төвийн айл болсон нь

Д.Бэхээ

Доржынх амьдралаа залгуулахуйц малтай товхийсэн амьжиргаатай хөдөөгийн залуучуудын үлгэр жишээ болохуйц айлын нэг байв. Харин 2009 оны зуднаар хэдэн малаа алдаж, хотоо харлуулсан гашуун амдралыг туулж, аргагүйн эрхэнд сумын төвийн айл болсон юм. Эхнэр Цэцгээ нь 8-р ангиа төгсөөд л малчин болсон тул эзэмшсэн мэргэжилгүй бөгөөд хоёр бага насны хүүхдийн ээж. Удмын малчин Дорж сумын төвд орж ирснээр бүр ч хийх ажилгүй болж, хий гиюүрч, үеийн залуучуудтай архидаж, шоудсан хүмүүсийн нэг болох нь тэр. Ажил хийж амьжиргаагаа залгуулъя гэсэн ч ажил үл олдоно. Харин архи элбэгхэн олдох тул энэ идээнээс хөдөөгийн залуус татгалзахгүй нь ойлгомжтой. Үнэндээ бол сумын төвөөр нэг ажилгүй залуучууд хөлхөлдөж, бизнесийн сэтгэлгээтэй нэгэн нь кафе баар нэрээр архи голдуу зарж хөөрхөн мөнгө олчихно. Ажилгүй залуусын бөөгнөрөл болсон сумын төвийнхөн улстөржиж, намчирхаж, намын харьяалалд хуваагдан хоорондоо үзэж тарах нь энгийн үзэгдэл. Харин төрийн байгууллагуудын үүд хаалга хүч чадал муутай онгойж хаагдах нь улсын ажил хэр явааг илтгэх мэт. Сумын төвийн энэ эл хульхан өдөр хоногийг өнгөрөөсөн мэт амьдрал олон иргэнээ хот руу нүүлгэхэд

хүргэсэн. Чадал, бэл бэнчинтэй, ах дүү арал садантай нь төв суурин газар бараадаж, ихэнхдээ нийслэлийн айл өрхийн тоог нэмсэн байгаа. Сургууль эмнэлгийн үйлчилгээ муу, хийх ч ажил олдохгүй, хөдөөгийн суманд залуус суурьшихыг хүсэхгүй нь мэдээж.

Сүүлийн жилүүдэд төрөөс хөдөө, орон нутгийг гэрэл цахилгаанаар хангаж, дэд бүтцийг хөгжүүлэхийг хичээж байгаа ч сайн үр дүн өгөхгүй байгаа нь харагдана. Нэгэнтээ хөдөөгийн сумдад эрчим хүч хүргэсэн л юм бол жижиг, дунд, бичил бизнесийг хөгжүүлэхэд төр, засгаас дорвитойхон шиг анхаарч дэмжээд өгөх шаардлагатай байгааг нутгийн иргэд ярьдаг. Төрийн мэргэн бодлого хөдөөд үгүйлэгдэж байна гэж Монголын эдийн засгийн чуулганы үеэр ярилцсан. УИХ-ын гишүүн Д.Одхүү манай улсад ирээдүйн хөгжлийн тодорхой стратеги байдаггүй, асуудлыг тойроод л яваад байдаг тухай онцолж байлаа. Мөн манай өнөөгийн аймаг, сумдын, багын засаг захиргааны бүтэц Монгол Улсын ирээдүйн хөгжлийн загварчлалд тохирохгүй байгааг судлаачид тэмдэглэсэн. Тухайлбал, цөөхөн хүн амтай олон сум бий. Тэгэхээр хаана ямар хатуу болон зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэх концепци гаргаж, хүн рүүгээ чиглэсэн хөгжлийг бий болгоочээ гэсэн асуудал Монголын эдийн засгийн чуулганы Орон нутгийн хөгжил салбар хуралдааны гол сэдэв болж өрнөсөн юм. 200-хан хүнтэй сум руу 200 кВт-ын эрчим хүчний шугам татаж байна шүү дээ гэсэн үг ч УИХ-ын гишүүний амнаас унасан бол хөдөөгийн сумдад бүтээн байгуулалт өрнөлөө гэхээр бөхийн өргөө, соёлын төв мэтийн барилга л босох юм гэсэн асуудал ч яригдсан. Өөрөөр хэлбэл, 20 жилийн дараа энэ сум оршин тогтносоор байх уу гэдэгт анхаарал хандуулж, судалгаа дүгнэлт хийх замаар Монгол Улсын, бүсчилсэн хөгжлийн, орон нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж гаргаж



тавих асуудал нэн чухал болохыг чуулганы төлөөлөгчид дуу нэгтэй зөвшөөрсөн. 80 жилийн өмнө Монгол Улсыг түүхий эдийн бааз болгохын тулд 365 суманд хуваасан шүү дээ. Одоо мэдлэгт тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэхээр л зорьж буй юм бол УИХ-ын гишүүд нь жалга довны улстөржсөн байдлаасаа салж, шинэ эриний шинэ бодлогоор хөгжих цаг ирснийг иргэдийн төлөөлөл хэлж байсныг энд онцлон тэмдэглэе.

Доржын хотын айл болсон нь

Малгүй, ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн малчин Дорж сумын төвийн баргар амьдралд удаан тэсэлгүй, тэсэлгүй ч гэж дээ, эхнэр хүүхдүүдээ тэжээхийн эрхэнд төв суурин газрыг бараадахаар нэгэн хаврын уйтай өдөр Улаанбаатарын зүг жолоо залав. Өндөр гоёмсог барилгууд сүндэрлэсэн нийслэл хотын сүр дарханд хөдөөх уулын мухарт өссөн бор хүү сүрдэхийн зэрэгцээ Улаанбаатар хотын дээгүүр суунаглан униартах утаат хот хөдөөгийн цэвэр цэнгэг агаарт цээж дүүрэн амьсгалж өссөн малчин Доржийг ийн тосож авсан юм. Их хотын маань баялагт хахаж цацаж, цээжээ хорсгосон Дорж нийслэлийн иргэн болох амаргүй даваатай нүүр учирч, Хайлааст дахь уулын нөмөрт хашаа хатгаж, бор гэрээ барьж авснаар түм түжигнэж, бум бужигнасан их хотын аясыг дагаж эхэллээ. Хамаатныхаа эгчийн туслалцаатайгаар хүнсний нэгэн захад ажилд орж, эхнэрээ ч бас таарсан ажилд оруулав. Үзэж харах, зугаалах зүйл олонтой ч Улаанбаатар гэж их айлд олон хүндрэлтэй асуудал байдгийг Дорж удалгүй олж мэдсэн юм. Тоо томшгүй олон сайхан машинтай хэрнээ зам харгуй нь их муу юм. Тэгээд энэ их түгжрэл дунд улаанбаатарчууд яаж явж ажлаа амжуулдаг юм бол гэсэн бодол төрөх. Хүнсний дэлгүүр, захын лангуун дээр шүлс асгаруулам харагдах олон зүйлс хүний эрүүл мэндэд хэр нөлөө үзүүлдэг юм бол. Зарим хүн урд хөршөөс орж ирсэн жимс ногоонд химийн найрлага ямар нэг хэмжээгээр байгаа гэх. Хүнсний ногоонууд, жимс, бүр сүү таргаа хүртэл Хятадаас авч байгаад манай малчин ихэд гайхлаа. За тэгээд гэр хороололд нийслэлчүүдийн ихэнх

хувь нь амьдардаг юм байна. Нэлээд бохир заваандуу, хог шороотойгоо хутгалдах байдал гэр хорооллоос харагдах. Хотын төвдөө болохоор газар их үнэтэй гэж сонссон. Үнэхээр ч сул газар үлдээлгүй л байшин барилга шавааралдуулан барьсан нь хотын үзэмжинд тааруу л харагдах. Гэлээ ч хүн өөрөө өөрийгөө хөгжүүлж, амьдрах арга ухаанд суралцаж, хөдөлмөрлөж хүүхдүүддээ сайн боловсрол эзэмшүүлж, сайхан амьдрах боломж хотод үнэхээр байдгийг Дорж илүүтэй олж харсан юм.

Та бүхэн хотын амьдралыг ямраар төсөөлж байна гэж Улаанбаатар хотын орлогч дарга Да.Ганболд Монголын эдийн засгийн чуулганы үеэр төлөөлөгчдөөс асуугаад Улаанбаатар орчин үеийн хот биш юм. Хүн амын гуравны хоёр хувь нь хөдөөгийн суманд ямар байсан тэр чигээрээ л хотод амьдарч байна. Хот бол цахилгаан дулаан, шугам сүлжээ, бохир ус, нийтийн тээвэр, хогны менежментийг бүрэн шийдсэн байх ёстой. Тэгвэл манайд эдгээр салбар зах зээлийн харилцаанд ороогүй байна шүү хэмээн учирласан. Гэр хороолол хөгжил авчирдаггүй юм гэж ч олон хүн хэлэв. Амьдралын дорой түвшинтэй хүмүүс хотын хөгжлийг чангаагаад байна. Долоо хоногт 700 гаруй хүн хотын иргэн болж байна. Орон сууцанд орж буй айлын тоог хөдөөнөөс нүүн ирж буй айл өрхийн тоотой харьцуулбал гурав дахин их байна. Тиймээс Улаанбаатар хотын бондыг гаргах замаар мөнгөний асуудлыг шийдье. Нийслэлийн бондыг хүмүүс худалдаж авна шүү дээ. Хотын иргэнээс татвар авъя. Хотынхоо төвдөө өндөр үнэтэй, зах руугаа үнэ багатай байлгах бүтцэд шилжье. Хөгжилд төлөвлөлт хэрэгтэй. Төлөвлөлтөд мөнгө зарахгүй байна. Уурын зуухны янданд амьдарч буй хүмүүс хөгжлийн тухай хэрхэн ярих вэ. Улаанбаатар хотын стратегийн хөгжлийн концепцийг гаргая гэсэн асуудал Монголын эдийн засгийн чуулганы Хотын хөгжил салбар хуралдаанаар яригдсан. Тоймолбол, улаанбаатарчуудын өмнө нэгдүгээрт, агаарын бохирдол' хоёрдугаарт, эрүүл мэнд' гуравдугаарт аюулгүй амьдрах гэсэн хамгийн түрүүнд шийдэх асуудлууд байгааг эрдэмтэн судлаач, мөн олон улсын байгууллагын хүмүүс онцолж байлаа.

Хөгжлийн түншүүдийн зөвлөгөө

Нүүрээ угаая

Манай улсын хөгжлийн түнш орнуудын төлөөлөгчид энэ үгийг Монголын улстөрчдөд хандан хэлсэн юм. Төв Азийн өндөрлөгт орших өргөн уудам газар нутагтай Монгол хэмээх улсад хурдацтай хөгжин дэвших асар их боломж бололцоо гарч ирж байгаа бөгөөд гагцхүү тэр нөөц боломжийг ашиглаж чадах эсэх нь төрийг жолоодож буй улстөрчдийн гарт байгааг тэд онцлон тэмдэглэлээ. Эдийн засгийн өндөр өсөлт харагдаж байна, удахгүй бидний төсөөлснөөс их мөнгө орж ирнэ, ард иргэд минь баяжина хэмээн хөөрцөглөн явахаасаа өмнө тэрхүү өндөр өсөлтийг зөв зохицуулж, иргэдээ, улсаа баяжуулах үнэнхүү хүсэл эрмэлзлэлтэй бол өөрсдөө эхлээд нүүрээ сайтар савандаж угаах ёстойг хөгжлийн түншүүд анхааруулсан билээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс ангал руу унах уу,

аврагдах уу гэсэн хоёр сонголтын өмнө ирээд байгаа энэ үед улстөрчид амаргүй шийдвэрүүдийг зоригтой шийдэж, эдийн засгийн шинэтгэлийг эхлүүлэх хэрэгтэй хэмээн хэлсэн юм. 2012 оны сонгуулийн чимээ ойртсон энэ үед УИХ-ын гишүүд өөр өөрийн тойрогтоо ахиухан мөнгө хуваарилуулах санаа өвөртлөхгүйгээр асуудалд улс орныхоо эрх ашгийг тэргүүнд тавьж хандвал хөгжил аяндаа ирнэ гэдгийг ч тэд анхаарууллаа.

Уул уурхай уу хошуурахаасаа илүүтэй хүнийхээ хөгжил, нийгмийн хамгаалал, нэмүү өртгийг бий болгох, ядуурлыг бууруулах, санхүүгийн шинэ бүтцийг зөв хөгжүүлэх, боловсролын стандартыг сайжруулах, усны хангамж, хүнсний аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн даатгал, ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуучууд руугаа хандсан төсвийн бодлого явуулах,

Эдийн засаг

төрийн чанартай үйлчилгээг иргэдэд хүргэх талд голлон ажиллахыг түншүүд зөвөллөө. Эдийн засгийн өсөлтийг зөв зохицуулж чадахгүйгээс ядуурал дорвитой буурахгүй байна гэж ч үзсэн. Уул уурхайн асуудлаа түлхүү яриад байгаль орчны асуудлыг орхигдуулаад байгаа нь алсдаа аюул дагуулах вий гэсэн шүүмжлэл Засгийн газар, хөгжлийн түншүүдийн хамтарсан техникийн уулзалтын үеэр яригдсан юм.

20 дахь жилдээ болж буй энэ уулзалтын уур амьсгалыг товчлон хүргэвэл хөгжлийн гараан дээр ирээд байгаа шинэ Монгол Улстай хөгжлийн түнш орнууд харилцаагаа эргэн харж, шинэ нөхцөл байдалд хэрхэн харилцах хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаараа бодох цаг иржээ хэмээн Дэлхийн банкны Монгол, Хятад, Солонгос улсыг хариуцсан захирал Клаус Роланд тэмдэглэсэн. Харин манай улсын зүгээс ч уул уурхайн томоохон төслүүд хэрэгжүүлэх, мөн санхүүгийн шинэ механизмын үндэс суурийг зөв бат бэх тавихад хөгжлийн түншүүдээс зөвөлгөө авч хамтарч ажиллах санал тавьж байна.

“Монгол Улсын эдийн засгийг шинэ шатанд гаргахад олон жил хамтарч ажилласан түншүүддээ их баярлалаа. Өнөөдөр манай улсын өмнө хөгжих боломж их байна. Мөн шинэ сорилтуудтай ч тулгарч байна. Энэ бүхэнд түншүүд маань зөвөлгөө өгч, туршлагаасаа хуваалцаж ажиллах шинэ үүрэг та бүхэнд ногдож байна” гэж Сангийн сайд Ц.Баярцогт хэлсэн юм. Тэрбээр энэхүү уулзалт дээр “Монгол Улсын Засгийн газрын өмнө бүрдээд буй шинэ нөхцөл байдал, санхүүгийн шинэ механизмуудын талаар ярьсан. Түүний илтгэлд дурьдсанаар амьжиргааны доод түвшин өсч, 2002 онд 24600 байсан бол 2010 онд 101600 болж, 4,1 дахин өссөн байна. Мөн манай улс

өмнө нь зөвхөн өндөр хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд хамтран ажилладаг байсан бол зээлжих зэрэглэл өссөнөөр санхүүгийн шинэ арга хэрэслүүдийг ашиглах боломжтой болжээ. Засгийн газар шаардлагатай дэд бүтцийг бий болгох, уул уурхай болон хот байгуулалт, орон сууцжуулах чиглэлээр томоохон төслүүдийг эхлүүлэхээр ажиллаж байгаа. Мөн шинэ хөрөнгө оруулалтыг татах, ажлын байр бий болгох, экспортын орлого, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн болон хөгжлийн зориулалтаар хөрөнгө оруулалт хийх, ядууралтай тэмцэх, нийгмийн бүтээмжийг сайжруулах чиглэлээр гадаад түншүүдтэй өргөн хүрээнд харилцах шаардлагатай байгаагаа дуулгасан юм. Ийнхүү манай улс хөгжлийн шинэ шат руу алхмаар ахисныг дээрх техникийн уулзалт харууллаа. Өөрөөр хэлбэл, монголчуудын хөрөнгө мөнгө хошуу цорвойн гуйдаг цаг ард үлдэж, түншүүдтэйгээ мөр зэрэгцэн хамтран ажиллаж, зөвлөгөө авч ажилладаг шинэ эрин эхэллээ гэсэн үг.



Банк

Санхүүгийн шинэ тоглогч Хөгжлийн банк

И.Отгонжаргал

Хөгжлийн банк санхүүгийн хүчтэй шинэ тоглогч гэдгээ харуулах нь тодорхой боллоо. 17.4 тэрбум төгрөгийг Хөгжлийн банкны гарааны мөнгө болгон Сангийн яамнаас Төвбанкинд байршуулсан тухай Эдийн засгийн форумын үеэр Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуяг тэмдэглэж байсан. Тэгвэл Засгийн газрын гуравдугаар сарын 16-ны лхагва гаригийн хуралдаанаар аар шийдвэрлэв. Санхүүгийнх нь эх үүсвэрийг бүрдүүлэхэд зориулж Монгол Улсын Хөгжлийн банкны 250 тэрбум төгрөгийн үнэт цаасыг таван жил, 250 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 10 жил, 300 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 15 жилийн хугацаатай дотоодын зах зээлд гаргахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Хашчулуунд, үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт Засгийн газрын баталгаа гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсөн


байна. Энэ талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар сэтгүүлчдэд мэдээлэл хийх үеэрээ “Хөгжлийн банкнаас гаргах бондоос төмөр болон авто зам, орон сууцны зээлийг санхүүжүүлнэ. Орон сууцны урт хугацааны зээлийн хүүг зургаан хувь болго гэсэн чиглэл өгсөн. Үүнтэй холбоотой авах арга хэмжээг дараагийн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэнэ” гэлээ.

Мөн Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж “Манай Засгийн газар хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд анх удаа ийм их хэмжээний бонд гарган оролцох гэж байна. Тиймээс ач холбогдол ихтэй, чухал шийдвэр. Засгийн газраас гаргах 800 тэрбум төгрөгийн бондын 300 орчим тэрбумыг нь орон сууцанд зориулах байх” хэмээв. Тэрбээр цааш нь хэлэхдээ “Хэдийгээр орон сууцжуулахыг дэмжиж байгаа ч орон сууцны бүх зээлийн

хүүг зургаан хувьд хүргэвэл бас л нөгөө халамжийг хавтгайруулсан шинжтэй арга хэмжээ болж хувирна. Тэгэхээр зээлийн хүүг ямар нөхцөлд зургаан хувьд хүргэх боломжтойг дахин тодруулах шаардлагатай” гэж нэмж тайлбарласан. Уг арга хэмжээг авахдаа мөнгөний бодлоготой уялдуулахыг холбогдох газруудад Засгийн газрын хуралдаанаас зөвлөмж болгожээ.

Бүтээн байгуулалтыг урт хугацаатай, бага хүүтэй зээлээр дэмжих Хөгжлийн банкныг олон нийт үзэхдээ сонгуулийн өмнөх жил босч байгаа том мөнгө. Хөрөнгийг нь харин зөв зүйлд зарцуулаасай. Хөрөнгийг нь мэдлэгт суурилсан эдийн засагт чиглүүлбэл илүү үр дүнтэй. Өнөөдрийнх шиг тендер санхүүжүүлж болохгүй хэмээн болгоомжтой хандаж байсан. Ийм бодол санал Эдийн засгийн форумын үеэр оролцогчдын зүгээс гарч байсныг тэмдэглэхэд илүүдэхгүй болов уу. Тэд мөн төсөв ийм их алдагдалтай байхад тус банкны эрсдэлийг нь тооцсон уу гэсэн асуултыг ч нэг бус удаа хурал удирдагчдаас асууж байсан. Төвбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан “Төсвийн ачааллыг тараах гэж Хөгжлийн банк байгуулж байгаа. Нөгөө талаас макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах зорилготой” гэж ярьсан. Харин бусад холбогдох албаныхан “Хөгжлийн банкны тухай хууль батлагдсан. Хуулинд бүх зүйлийг тодорхой тусгасан” гэсэн хариулт өгч байлаа. Одоо тэгвэл Хөгжлийн банкны тухай хуулийг сонирхоод үзье.

Хөгжлийн банкны тухай хуулийг 2011 оны хоёрдугаар сарын 10-нд баталжээ. Арилжааны банктай өрсөлдөхгүй, хөгжлийг түргэвчлэх зорилготой Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг долоон бүлэг, 29 заалт бүхий уг хуулинд нэлээд нарийн тусгажээ. Тухайлбал, Хөгжлийн банкныг Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий хуулиар заасан үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд байна гэж тодорхойлжээ. Тус банкныг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргаж, УИХ-д танилцуулна. Хөгжлийн банкны хөрөнгө нь улсын төсвөөс хуваарилсан өөрийн хөрөнгө болон хуульд заасан бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Түүнчлэн тус банкны зээл олгох байдал хүмүүсийн сонирхлын төвд буй. Санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ жил бүрийн хаврын чуулганаар батална. Зээл олгох шийдвэрийг Хөгжлийн банкны актив-пассивийн болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана гэж хуулийн 8.2-д заажээ. Хуулийг цааш нь сонирхоход, Хөгжлийн банкнаас олгох зээл нь арилжааны банкуудын зээлийн хүүгээс доогуур байх бөгөөд хөнгөлөлттэй нөхцөлтэй байхаар тусгасан байна. Харин санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт тавих шаардлага нь таван заалттай юм. Үүнд, Засгийн газрын баталсан Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах, Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, эсхүл олон улсын болон Европын холбооны стандартын шаардлагад нийцсэн экспортын болон импортыг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байна. Зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээл авах үндэслэл, төсөл, хөтөлбөрийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг олон улсад тогтсон мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх. Төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг тухайн зээл бүрэн төлөгдөж дуусах хүртэл зээлийн



барьцаа хөрөнгөд тооцно гэжээ. Үүнээс гадна хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын зөвшөөрснөөр дотоод, гадаад эх үүсвэрээс зээл авч болно гэж үргэлжилж байх жишээтэй.

Хуулийн 24.1, 24.2-д зээл, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн болон зээлийн баталгаа, батлан даалт, үнэт цаасны нийт дүнгийн нийлбэр нь тус бүр өөрийн хөрөнгийг 50 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна гэж тусгасан байна. Түүнчлэн Хөгжлийн банк нь дээрх заасан хязгаарлалтын хүрээнд дангаар болон бусадтай хамтран гуравдагч этгээдэд зээлийн баталгаа, батлан даалт гаргаж болно гэсэн өгүүлбэр харагдлаа.

Энэ их хөрөнгө мөнгөтэй банкны удирдлага, бүтэц ямар байх вэ гэдэг бас сонирхолтой. Хуулийн 19.2-д гүйцэтгэх удирдлагыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын дагуу сонгож, хувь нийлүүлэгчдийн хурлын зөвшөөрснөөр ТУЗ томилж, чөлөөлнө. Гүйцэтгэх удирдлагын 50-иас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байна гэж заажээ. Уг нь бол оны өмнө БНСУ-ын манай хөгжлийн банкны менежментийг авч явахаар шалгарсан. Зарим холбогдох албаныхан Хөгжлийн банкны тухай хуулийг баталсны дараа дээрх шалгаруулалтын асуудлыг эргэн авч үзнэ гэж хэлсэн удаатай. Энэ талаар одоогоор шинэ мэдээлэл сэтгүүлчдийн чихэнд дуулдаагүй байна. Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл есөн гишүүнтэй байх ба тэдгээрийн гурав нь хараат бус гишүүн байх аж. ТУЗ-ын хараат бус гурван гишүүнийг Монголбанк, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын банкны холбоо тус тус нэр дэвшүүлж Засгийн газар томилно. Хараат бус гурван гишүүн нь мэргэжлээрээ таваас доошгүй жил ажилласан, хоёроос доошгүй жилд нь эрх бүхий албан тушаал хашсан хийгээд төрийн улс төрийн, захиргааны, тусгай албан тушаал хашдаггүй байх шалгууртай. Хөгжлийн банкны ТУЗ-ын даргаар Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун ажилладаг. Банкны бүтцийн хувьд актив-пассивийн удирдлагын, зээлийн, эрсдэлийн удирдлагын, хяналтын болон захиргааны асуудал хариуцсан үндсэн нэгжтэй байх гэнэ.

Хөгжлийн банкны үйл ажиллагаа ийнхүү шуудрах талдаа орж байна. Засгийн газрын дараа дараагийн хуралдаанаар тус банкны 800 тэрбумын бондтой холбоотой хийх ажлууд улам илүү тодорхой болох биз ээ.

Уул уурхайн орлогоороо урлаг соёлоо услая

Д.Мөнхчимэг

“Тоглоомын түүх III” хүүхэлдэйн киноны орлого тэрбум ам.долларт хүрсэн гэнэ. Канадын “Royal Tyrrell Museum” палеонтологийн музей өнгөрсөн онд 10 сая дахь үзэгчээ хүлээж авчээ. Урлаг соёлын салбар эдийн засгийн ямар их үр өгөөжтэйг харуулах энэ мэт мэдээлэл хөвөрч байх зуур монголчууд уул уурхай даган урсан орж ирж буй мөнгөө хэрхэн зарцуулах тухай ярилцах аж. Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Н.Жанцанноров гуай “Эрдэс баялгийн орлогоосоо соёл урлагаа хөгжүүлэхэд зарцуулъя. Монголд дэлхийд үнэлэгдэхүйц уран бүтээлчид бий. Өндөр хөгжилтэй орнуудад төрсөн бол дороо нэрд гарчихаар хүмүүс байна. Гагцхүү монгол хүний оюуны чадавхийг дэлхийн тавцанд гаргахын тулд хүний хөгжилд анхаарах цаг нэгэнт иржээ” хэмээн Монголын эдийн засгийн форумын үеэр тэмдэглэсэн юм.

Төрийн ордонд гурван өдрийн турш үргэлжилсэн Монголын эдийн засгийн форумын үеэр Монголын урлагийн зөвлөл “Хүн ба байгаль”, “Хүн ба нийгэм”, “Хүн ба оюун сэтгэлгээ” сэдвээр үзэсгэлэн зохион байгуулсан нь олны анхаарлыг татсан биз ээ. Манай 35 уран бүтээлч уран зураг, уран баримал, видео, фото, кино зэрэг бүтээлээ дэлгэн тавьсан нь Монголын урлаг соёлыг гадаад, дотоодын 1000 гаруй хүнд таниулан сурталчилж чадсан болов уу. Үүгээрээ ч Монголын эдийн засгийн форум урд хожид Улаанбаатарт зохион байгуулагдсан олон улсын чуулганаас ялгарсан билээ. Дэлхийн жишгийг харваас аливаа улс үндэстэн олон улсын томоохон арга хэмжээ зохион байгуулахдаа үндэсний урлаг соёлоо сурталчлах нь элбэг. “Их 20”-ийн уулзалт БНСУ- д болох үед ирсэн зочдоо урлаг соёлын үзвэр үйлчилгээгээр ёстой л бөмбөгдсөн дөө. Тусгай шоу, үзвэрүүд зохион байгуулахын зэрэгцээ Сөүлийн гудамжаар өглөө нарнаас үдшийн бүрий хүртэл сонирхолтой тоглолтууд болж байлаа. Музейнүүд нь ч үүдээ том гэгчээр дэлгэж, олны хөлд дарагдаж байв. “Их 20”-ийн уулзалтын үеэр Солонгосын уран бүтээлчид бүтэн нойртой хоноогүй болов уу гэмээр. За тэр ч яах вэ, урлаг соёлын салбар Монголд ямар байна вэ?

“Соёл бол гарлага биш, эдийн засгийн том салбар гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч байна” хэмээн Н.Жанцанноров гуай онцолсон нь юутай үнэн. Харин Монголын төр урлаг соёлоо уландаа гишгээд олон жилийг үдэж байна гэчихвэл нэг их буруудахгүй байх. Дуурь бүжгийн эрдмийн театр, Улсын драмын эрдмийн театр, Улсын филармони, Хүүхэлдэйн театр гээд нурж унах дөхсөн хэдэн барилгад Монголын урлаг соёл амь зогооно. За тэгээд тэтгэвэртээ гарах шахсан 40 орчим музейд үндэсний үүх түүх, шинжлэх ухааны

асар үнэтэй олдворууд өгөрч хуучирч байна. Үүсэн байгуулагдсанаасаа хойш их засварын нүүр үзээгүй нэгэн жарныг үдсэн Байгалийн түүхий музейгээр жишээ татая л даа. 2009 онд нийслэлийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас энэ барилгад үйл ажиллагаа явуулахыг нь хориглон улаан канттай бичиг “гардуулсан” ч өнөө хүртэл ажилласаар. Нүүгээд орчих өөр байр сав байхгүй юм хойно аргагүй биз дээ. Гэтэл музей бидэнд юу өгч болох талаар манай төр, засгийн эрхмүүд бодолцсон болов уу?

Канадын “Royal Tyrrell Museum” палеонтологийн музей 1985 онд байгуулагдсанаасаа хойш жилдээ л хагас сая хүн хүлээж авдаг болжээ. 2010 онд 10 сая дахь үзэгчээ угтсан гээд бод доо. Монголд ийм боломж байхгүй гэж үү? Гадаад, дотоодын палеонтологчдын арааны шүлсийг Монголын үлэг гүрвэлийн өндөг, яс асгаруулсаар байна шүү дээ. Яагаад бид энэ боломжоо ашиглаад, дэлхийн хэмжээний ганц музей байгуулчихаж болохгүй гэж? Зөвхөн тэр музейг үзэх гэж ирэх хүмүүс, палеонтологчдын тоо хэрхэн гэрлийн хурдаар нэмэгдэж, Монголын эдийн засагт ямар их орлого оруулахыг зүгээр л төсөөлөөд үз дээ!

Харин одоо барилга байшин, музейн асуудлыг түр орхиод уран бүтээлчдийнхээ амьдрал, амьжиргааны талаар ярихад бас л бүрхэг дүр зураг гарч ирэх вий. Монгол Улсын Засгийн газрын 351 дүгээр тогтоолоор Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн хэмжээг тодорхойлсон байдаг. Энэ жагсаалтад багтсан хамгийн өндөр цалин нь сарын 368 мянган төгрөг гэвэл Та итгэх үү? Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо төрийн албан хаагчдын цалинг нэмэх шаардлага тавин жагсаал зохион байгуулахад Улсын драмын эрдмийн театрынхан эхний эгнээнд нэгдсэн нь ийм учиртай. Энэ жагсаалын үеэр ардын жүжигчин Н.Мягмарнاران гуай “Монголын төрд урлагийг дэмжих ямар ч бодлого алга. Бид сардаа 230 мянган төгрөгийн цалин авдаг. Тайзан дээр цагаан захтай, цатгалан хүний дүрд тоглодог ч гэртээ харихдаа үр хүүхдэдээ юу ч үгүй буцаж байна” хэмээн онцолж байсан. Гэсэн ч Монголын уран бүтээлчид урлагийн замаасаа ухарсангүй. Сонгодог урлаг, соёлынхоо төлөө бие сэтгэлээ өгч, бүтээл туурвилаараа амьдардаг, амьсгалдаг хүмүүсийг төр хэрхэн дэмжиж байна вэ? Уг нь Монголын уран бүтээлчдийг жаахан л дэмжихэд босоод ирнэ, дэлхийн тавцанд гараад ирнэ хэмээн учир мэдэх хүмүүс ярьдаг юм билээ. Үүнийг гэрчлэх баримт мундахгүй ээ.

Кино найруулагч Д.Бямбасүрэнг германчууд төдийгүй дэлхий андахгүй. “Шар нохойн там”,

“Ингэний нулимс” кино нь Монголын соёл иргэншлийг бөмбөрцгийн хүмүүст таниулсан бус уу? Төрийн соёрхолт Т.Цэнд-Аюушийн шавь нарын “X roses” хэмээх хамтлаг, циркийн тоглолтоор гаднынхныг гайхшруулж буй “Circus Mongolia” группийг дурдахгүй өнгөрч боломгүй. АНУ-ын Калифорнийн их сургуульд урлаг судлалын ухааны доктор Ц.Уранчимэг багшилж байгаа нь мөн нэгийг өгүүлнэ. Цагаан сарын өмнөхөн Америкт Монголын соёлын өдрүүдийг зохион байгуулахад Ховд аймгийн алдарт хөөмийч Н.Сэнгэдорж, “Бөртэ” хамтлаг, АНУ-д аж төрж буй морин хуурч Г.Уртнасан, “Хөх тэнгэр” хамтлагийн бүжигчид хамтран Монголын язгуур болон үндэсний, орчин үеийн урлагийг танилцуулсан тоглолт хийсэн байна. Олон улсын нэр бүхий уралдаан, тэмцээнээс монголчуудын хүртсэн гавьяа шагнал ч тоймоо алдсан. Тайванийн кино наадмын гранприг “Хүсэл шунал” хэмээх баримтат киногоороо өнгөрсөн онд хүртсэн С.Бямбаа найруулагчаас эхлээд олон улсын хэмжээний уран зураачдын оролцдог “Бээжин бинал” наадмаас Х.Батбаатар “Untitled” бүтээлээрээ гранпри хүртсэн байх жишээтэй. Таван жилийн өмнө

Монголын нугараач циркийн хамгийн том тэмцээн болох “Монте карло”-гоос мөнгөн цом авсныг сануулах юун. Дэлхийн урлагийн дэвжээнд гаргасан монголчуудын энэ мэт амжилтын жагсаалт цааш хөвөрнө... Энэ бүхнээс Монголын уран бүтээлчдийн чадал, чансааг дүгнэж болно.

Харин манай төр соёл урлагаа хэрхэн дэмжиж байгаа юм бэ? “Соёл урлагийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах” гэсэн сайхан уриатай Соёл урлагийн хөтөлбөрийн урсгал төсөв 34.4 тэрбум төгрөг байхаар 2011 оны төсөвт төлөвлөжээ. Харин сонгуулийн амлалт биелүүлэх буюу ард иргэдэд бэлнээр мөнгө тараахад үүнээс 23 дахин их буюу 804.5 тэрбум төгрөг төсөвлөдөг төр, засагтай оронд бид амьдарч байна шүү дээ.

Монголын нүүрсийг биш, зэсийг ч биш, гагцхүү монгол хүний ур чадвар, авьяас билгийг дэлхийн тавцанд гаргах цаг нэгэнт иржээ. Энэ бол Монголд байгаа хамгийн том баялаг биш гэж үү? Гаднынхан Монгол гэхээр л алт, зэс, нүүрс, уран санагалзах биш, Монголын үүх түүх, урлаг соёлыг бодон уулга алддаг болох цаг ирээсэй.



Асуулт

-Хоёр дахь жилдээ болсон Монголын эдийн засгийн чуулганы талаар та юу хэлэх вэ? Хэлэлцсэн асуудлуудын үр дүн хэр гарах талд та ямар бодолтой байна вэ?

http://www.mongolianeconomy.mn

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН 2011

ХӨГЖИЛД ХАМТДАА



Ж.Оюунгэрэл:

/Петровис компанийн ТУЗ-ийн дарга/



-Төр иргэний нийгмээ сонсож буй нэг хэлбэр шүү дээ. Хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг нэг индэр болж байна. Энэ утгаараа их зөв арга хэмжээ. Үр дүн гаргахын тулд бүх оролцогч тал анхаарч өөрсдийн зүгээс санаачилгатай ажиллах ёстой. Бүх ярьсан асуудлыг ажил хэрэг болгох талаас төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхэн дор бүрдээ анхаарч ажиллах л шаардлагатай. Түүнээс өмнөх ярьсан юмаа л ярилаа, үр дүнгүй гэх нь өрөөсгөл, би хувьдаа тэгж бодохгүй байна.

Өмнөх жилийн Эдийн засгийн чуулганаас өнөө жилийнх нэлээд сайжирсан нь харагдаж байна.

Н.Дашзэвэг:

/Эдийн засагч/



-Энэ удаагийн чуулганаар маш сайн саналууд их гарлаа. Эдгээр сайн саналыг төрийн бодлого, эдийн засгийн бодлого болгон амьдралын хөрс дээр буулгавал манай улсын эдийн засгийн хөгжил хурдсаж, зөв замдаа орно гэж бодож байна.

Тухайлбал, Монголын эдийн засгийн хөгжлийн стратегийг дөрөв дөрвөн жилээр найман жилээр төлөвлөдөг болгоё, 20 жилийн стратегийн төлөвлөгөөг гаргая, улсын төсвийг олон нийтийн буюу төрийн бус байгууллагын оролцоотой хэлэлцдэг болгоё, төрийн өмчийн олон дээд сургуулийг татан буулгаж, оронд нь нано технологитой, мэдээллийн технологид тулгуурласан лаборатори, паркуудыг байгуулъя гэсэн бодит саналууд олон гарлаа. Эдгээр саналыг УИХ, Засгийн газар шүүрч аваад л хуулиндаа,

дүрмэндээ өөрчлөлт хийж оруулаад хэрэгжүүлбэл үр дүн гарна. Хэрвээ энэ олон хүний ярьсан саналууд хэрэгжихгүй л юм бол уг арга хэмжээний үр дүн гарахгүй шүү дээ. Дараа жилээс ч хүмүүс энэ уулзалтад ирэхээ болино.

Л.Ариунболд:

/"Монгол -999" ХХК-ийн гүйцэтгэх



захирал/

-Санал солилцож шийдэл сонсоно гэсэн. Ямар үр дүн гарахыг мэдэхгүй. Гэхдээ улс орны хөгжлийн гараан дээр төр олон нийттэй саналаа солилцож байгаа нь сайшаалтай. Харин манай төрийн түшээд бидний үгийг сонсохгүйгээр өөрсдийн ажлаа л тайлагнаад яриад байна. Нөгөө л зовлон бэрхшээлээ дахин давтаад ярьж байна. Гурван өдрийн хурлаас манай улстөрчид өөрчлөгдөхгүй юм байна, ирэх сонгуульд бэлтгэж

байгаа юм байна, Монголын эдийн засгийн чуулганыг ажлаа тайлагнах индэр болгож байгаа юм байна гэдгийг анзаарлаа. Түүнээс хувийн хэвшлийнхэн, эрдэмтэн судлаачдаас гарч буй чухал саналыг үнэхээр ажил хэрэг болгоё гэсэн байдал ажиглагдахгүй байна. Хамгийн гол нь шийдвэр гаргагчид улстөрийн хүсэл эрмэлзлэлтэй байх ёстой шүү дээ.

М.Ичинноров:



/Хуульч/

Өнгөрсөн жилийн ярьсан олон асуудал өнөөдөр шийдлээ олж, тодорхой түвшинд яригдаж байгаа. Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шийдэл хэрэгтэй. Тэрхүү шийдлийг гаргахад ярилцаж зөвлөлдөх хэрэгтэй. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэг. Тэр л шийдэл, зөв үйлсэд хүрэхийн үндэс суурийг нь тавьж байна. Өмнөх жилийн уулзалтаас өнөөдөр хүмүүс ч өөрчлөгдсөн, цаг хугацаа ч өөр болж. Хүмүүсийг өөдрөгөөр харж байгаагийн гол нь тэд зовлон бэрхшээл ярихаасаа илүүтэй хөгжлийн шийдэл, гарц ярьж байна.

Нэг барилгын компанийн мэргэжилтэн эмэгтэй хотын утааг хэрхэн багасгах, ажлын байрыг яаж нэмэгдүүлэх зэргээр төлөөлөгчид амьдралиас урган гарсан зөв зөв шийдлийг санал болгож байна. Чуулганаар ярьж буй бүх асуудал хоорондоо уялдаа холбоотой байна. Энэ уялдаа холбоотой бүх асуудлыг хэрхэн зохицуулж үр дүнд хүргэхэв гэхээр улс орны эдийн засгийн стратегийн бодлогыг л зөв тодорхойлж гаргах хэрэгтэй юм байна.

Л.Пүрэвбаатар:

/Төмөр замын хэрэг эрхлэх газрын дэд дарга/

-Цаг үеэ олсон арга хэмжээ



болсон. Оролцогчдын хувьд ихэнхдээ дарга хурандаа нар нь л байна. Цэргүүд цөөхөн харагдаж байна. Энэ форум дээр хэлэлцсэн асуудлуудаар хамгийн гол нь амьдралд хэрэгжүүлэх хүмүүс л сайтар мэдээлэл авч байж ажил урагшилна, үр дүнд хүрнэ. Тэгэхээр энэ мэдээллийг яаж нийгэмд хүргэхэв, нийгэмд хүргэх тэр мэдээллийн утга агуулгыг хэрхэн томъёолохов гэдэг нь их чухал. Ерөнхийгөөс тодорхой руу л шилжих яриа л даа. Энэ ажил форумын дараа хийгдэх байх. Дэд бүтэц, санхүүгийн зах зээл, орон нутгийн хөгжил гээд ерөнхий нэр томъёо дор олон асуудлыг ярилаа. Эцэст нь хэрэгжүүлэх он дараалалтай, хийх ажлын жагсаалттай, хариуцах эзэнтэй том схем гарвал зүгээр байх. Урт, дунд, ойрын хугацааны гэсэн. Тэгээд ажил хэр явааг олон нийтэд мэдээлж байвал зүгээр болов уу.



Б.Төмөрчулуу

/“Сэргэн мандалт” группийн үүсгэн байгуулагч/

Ярьж бодож сэтгэх хийхийн тал нь. Ийм чухал ажил байнга байгаасай. Монголын эдийн засаг гэдэг машиныг уул уурхайн мөнгөөр чирч асаах гээд байгаа юм уу эсвэл уул уурхайн машинаар түлхэж асаах

гээд байгаа юм уу. Уг нь бол өөрийн хүчээр асах ёстой. Хэрэглээний зах зээл дээр тоглоод сурчихмаар байна. Ийм хөдөлгүүр Монголын эдийн засгийн гол цилиндр болно. Уул уурхайн мөнгө урвадаг мөнгө. Импортын дарлалаас ядаж 60 хувь чөлөөлөгдмөөр байна. Энэ цагт Монголын эдийн засаг гэдэг машин ажиллаж чадна. Монгол Улс хүн төрөлхтөний эдийн засагт сонин содон зүйлээр орох ёстой. Ертөнцөд огт байдаггүй тариа будаа тарьж болно.

Үлгэр жишээ хөгжлийн загварыг олж харах хэрэгтэй байна. Төр туслахдаа мөнгө төгрөг, татвар татаасаар туслах хэрэггүй. Цэцэн бодлогоор туслах хэрэгтэй.



Дэвид Патерсон

/“Оюу толгой” ХХК-ийн бүсийн хөгжил, олон нийтийн харилцаа хариуцсан дэд ерөнхийлөгч/

Тус чуулган Монголын эдийн засаг болоод түүний ирээдүйн өсөлтийн талаар санаа оноогоо хуваалцах сайхан арга хэмжээ боллоо гэж бодож байна. Эдгээр асуудлын талаар Засгийн газар, иргэний нийгэм, үйлдвэрлэлийнхэн хамтдаа хэлэлцэж байгаа нь ямагт маш сайн зүйл байдаг юм.

Баялгийн хараалын талаар маш сонирхолтой нилээд олон хэлэлцүүлэг явагдаж байсан. Баялаг нь улс оронд хараал эсвэл ерөөл авчирч болно гэдгийг бид бүгдээрээ мэддэг. Гэхдээ Монголын тохиолдолд энэхүү эрдэс баялгийн арвин их буян хишиг нь агуу их ерөөл авчрах гэж буйг харуулсан олон нотлох баримт гарч байна гэж бодож байна. Ийм нээлттэй ардчилалтай, Засгийн газар нь сайн засаглалыг хөгжүүлэх талаар ихээхэн үүрэг

Ядуурал буурсан уу?

И.Отгонжаргал



2007 оноос хойш үнэндээ гэр хорооллоор явж сурвалжлага хийгээгүй юм байна. Хувь хүнийхээ хувьд дотроо бодохдоо улсаас халамж их өгч байгаа юм чинь хүмүүсийн амьдрал тийм ч их биш байгаа байх гэж бодож явсандаа ичих шиг. Энэ сурвалжлагад явчихаад хоёр хоног сэтгэл хямарснаа нуух юун. Монголчуудын маань нэг хэсэг нь ямар их ядуурч, өвчин шаналалд автаж байна аа гэж бодохоор сэтгэл өөрийн эрхгүй хямарсан. Гэтэл төр, засгийн хүмүүс “халамж их өгч байгаа болохоор амьдрал болж байгаа гэж” бодоод дуу аялан албан тасалгааны цонхоор харж байж ч мэднэ... Дээрх ядуу хүмүүсийн яриа сурвалжлагаар цааш үргэлжилнэ. Одоо харин яагаад ядуусын амьдралыг сурвалжлах болсон талаараа бяцхан тайлбар хийх нь зөв байх. Монголын эдийн засгийн форумын үеэр олон салбар хуралдаан зохион байгуулсны нэг нь нийгмийн хамгааллын шинэчлэлийн сэдэв байлаа.

Хүний амьдралын ажил хөдөлмөр эрхлэх, халамж, үйлчилгээ авах гээд л хамаг нарийн ширийн асуудлыг хамарсан чухал салбарын шинэчлэлийн асуудлыг хөндсөн учраас 90 минут хаанаа ч хүрэлцэхгүй байв. Эндээс миний бие нэг л асуудлыг сэтгүүлчийнхээ хувьд тодорхой болгох юм байна гэсэн зорилго тээж гарсан. Монголд ядуурал буурсан уу? гэдэг асуултын хариултыг олох. Хурлын эхэнд оролцогчид мөн л энэ асуултыг гаргаж ирснээр холбогдох байгууллагуынхан өөр өөр тоо баримт хэлж энд нэлээд цаг авсан юм. Тухайлбал, УИХ-ын даргын эдийн засаг, нийгмийн бодлогын зөвлөх Д.Даваасамбуу хэлэхдээ “2006-2007 онд ядуурлыг хэмждэг үзүүлэлт өөрчлөгдсөн. Үүгээр 80 хувьтай байсан ядуурал 35 хувьтай болсон. Чанарын үзүүлэлт нь өндөр болсон. Төрийн албан хаагчдын цалинг нэмж ядуурлаас гаргасан. Олон улсын байгууллагуудын судалгаа бэлэхнээ

хэлсэн байгаа. Маргах юм байхгүй” хэмээсэн. Үндэсний статистикийн хорооны дэд дарга Т.Эрдэнэсүрэн “Манай байгууллагаас хийсэн судалгаагаар ядуурлын түвшин улсын хэмжээнд 2002 онд 37 хувьтай, 2008 онд 36 хувьтай, 2010 онд 38 хувьтай гарсан.

Дэлхийд ядуурлын түвшинг судалж тогтоодог хэд хэдэн арга байдаг. Хөгжил тааруу орнууд хэрэглээний сагсны аргаар тооцдог. Манайх энэ аргаар тооцож гаргаж байгаа. Энд ядуурлын түвшинг тооцож буй арга нь буруу биш. Харин ядуурлын 2007 оны түвшинг 2010 оныхтой харьцуулж, ядуурал буурсан буураагүй гэж дүгнэж болохгүй гэдэг зөвлөмжийг Дэлхийн банк өгч буй. Үүнийг манай бодлого боловсруулагчид буруу ойлгож байгаа тал бий” гэв. Харин Дэлхийн банк ядуурлын түвшний өөрчлөлтийг харилцан уялдаатай хэмжигдэхүүн ашиглан тодорхойлсон аж. Ингэж тооцоолсноор Монголд ядуурлын түвшин 2002/2003 онд 61.1 хувь байсан ба 2007/2008 онд 35.2 хувь болж буурсан байна гэсэн дүгнэлт хийжээ.

...Манай байгууллагын ажилтан саяхан нэг ядуу айлын хүнийг ажилд оруулахаар гэр хороололд очиход, өмнөөс нь нохойгоо тавьсан байсан. Ингэж л монгол хүн зэрлэгшиж байна. Өөрт нь тусалъя дэмжье гэсэн хүний өөдөөс нохойгоо тавьж байна гэдэг чинь юу гэсэн үг вэ. Монголчууд ингэж л тэжээвэр сэтгэлгээтэй болж байна” хэмээн “Тэнгэр” санхүүгийн нэгдлийн захирал М.Болд ярилаа. Тэрбээр энэ үгээ Эдийн засгийн форумын төсөв, төлөвлөлт сэдэвтэй салбар хуралдааны үеэр хэлсэн юм. Энэ үг миний гэр хорооллоор явж сурвалжлага хийх сонирхлыг улам бадраасан хэрэг.

15 настай хүүхэд ясны

сийрэгжилт болж, 75 настай хөгшин төрийнхөө буянг харуулдаг хэвтэнэ

2011.03.15. Ядуурал буурсан уу, үгүй юу? гэдгийг сонирхохоор нийслэлийн баруун зах руу буюу Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороогоор очлоо. “Захын айлын хаалгыг цохиход л ядуу байгаа шүү дээ яагаад заавал манай хороог сонгож байгаа “ гэж нэг ажилтан нь дургуйцав. Болд захирлын хэлсэнчлэн нохойгоо өмнөөс тавибал яалтай. Тэгээд ч зах хязгааргүй мэт үргэлжлэх, хог шороо ихтэй гэр хорооллын хаанаас нь ядуу өрх олно гээд явах билээ. Гэхдээ тус хорооны хоёр ч хэсгийн ахлагчаар нь замчлуулсан болохоор баярласан шүү гэдгээ уламжлах нь зөв байх.

Бидний эхний айл хотын баруун захын хуучирч муудсан гурван давхар шар байрнуудын нэгэнд байлаа. Тодруулбал, шинэ цэргийн хотхоны 73.1.4 тоот. Гэрийн эзэн Ц.Цэрэндэжид босоод явах тамир тэнхээгүй, өвчинд шаналан хэвтэнэ. 75 настай тэрбээр 117 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг. Замын II ангид Төмөр замын гармын жижүүрээр 32 жил ажиллажээ. Тэрбээр “Амьдралд болж байгаа юм гэж алга хүү минь. Тэтгэврээсээ гэрлийн мөнгө, утасны мөнгө, байрны мөнгөө өгөөд 50 мянган төгрөг үлддэг” гэв. Тэрбээр дөрвөн хүүхэд төрүүлж, өсгөсөн ч дор бүрнээ л өнөө маргаашаа болгож ядаж байгаа болохоор ээждээ илүүчлэх мөнгө байдаггүй гэнэ. Цэрэндэжид гуай ч хүүхдүүдээсээ мөнгө хардаггүй, ажил хөдөлмөр эрхлэхээсээ эрхлэхгүй нь олон болохоор өөрсдөө л хоосон хоночихгүй болгож байвал болох нь тэр гэж залбирдаг аж. “Намайг ач охин маань асран халамжилж байгаа. Энэ маань удахгүй төрөх гээд байдаг” гэж санаа алдав. Өвчин шаналалд зовиурласан тэрбээр залуу насны хүч хөдөлмөрөө зориулсан Замын II ангиас нь сард 10000 төгрөг өгдөг байснаа сүүлийн үед огт сураггүй болчихсонд гайхаж хэвтэнэ. “Одонгийн мөнгө авах болсон чинь бас хамрагдаж чаддаггүй ээ. Уг нь би 1960-аад онд Эхийн II одон авсан юм. 1990-ээд оны дундуур манайх үерт ороод хамаг юмаа урсгачихсан. Эхийн одонгоо өнөөдрийг болтол үгүйлсэн ч үгүй.

Тэгээд л сая мөнгө өгөх боллоо гэхээр нь санасан чинь байдаггүй. Лавлагаа энэ тэр авч уйгагүй явбал болох л байх даа. Даанч өөрөө хөдөлж чадахгүй хэвтрийн хүн чинь яах гээд ч нэмэр алга. Ноднингийн дөрөвдүгээр сараас хойш хэвтэрт байна. 4-5 эмнэлэг дамжлаа” гэв. Түүний тэтгэвэр мөнгө хатуу байхад 240 төгрөгөөр тогтоож байжээ. “Төрийн минь сүлд таван төгрөг байсан чиг л их юм шүү дээ. Би улсад ажил хийснээс гадна 20 гаруй жил байр, хэсгийн дарга хийсэн хүн. Өндөр настны халамж үйлчилгээнд хамруулах нь бага л юм байна шүү дээ” хэмээн гомдонгуй өгүүлсэн. Насны эрхээр шээс нь задгайрч, хавагнадаг болсон түүний хувьд байр нь мөсний хөндий шиг болсон нь өвчнийг нь улам сэдрээж байгаа бололтой. Тус хорооны IV хэсгийн ахлагч П.Нямжав “Хууль дүрэм амьдрал дээр их зөрчигдөж байна.

Нийгмийн халамж үйлчилгээ зохих хүндээ хүрдэггүй. Жишээ нь Цэрэндэжид гуайг халамжид хамруулах гэхээр асран хамгаалах үр хүүхэдтэй, байр савтай гээд хасагддаг. Гэтэл хүүхдүүд нь тус тусдаа дөнгө ядсан амьдралтай. Насныхаа залууд улсад хөдөлмөрлөснийхөө хүчинд ганц өрөө байр авсан л байгаа биз. Тэр нь одоо хуучирч муудаад халахгүй, тун хүнд нөхцөлд амьдарч байна шүү дээ” гэж учирлаж байлаа.

Дараагийн айл М.Баярцогтынх. Эхнэртэйгээ хоёулаа ажил, мэргэжилгүй. Баярцогт эр хүний

ид хийж бүтээдэг 47 настай ч групптэй. Хүнд юм өргөх хориотой. Бие нь ядрахаараа унаж татах нь ч энүүхэнд. Орон дээр цэвэрхэн хувцасласан залуу унтаж байсан нь том хүү Батжаргал нь аж. “Эмнэлэг явж ирчихээд унтаж байгаа. Уг нь аав ээждээ тусалж, мөнгө олох сонирхолтой ч хөл, гар нь янгинаад байдаг болсон. Эмнэлэгт сайн үзүүлж чадаагүй байгаа ч эмч нар ясны сийрэгжилт байх гэсэн” хэмээн аав нь ярилаа. Түүнийг аав ээж нь сургуульд явуулж чадалгүй долдугаар ангиас нь гаргажээ.

Улсын сургуульд явуулахад нэг их мөнгө шаардагдахгүй шүү дээ, хүүгээ яагаад сургуулиас нь гаргасан юм бэ? гэж лавлахад, “Хэдийгээр улсын сургууль ч гэсэн ном дэвтэр, цүнх сав гээд л мөнгө хэрэг болдог. Хажуугаар нь сургуулиас нь тийм ч юмны мөнгө ийм ч юмны мөнгө гээд нэг их биш ч гэсэн байнга мөнгө шаардчихдаг бололтой юм билээ. Хүүхэд болохоор тэр бүр зовлонгоо хэлээд байж чадахгүй, санаа нь зовдог юм шиг байгаа. Тэгээд өөрөө сургуульд явахгүй гээд байдаг болсон” гэв. Эдний сарын орлогыг сонирхвол, нөхрийнх нь группийн 51000 төгрөг. Дээр нь дөрвөн ам бүлийн 21000 төгрөг буюу 84000 төгрөг нэмэгдэнэ. Өөрийн гэсэн хашаагүй учраас хүнсний ногоо хадгалах зориулалттай агуулахын хашаанд манаач маягаар буусан гэнэ. Гэрийн эзэн өвөл хааяа зоорь галлаж сардаа дунджаар 50000 төгрөг олох нь бий. Баярцогтынх 2002



онд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумаас хотод орж иржээ. Өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор эхнэр нь Өвөрхангайн Баян-Өндөрт аавындаа үрчлүүлсэн хоёр хүүхдээ өөрийн ам бүлийнхээ тоонд оруулах гэсэн боловч овог нь өөр байна гэдэг шалтгаанаар бүтээгүй гэсэн. Нөхөр нь групптэй болохоор шаардлагатай эмээ хөнгөлөлттэй үнээр авдаг ч, авч чадахгүй үе ч бий. Эхнэр нь биднийг очиход байгаагүй. Ямар нэгэн юм олж хийж өдрийн хоолны мөнгөө олохоор гарсан бололтой. Эхнэр нь бас тийм ч гялалзтал ажиллалчаар эрүүл саруул биетэй хүн биш бололтой. Ходоод, гэдэсний шархтай. Шөнө унтаж чаддагүй гэсэн. Үзүүлж харуулах гэхээр эрүүл мэндийн даатгалаа бөглүүлж чадахгүй болохоор эмнэлэгт хандах эрхгүй.

Тог цахилгааны мөнгө нь 15000 төгрөг гардаг. Өвлийн цагт даарч хөрчихгүйн тулд нүүрсэнд орлогынхоо ихэнхийг зарцуулдаг байна. Хоол хүнсээ хоосон хонохгүй хоёр идэхгүй л болгодог аж. Бага нь харин сэргэлэн хүү санагдсан. “Аав аа, би хичээлдээ явлаа шүү” гэж цовоо дуугаар хэлээд гарсан түүний царайнаас өлссөн цангасан, ядуу амьдралын зовлон шаналал ажиглагдаагүй.

21 мянган төгрөгний дэвтрээ

ТҮЦ-д тавьж, өнөө, маргаашаа зогоож байна

Гурав дахь айл Төмөр замын дангийн 15.1 гэдэг хаягтай байлаа. Дөрвөн талаасаа ордог нийтийн зориулалттай барьсан байшин. Царайг нь харахад нас бие гүйцсэн бололтой ч давжаа биетэй бор охин угтав. Сэтгүүлийн сурвалжлагч амьдрал ямар байна гэж сурвалжилж явна. Ядуу айлуудаараа оруулаад явж байна эгч нь гэсэн хэсгийн ахлагчийн үгэнд тэрбээр багахан хигжүүрхэнгүй хандсан. “Манайх олсноороо болгоод л байдаг шүү дээ. Нэг их ядуу ч биш” гэв. Ах, дүү зургуулаа амьдардаг гэнэ. Том ах нь мөнгө олж дүү нараа тэжээдэг. Л.Батчимэг 19 настай.

Тэрбээр Монгол-Солонгосын техникийн коллежид сурдаг байж байгаад бие нь өвдөөд сургуулиасаа жилийн чөлөө авчээ. Миний дүү тэгээд эмчилгээ хийлгэж байгаа юм уу гэхэд “үгүй, бие нэг их өвдөөгүй. Зүгээр л нэлээд ядарсан байна гэсэн” гэлээ. Хоол ундны дутагдалтай явсаар ядаргаанд орсон бололтой. Хэсгийн ахлагч Нямжав “Эд нар ч болоод байдаг юм. Том ахынх нь эхнэр сая төрсөн. Том ах нь вагоноос нүүрс буулгаж мөнгө олдог. Архи уудаггүй, дүү нараа сүрхий авч яваа сайн ах байгаа” гэж онцлов.

Л.Батчимэг “Манайх 21000 төгрөгөө аваад нэг сардаа хоол хүнсээ бэлдээд, дараагийн сардаа гурил будаа авах шаардлагагүй байвал ярилцаж байгаад хэрэгтэй юмаа авдаг” гэлээ.

Ядуу ч гэсэн олдож байгаагаа болгоод яваа нь сайн хэрэг. Хэсгийн ахлагчийнх нь хэлснээр эднийд ажил төрөл эрхлэхээр хүн цөөн юм билээ.

Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд очиж хэсгийн ахлагчаа солилоо. Өөр чиглэлд явж үзэхээр тэр. II хэсгийн ахлагч И.Одончимэг машинд суув. Түүний хариуцсан хэсэг замын урд талын гэр хороолол гэнэ. Түүнд би захиалга өглөө. Одоо нэг их өвчтэй зовлонтой, өндөр настай айлд ормооргүй байна. Залуу хүмүүстэй. Өөрөөр хэлбэл, ажил хийх насны хүмүүстэй, тэгсэн хэрнээ ажил эрхлэх дургүй халамжийн мөнгөө хараад суудаг гэр бүлд орж үзмээр байна гэж. Тийм өрх зөндөө бий гээд нэг айлд дагуулж орлоо. Хаалгаар нь оронгуут цэмбийсэн цэвэрхэн орчин угтав. Баруун орон дээр нэг өвгөн, хоёр ч залуухан эмэгтэй, нэг жаахан хүү сууж байв. Шинэ шалны хулдаас дэвссэн. Хойморын орных нь гоёл чимэглэл нь шинэхэн, ядуу гэхэд халуу дүүгсэн, гэгээлэг айл санагдав. “Тэр орон дээр суугаа өвөөг Яндаг гэдэг.

Энэ хоёр охин нь сэтгэцийн өвчтэй, өвөө бас зүгээргүй ээ, энэ жаахан хүү охиных нь хүүхэд. Бас тархиндаа усжилттай гэсэн. Том охин нь хоёр хүүхэдтэй” гэж хэсгийн ахлагч танилцууллаа. Хоёр охин нь сэтгэцийн өвчтэй Шар хадны эмнэлгийн хяналтад байдаг гэнэ. Тэгсэн хэрнээ том охин нь яриа хөөрөө сайтай, гадна царай төрхнөөсөө сэтгэцийн өвчтэй гэж харагдахааргүй байсан нь сонин. Тэрбээр “Манай аав түрүү булчирхайн хагалгаа хийлгэсэн юм. Дааруулж болохгүй гэсэн болохоор гал бараг тасалдаггүй. Манай орлогын талаас илүү нь түлээ түлшинд явдаг даа. Халамжийн мөнгө хаанаа ч хүрдэггүй. Аавыгаа 3-4 сар тутам ЭХО-д харуулна. Нэг шинжилгээ нь л гэхэд доод тал нь 65000-75000 төгрөгийн үнэтэй. Нэг шуудай нүүрс 1500 төгрөгийн үнэтэй. Хоногтоо 3-4 шуудай нүүрс түлдэг. Өвөл бол дөрвөн шуудай дөнгөн данган хүрдэг. Одоо ч ирж яваа цаг болохоор харьцангуй гайгүй болж



байна” гэлээ. Эднийх хоногт зөвхөн нүүрсэнд 6000 төгрөг зарцуулдаг гэж бодохоор сард 180000 төгрөг болох нь. Хоёр охин нь сэтгэцийн өвчтэй учраас аавыгаа асран хамгаалах эрхгүй. Тиймээс эрэгтэй дүү нь асран хамгаалагчаар нь байдаг аж. Тэрбээр өдрийн цагаар гадагшаа гарч, төмөр авдаг гэсэн. Яндаг гуайн сарын орлогыг тооцоод үзье.

Хоёр охин нь группийн мөнгө гэж сард тус бүр 51000 төгрөгийн “цалинтай”. Яндаг гуайн тэтгэвэр 80000 байж байгаад саяхан нэмэгдээд 100000 болсон гэнэ. Тэгээд зургаан хүний сарын 21000 төгрөгийг тооцохоор 126000 төгрөг болно. Нийтдээ сарын 328000 төгрөгийн орлоготой гэсэн үг. Энэ мөнгөөр зургаан хүн иднэ ууна, өмсөнө зүүнэ. Энэ өрхийн хувьд хамгийн зарлагатай нь түлээ, нүүрс, эм тариа гэсэн. Дулаан суухад өрхийн орлогынх нь 20 хувь нь явчихна. Харин дулаарч байгаа болохоор нүүрснээсээ сүүлийн үед 45 мянган төгрөгийн хэмнэлт гаргаад байгаа аж. Үлдэж байгаа 193000 төгрөгөөрөө дараа сарын 15-н болж халамж, тэтгэврийн мөнгөтэй залгатлаа зургаан хүнийхээ хэрэгцээг болгох ёстой. “Дээр нь манай том хүү дөрөвдүгээр анги. Сургуулиас нь бас ийм ч юмны мөнгө тийм ч юмны мөнгө гээд байнга шаналгачихна шүү дээ” гэж том охин нь ярилаа.

Тэгээд яаж амьдралдаа хүргэж байна гэхэд “Үнэнийг хэлэхэд хүрдэггүй юм. Бүх халамжийн мөнгөө авч зээлээ төлөөд л таардаг. Тэгээд 21000-ынхаа дэвтрүүдээ таньдаг ТҮЦ-д тавьж мөнгө зээлнэ шүү дээ. Тэгж л болгодог. ТҮЦ-ээр дүүрэн 21 мянган төгрөгний дэвтэр байдаг байх” хэмээн инээд алдаад, “Ганц манайх ч биш, энэ хавийн айлуудын ихэнх нь иймэрхүү маягаар амьдарч байгаа” гэлээ. Тэгээд ТҮЦ-ний эзэн зүгээр мөнгө зээлэхгүй биз дээ гэж сонирхоход, “Тэгнэ ш дээ. Өрөө авахдаа хүү нэмж авдаг байхгүй юу” гэж тайлбарлав.

Хэцүү ч амьдрал юм даа. Нэг гэрт том бага нийлсэн дөрвийн дөрвөн сэтгэцийн өвчтэй хүн байгаа ч гэсэн халамжийнхаа мөнгийг болгох гээд аавыгаа эмнэлэгт үзүүлээд, болж өгвөл хүүхдээ хүртэл III эмнэлэгт аваачиж үзүүлэхээр явдаг гэсэн. Хэдийгээр сэтгэцийн өвчтэй ч эрүүл мэнддээ анхаарч байгааг нь миний

хувьд үнэлсэн. Эмэгтэйг “Чи гэрээ их гоё цэвэрхэн байлдаг юм байна” гэхэд “Энэ гэрийг Дэлхийн зөнгөөс өгсөн юм. Хүний өгсөн юмыг цэвэрхэн өнгөтэй өөдтэй авч явахгүй бол болохгүй шүү дээ” хэмээсэн нь бахархмаар. Хэсгийн ахлагч нь гарч явахдаа “Дэлхийн зөнгөөс ямар ч тавилгагүй гэр өгсөн л дөө. Эд нар ор, зурагт авч тавиад, шалны хулдаас дэвсээд хөөрхөн янзалчихсан байна. Энэ хүүхэн уг нь их сэргэлэн л дээ. Даан ч хааяа өвчин нь хөдөлчихдөг талтай. Мөнгө төгрөг муугаасаа болоод эмээ авч ууж чаддаггүй ч байж болох юм” гэлээ.

Одоо СХД-ийн 20-р хорооны V баазын 10.3 тоотод оршин суудаг Батбаярын амьдралыг сонирхъё. Гэрийн эзэн 49, эхнэр Нэмэхбаяр нь 45 настай. Гурван хүүхэдтэй. Эхнэр нөхрийн хэн нь ч ажил эрхэлдэггүй. Уг нь эхнэр нь хэдэн жилийн өмнө тор оёж борлуулдаг байсан ч сүүлийн үед торыг чанартай материалаар хийж чадахаа больжээ. Том охин нь МУИС-ийн гуравдугаар курсийн оюутан гэнэ. Дараагийн хүүхэд нь Барилгын коллежид сурдаг бол бага нь 10 жилийн сурагч аж. Эднийх мөн л нийтийн зориулалтаар барьсан байшингийн нэг өнцөгт амьдардаг бөгөөд хоёр хонож байж гал түлдэг гээд бод доо. Өдөр бүхэн галлах боломжгүй учраас өнжөөд нэг галладаг байна. Ороод 10 минут хэртэй болоход өвлийн гуталтай миний хөлийн хуруу чимчигнэж байв. Гуравдугаар сар талдаа орчихоод байхад шүү дээ. Өвөлжингөө гал бараг үзээгүй тул гэрт нь хүйтэн хургачихсан бололтой. “Нэгэнт нүүрс авч дийлэхгүй байгаа юм чинь бусад ядуу хүмүүс шиг машины дугуй ч гэсэн түлээд гал гаргаад дулаацаж болно л доо.

Гэхдээ хэдийгээр ядуу амьдарч байгаа ч тийм муухай юм түлж агаар бохирдуулаад яах вэ дээ гэж боддог” хэмээн эхнэр Нэмэхбаяр нь хэлэв. Нялх нойтон хүүхэд байхгүй тулдаа л болдог бололтой. Залуухан хүмүүс учраас тэтгэвэр авахгүй. Таван ам бүлийнхээ 21000 төгрөгөөрөө л сарынхаа хэрэгцээг болгодог гэнэ. Ингэхийн тулд том, багагүй ходоодныхоо мухарт хааяа л идэх юм хаядаг гэсэн. “Ямар ч гэсэн 21000-аасаа хоёр оюутныхаа автобусны виза картыг захиалчихад нэг сар чих

амар явдаг” гэж Батбаяр өгүүллээ. Охиных нь сургалтын төлбөр 800.000 төгрөг бөгөөд Дэлхийн зөн олон улсын байгууллагаас төлжээ. Том охин нь “Болгоод байх тусам аав ээж хоёр намайг бүр хаячих юм аа” гэж хааяа гомдоллодог гэнэ. Эдний хүүхдүүдийн нэрийг бичихийг хүссэнгүй.

Их сургуульд сурдаг оюутнуудад ийм ядуу амьдралд нухлагдаж яваа нэгэн бий л байх, гэхдээ тун цөөн биз. Бас болоогүй ээ, охин нь их сургуулийнхаа ангийн дарга гэж байгаа. Танайх цахилгаанд хэдэн төгрөг төлдөг вэ гэхэд Нэмэхбаяр “Цахилгааны мөнгө харин их хачин гараад байгаа. Тогны мөнгөө ч гэсэн төлөхөд нэмэртэй гэж бодоод үүдэндээ нэг айл буулгасан юм. Тэгээд энэ айлаас сард 15000 төгрөг авч цахилгааны төлбөртөө өгдөг. Тэгсэн өмнө нь манай энэ хашаанд байсан айл гэрлийн мөнгөө төлөхгүй 200.000 төгрөгийн өр үүсгэчихсэн юм билээ. Одоо тэгээд тэр өр нь манайхаас нэхэгдээд, гэрлийн мөнгөө сар сардаа өгөөд байгаа хэрнээ байн байн тог тасалчихдаг.

Төрөөс халамжийн мөнгийг бөөнөөр нь өгдөг л юм бол гэрлийнхээ өрийг л даръя гэж бодож суудаг” гэв. Эднийх идэх хоол хүнс үнэхээр муутай аж. Нэг удаа хоол хийх цувдаа 300 төгрөгийн үнэтэй байсан чинь үнэ нь нэмэгдээд 500 төгрөг болсон гэнэ. Уг нь “Хархорин” зах дээр 400 төгрөгийн үнэтэй байдаг ч “Хархорин” явах автобусны мөнгөгүй учраас гэрийнхээ ойр орчмоос цувдаа олж иддэг аж. Замын хойд талын ТҮЦ-үүдэд ядуу өрхүүдийн иддэг цувдаа нь байдаг гэсэн. Нөхөр нь мөн л харвалт өгсөн, хүнд зүйл өргөх хориотой. Гэрээрээ нэг ширхэг тариа хийлгэх гээд 300 төгрөгийн тариур авч чадахгүй хэсэг хугацааг өнгөрөөжээ.

Эхнэрийнх нь зовхи сүүлийн үед байнга татдаг болсон ч эмнэлэгт үзүүлж чадахгүй л яваа аж. Мөнөөх л эрүүл мэндийн даатгалаа бөглүүлээгүй учраас эмнэлэгт хандах боломжгүй. Эднийх 1994 онд хуучнаар Атрын САА-гаас шилжиж иржээ. Та ажил хийх гэж үзсэн үү гэж асуухад “Охиноо наймдугаар ангид байхад цайны газар ажилд орж үзсэн. Цалингаа өгөхтэй өгөхгүйтэй их л хэцүү юм байна лээ. Тэр хооронд явсан унааны мөнгө бүр талийж өгч байгаа юм чинь.

Ажил хийх биш, өрөнд орчихоор юм билээ” гэв. Энэ хоёр өдөрт 5000 төгрөгийн хөлстэй цэвэрлэгээний ажилд харин сайн оролцдог гэж хэсгийн ахлагч эмэгтэй нэмж хэлэв. Даанч тэр цэвэрлэгээний ажил нь байнга биш хааяа л гарч ирэх юм гэж Нэмэхбаяр ярьсан.

Өлсөж цангаж, даарч хөрч байгаад хүүхдүүдээ мэргэжил боловсролтой болгоё гэж зорьж байгаа Батбаярын гэр бүлд талархаж байгаагаа илэрхийлье. Хэдий хэцүү амьдралтай ч эхнэр Нэмэхбаяр нь алсын хараатай, ухаантай эмэгтэй санагдсан.

Эцэст нь хэлэх сэтгүүлчийн үг

Ядуу хүмүүс “тусалж дэмжих ах, дүү муу. Бүгд л өөр өөрийн амьдралаа болгоод ч байгаа юм шиг болгохгүй ч байгаа юм шиг л явдаг” гэж ам нэгтэй учирлаж байгаа нь өнөөдөр монголчуудын амьдрал задарсан баян л биш бол нийтээрээ сул дорой байгааг харуулж байгаа болов уу. Тэгээд мөн ядуугийн хажуугаар нэг өрхөд дор хаяж нэг өвчтэй хүн байгаа нь хачирхалтай. Хүмүүс өвчнөө эхэн үед нь үзүүлэх боломжгүй явсаар тартагт нь тулгаж хэвтэрт ороод байгаа бололтой. Инфляцын галзуурсан өсөлттэй энэ цагт айлд нэг л өвчтэй хүн байхад тэр өрхийн амьдрал шууд доошоо унаж байх шиг санагдлаа. Өнөө маргаашийн идэх хоол, өмсөх хувцаснаасаа илүүтэй ядуу хүмүүсийн эрүүл мэндийн асуудалд үнэхээр анхаарал хандуулахгүй бол өлмөн зэлмөн амьдрал нь өвчин шаналалд автуулсан байгаа нь эндээс харагдаж байх шиг. Олон жилийн өмнө олгоод мартсан эрүүл мэндийн дэвтрийг нь ядаж ядуу хүмүүст сардаа нэг бөглөж өгвөл яасан юм бэ? Уг нь тэдэнд төрөөс өгч байгаа 21000 төгрөгнөөсөө идэх уухаа хасч байгаад ч гэсэн эмнэлэгт үзүүлбэ гэсэн сэтгэл байдаг юм байна. Даанч эрүүл мэндийн дэвтрээ бөглүүлээгүй болохоор эмнэлэг рүү зүглэхийн ч хэрэггүй учраас өвчнөө зөнд нь орхиж, тартагт нь тулгаад байгаа юм биш үү?

Миний бие өдөр тутмын томоохон сонинд 10 гаруй жил сэтгүүлч хийх хугацаандаа хүмүүсийн аж амьдралыг цөөнгүй сурвалжлан бичиж байсан. “Өрхийн

төсөв” гэсэн буланг хөтөлж 2000 оны эхээр болон дундуур гэр хорооллоор ч, орон сууцны айлуудаар ч хаалгыг нь тогшиж явдаг байсан. Тэр үед цахилгаан, дулааны үнэ байн байн нэмэгдэж, бензин шатахууны хомсдол үүсээд, хүмүүс бухимдалтай хэцүү байсан. Ядуу гэсэн ангилалд багтдаг хүмүүс арай ч өнөөдрийнх шиг ядуугийн хажуугаар өвчин эмгэгт дарлагдаж байгаагүй.

Нийслэлийн дүүрэг бүрт ядуу өрхийн тоо ялгаатай л байгаа байх. Миний сурвалжлага хийсэн Сонгинохайрхан дүүрэг Улаанбаатар хотын хамгийн их ядууралтай, хамгийн олон хүн амтай нь үнэн. Тийм байлаа ч гэсэн алслагдсан гэр хорооллоороо ядуусын амьдрал ерөнхийдөө л иймэрхүү дүр төрхтэй байна гэдгийг хэлье. Хотын дарга, төр, засгийн томчуудаас зориуд гэр хорооллоор яваад үзээсэй гэж хүсмээр байна. Гэхдээ хотын төвтэй айлсан байгаа Зурагт, Дэнжийн 1000 биш, алсхан гараад хараасай. Т.Ганди сайдын Эдийн засгийн форумын үеэр хэлсэн нэг үг надад их таалагдсан. “Баян, ядуугийн ялгааг хэзээ ч уулзахгүй хоёр уулын оргил шиг болгохгүйн тулд ядуу хүмүүст очих халамж үйлчилгээг улам нэмэгдүүлнэ” хэмээн тэрбээр онцолсон юм. Үнэхээр 21000 төгрөг хэрэгтэй байгаа хүмүүст төрөөс үзүүлэх халамж үйлчилгээг хангалттай үзүүлж баймаар.

Дэлхийн банкны Монгол Улс ядуурлаа онилсон бодлого явуулах хэрэгтэй гэдэг зөвлөмжийг алхам тутамдаа сайтар санаж, ажиллах ёстой юм байна, Ганди сайд аа, Баярцогт сайд аа.

Нийгмийн хамгааллын хууль дүрэм амьдрал дээр их зөрчигдөж байна гэж баримттай хэлсэн СХД-ийн 20 дугаар хорооны хэсгийн ахлагч эмэгтэй Нямжавын үгийг би дахин сануулмаар байна. Ноднингоос эхлээд төрөөс ядуу айл бүрт сар тутам 14000 төгрөгийн хүнсний тусламж өгч байна энэ жилээс гэнэт л чимээгүй болчихсон гэнэ. Энэ тусламжийг баян айлын нохой ч тоож идэхгүй 500 төгрөгийн цувдаагаар голоо зогоож суугаа олон ядуу өрх харуулдаж сууна. Нэлээд хэдэн жил өгч чадахгүй байсан юм бол нэг хоёрхон удаа өгөх хэрэг байсан юм уу? Эсвэл урт хугацаанд ядууст хүрэх байсан хүнсний

тусламжийг бололцоотой боломжтой өрхүүдэд хавтгайруулж өгөөд ганцхан жилийн дотор ёроолыг нь харчихсан хэрэг үү? Хоногт хэрэглэх хоол хүнснээсээ шаардлагатай амин дэмээ авч чадахгүй настнууд ядарч, тамирдаж, хүүхэд залуучууд өвчилж, бие бялдар нь давжаарч байгаа нь энэ сурвалжлагаас тод харагдаж байгаа болов уу.

Манай төр, засгийнхныг ядуу, нэн ядуугийн тодорхойлолт, орлого орлуулан тооцох аргачлал зэрэг нэр томъёо төдийхнөөр оролдож суутал нийгмийн нэг хэсэгт өлсгөлөн нүүрлэсэн байна гэж хэлэхэд хатуудахааргүй болжээ. Түлээ нүүрс ядууст өвлийн улиралд том дарамт болдог гэж олон улсын байгууллагынхны хийсэн судалгаанд туссан нь үнэн юм. Дулаарч байгаа болохоор нэг хэсэгтээ нүүрсний мөнгө гэхгүй болно гээд баярлаж байна, ядуус. Түлээ, нүүрсний хөнгөлөлтөд 70 хувийн групптэй хүн хамрагддаг байсан бол одоо 80 хувь болж өөрчлөгдсөн гэнэ. Энэ үзүүлэлтээр олон хүнд юм өргөж болохгүй, даарч хөрч болохгүй өвчтэй хүнтэй өрх хасагдаж, дагжиж хонодог болох нь байна. Халамж үйлчилгээгээ улам боловсронгуй болгох атал яагаад өндөр шалгуур тавьж жинхэнэ эздээс нь холдуулаад байна вэ? Доноруудын зөвлөсөн байгаа оносон халамжийн бодлого гээд тодорхой үг байгаа биз дээ. Яагаад улсад 30 гаруй жил ажилласан хөгшин бүтэл муутай хүүхдүүдээсээ болоод төрийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, мөсний хөндий шиг байшинд өвчин шаналалд автаад, залбираад хэвтэх ёстой юм бэ?



“Mongolian Economy”-гийн асуулт

Монголчууд юун дээр алдаж байна вэ?

Нэг нэгнийгээ хүндэтгэж сур

М.Болд

“Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал/:



-Баг болж ажиллаж чадахгүй байна. Нэг нэгнийгээ хүндэтгэж, бүтээлч уур амьсгалаар ажиллавал амжилтад хүрнэ.

Аливаад багаар ажиллаж, бүтээлчээр хандаж сурах нь чухал

С.Бэхбат

/ТӨХ-ны Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын газрын зөвлөх/:

-Улс төрийн талцал, хувийн эрх ашгийн төлөөх амиа бодсон жалга довны үзэл хөгжилд их саад болж байна. Хэсэг хүмүүсийн дунд үзэл бо длын зөрүү байлаа ч гэсэн аливаад багаар ажиллаж, бүтээлчээр хандаж сурах нь чухал.

Судлаачдын дуу хоолойг сонсдог байх хэрэгтэй

Д.Цэрэндорж

/Монголын менежментийн холбооны ерөнхийлөгч/:

-Хөгжлийн бодлогод нарийн

судалгаа тооцоогүй улс төржсөн байдлаар хандаж байна. Үүнийг засах ажил бол бодлого гэдгээ зөв ойлгохоос эхэлнэ. Politic гэдэг чинь бодлого гэсэн үг шүү дээ.

Харин манайхан улс төр гэж ойлгодог. Улс төрийн хийрхэл хийгээд сэтгэлийн хөдөлгөөнөөр амлалт өгдөг. Улс төрийн намууд төлөвшиж, мэргэжлийн судлаачдын дуу хоолойг сонсдог байх хэрэгтэй.

Төрөө байгуулж чадахгүй алдаад явна

С.Дэлэг

/ШУТИС-ийн багш/:

-Төр, засгийн түвшинд алдаж байгаа алдаа гэх юм бол зөв бодлого боловсруулж, гаргаж чадахгүй тэмтчээд явна. Өнөөдрийг болтол ард түмнийг ядуурлаас гаргах бодлогыг гаргаж чадаагүй л байна шүү дээ. Ядуу байгааг нь мэдэхгүй биш, мэдээд байгаа. Улаанбаатар хот яагаад утаатай болсон бэ?

Хөдөөнийхөн их ирж, хотод хүн амын төвлөрөл бий болсонтой холбоотой. Утаанаас салахын тулд орон сууцжуулахад анхаарахаас гадна хөдөөг хөгжүүлэх хэрэгтэй байна шүү дээ. Хөдөөнийхнийг орон нутагтаа тайван амгалан амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй биз дээ.

Улс орон даяар хэт намчирхдаг өвчин бий болж байна. Дээгүүрээ хоёр намынхан болоод байгаа юм шиг боловч орон нутагт, сумын түвшинд энэ нь үзэн ядалт

болж хувирч байх жишээтэй. Өнөөдрийг хүртэл хүнийхээ оюунд юм хийж чадаагүй байна, манайх. Энэ бүхний эцэст юу бодогдож байна гэхээр бид чинь төрөө байгуулж чадахгүй алдаад яваа юм байна .

Баялгийн салбарын урт хугацааны бодлого алга

Д.Галсандорж

/Монголын экспортлогчдын холбооны гүйцэтгэх захирал/:



-Өнөөдөр Монгол Улсын уул уурхайн салбар эрчимтэй хөгжих хариуцлагатай замын уулзвар дээр байна. Засгийн газар стратегийн томоохон төслүүдийг эзэмших, эдийн засгийн эргэлтэд оруулах хэлэлцээрүүдийг гадаадын хөрөнгө оруулагч нартай байгуулж, зарим төслийн хэрэгжилтийн ажил ид явагдаж байна.

Харамсалтай нь өнөөг хүртэл манай орны эрдэс баялгийн салбарыг урт хугацаанд хөгжүүлэх бодлогын баримт бичиг УИХ-аар батлагдаж гарахгүй, хугацаа алдаж хойшлогдсоор.

Агаарын бохирдол иргэдийн эрүүл мэндийг “хямрааж” байна

Улаанбаатар хотын утаа хүмүүсийн, ялангуяа хүүхдүүдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг Пирли Якоб (Pearly Jacob) <http://www.eurasianet.org/> цахим хуудсанд нийтэлжээ. “Mongolia: Ulaanbaatar Air Pollution Linked to Public Health Crisis” гэсэн гарчигтай түүний нийтлэлийг хүргэе.

Хvний хөл тасардагвй III төрөх эмнэлгийн нярайн уушигны тасгийн эмч Т.Лодон төрөөд ганц хонож байгаа хvгээс хvчилтөрөгчийн гуурсыг авахдаа тун ч баяртай харагдав. Энэ хvгийн зvрхний цохилт сайжирчээ. Харин бусад хvхдийн хувьд цаашид яах нь эргэлзээтэй...

Сvвлийн жилvвдэд Улаанбаатарын төрөх эмнэлгvвдэд төрөлхийн гажигтай, бие султай хvхдvвд төрөх явдал нэмэгдсээр байна. Тагнай нь цоорсон, ясны сийрэгжилттэй, эрхтний хөгжил муутай хvхдийн тоо эрс өсч байгаагийн гол шалтгаан нь агаарын бохирдол байж болохыг 10 гаруй жил ажилласан туршлагатай Лодон эмч хэлэв. Нэгэн судлаач ямар нэг байдлаар гажигтай төрөх хvхдийн тоо сvвлийн 10 жилд 30 хувиар нэмэгдсэнийг илрvвлжээ. Мөн ганц жилийн дотор л гэхэд зvрхний гажигтай төрсөн хvхдийн 56 хувь нь нэг ой хvрээгvй байхдаа нас бардаг болохыг Засгийн газрын судалгаанаас харж болно. Өвлийн урт өдрvвдийн турш нvврс тvлдэг гэр хорооллын оршин суугчдаас болж, нэг сая гаруй хvн амтай Улаанбаатар хот бохирдлын зарим тvвшнээрээ дэлхийд “тэргvвлж” буйг Дэлхийн банкныхан ч онцолсон. ЭМШУИС-ийн Эпидемиологи болон биостатистикийн тэнхимийн эрхлэгч Д.Даваалхам гажигтай төрөлт ганц хvчин зvйлээс шалтгаалан нэмэгдэхгvй ч агаарын бохирдлоос ихээхэн нөлөөлж байгааг тэмдэглэсэн юм. Засгийн газрын Нийгмийн эрvлл мэндийн сургуулиас 1998-2008 оны мэдээлэлд тулгуурлан явуулсан судалгаагаар зvрхний гажигтай төрөх хvхдийн тоо нэмэгдсэн нь нvврс шатаахад гардаг азотын болон хvхрийн давхар исэл хэт их байгаатай шууд хамааралтай болохыг тогтоожээ. Мөн насанд хvрэгсдийг vхэлд хvргэж буй таван гол шалтгааны нэг нь амьсгалын замын vвчин бvгvд сvвлийн таван жилд 45 хувиар нэмэгдсэн байна.

Агаарын бохирдлын тvвшин дээд цэгтээ хvрдэг vвлийн улиралд эмнэлгvвд хэт их ачаалалд дарагддаг тухай Баянгол дvвргийн эмнэлгийн уушигны тасгийн эмч Н.Цэндээхvв ярьсан. Жишээ нь тус эмнэлэг 35 өвчтөн хэвтvвлэх нормоо 45 болгож нэмэгдvвлснээс гадна гадуур эмчлvвлэгчдийн тоо нь хоёр дахин нэмэгдсэн байна. Үнгvрсvн нэгдvгээр сард Ерvнхийлvгч Ц.Элбэгдорж агаарын бохирдлыг “сvйрэл” гээд Засгийн газрын агентлагийг vр дvнтэй ажиллахыг уриалсан билээ. Дэлхийн банк зэрэг хандивлагч байгууллагууд тvлш бага хэрэглэх зуух зохион бvтээх, дулааныг удаан хадгалах материал сайжруулах арга хэмжээ авч, сая сая доллар зарцуулж байгаа нь ямар ч ашиггvй хэмээн зарим эрvлл мэндийн мэргэжилтэн vзэж буй. Судлаач Э.Алтангэрэл

“Оршин суугчид сайжруулсан гээд байгаа зуух, тvлшийг авах vгvйгээ мэдэхгvй эсвэл худалдан авах бололцоогvй байдаг” гэв. Шvнийн цагаар 6000 vрхvд цахилгааныг 50 хувь хямдруулж, улмаар цахилгаан халаагуурын хэрэглээг нэмэгдvвлэх шинэ санаачилга гарсан ч Эрчим хvчний зохицуулах газраас сvлжээний хуваарилалтыг нэмэгдvлж, сайжруулахад 200 сая ам.доллар шаардлагатай талаар мэргэжлийн хvмvвс ярьж байна.

2010 оны арванхоёрдугаар сард батлагдсан “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хууль”-д шинэ дvрэм журамд захирагдаагвй иргэдийг торгох, харин бохирдлыг бууруулахад оролцож буй хувь хvн болон бизнес эрхлэгчдэд шахмал тvлшний vнийг бууруулахаар заасан байна. Хэдийгээр vр дvн хэрэгжилтийн хувьд нэгэнт тогтсон их хэрэглээ болон улсын хязгаарлагдмал нvцvд том сорилт болох ч Улаанбаатар хотын агаарыг цэвэршvлэхэд энэхvв хууль vр дvнгээ vгнv гэж ажиглагчид итгэж байгаа. Судлаач Алтангэрэл “Бид нийслэлийн агаарын бохирдлоос vвдэн ямар нэг байдлаар vвчтэй болохоосоо vмнv зарим зохицуулалтын бодлоготой боллоо” гэсэн юм.

... Ээжээ ээжээ
утааны багаа
зүүгээрэй, би
хордлоо шүү ...



Хоёр дахь жилдээ болсон Монголын эдийн засгийн чуулганы үеэр энэ зураг төрийн ордны их танхимын хоёр дугаар давхарт гурван өдөр байрласан юм.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг арилгахад ямар хугацаа хэрэгтэй вэ?

Манай сэтгүүл энэ дугаараасаа эхлэн “Үзэл бодол” гэсэн шинэ булан нээлээ. Энэ булангаараа дамжуулан эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн санал бодлыг уншигчдадаа хүргэхэд чиглүүлэх юм. Манай анхны дугаарт дэд бүтцийн эксперт Ц.Түмэнцогт агаарын бохирдлын талаар үзэл бодлоо илэрхийллээ.



Ц.Түмэнцогт
/Дэд бүтцийн эксперт/

Улаанбаатар хот цаг агаарын хувьд дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд тооцогддог бөгөөд агаарын бохирдлын хувьд ч мөн тэргүүлж байна. Ихэнх агаарын бохирдуулагч бодисын агууламж Монгол Улсын болон олон улсын хэмжээний байх ёстой норм хэмжээнээсээ аль хэдийнэ хэтэрсэн үзүүлэлттэй яваа. Ялангуяа бичил тоосонцор (англиар particulate matters (PM))-ын агууламж онцгой анхаарал татаж байна. Мэргэжлийн бус хүмүүст тайлбарлахад, PM бичил тоосонцор нь хүний эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөтэй, амьсгалын, мөн зүрх судасны өвчнүүдийн эх үүсвэр болохоос гадна хүн амын наслалтын хугацааг богиносгодог нь тогтоогдсон. Сүүлийн жилүүдэд хийсэн хэмжилтүүдээс үзвэл, Улаанбаатар хотын бичил тоосонцор PM-ийн жилийн дундаж агууламж Монгол Улсын агаарын чанарын стандартын хэмжээнээс 6-20 дахин их байна. Дашрамд хэлэхэд, Монгол Улсын агаарын чанарын стандарт нь олон улсын эрүүл мэндийн байгууллагын хэмжээнээс доогуур байдаг юм байна. Олон улсын экспертүүдийн тооцоолсноор ийм хэмжээний агаарын бохирдол нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 12, Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувьтай тэнцэхүйц хэмжээний эрүүл мэндийн зардал гарч байгааг тогтоожээ.

Мөн судалгаагаар амьсгалын замын өвчлөлийн хэмжээ эрс нэмэгдсэнийг тоо баримттай үзүүлсэн нь Улаанбаатар хот амьдрахад хэр таатай орчинтойг



харуулж байна. Энэ байдал нь Засгийн газар, хувийн хэвшил, түншүүд болон иргэд хамтран яаралтай арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна. Мөн сэтгэл амар суух боломжгүй болсныг харуулж байна. Тэгэхээр гадаадын туршлагаас суралцах, олон нийтийн агаарын бохирдлын талаар танин мэдүүлэх арга хэмжээг авах нь чухал байна.

Агаарын бохирдлыг эх үүсвэрийн хувьд гэрийн зуух, нам даралтын халаалтын зуухнууд, цахилгаан станцууд, шороон замууд, ил задгай хог, ногоон байгууламж хязгаарлагдмал байгаа дээр хот төлөвлөлт, гэр хорооллын эмх замбараагүй суурьшилт ч мөн нөлөөлдөг байна. Иргэд хөдөөнөөс хот руу жил бүр мянган мянгаараа шилжин суурьшиж байгаа бөгөөд хот төлөвлөлт, суурьшилтыг боловсронгуй болгохгүй бол энэ байдал үргэлжлэх төлөв ажиглагдаж байна. 2007 оноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн тодорхой ажлууд хийсээр ирсэн болно. Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газраас холбогдох байгууллагуудтай хамтран агаарын бохирдлын өнөөгийн байдал, учир шалтгаан, авч болох арга хэмжээ, гарах үр дүнгийн талаар багагүй ажил хийж, төсөл арга хэмжээнүүд нь түрүүчээсээ хэрэгжиж эхэлсэн. Хамгийн гол нь ганцхан арга хэмжээ аваад шийдвэрлэх боломжгүй цогц асуудал тул боломжтой бүхий л арга хэмжээг дайчилж байж үр дүнд хүрэх нь тодорхой болсон. Болдогсон бол маш хурдан агаарын бохирдлоос салах сонирхол байвч санхүүгийн боломж, хэрэгжих хугацаа, иргэдийн орлого зэрэг бодит хүчин зүйл нөлөөлсөөр байна. Ойрын 2-3 жилийн хугацаанд хэрэгжих боломжтой арга хэмжээнд илүү бүрэн шаталттай гэрийн зуух, гэрийн болон орон сууцны дулаалгыг сайжруулах, төрөл бүрийн цэвэр түлш рүү шилжих зэрэг болно.

Дэлхийн банкны тооцоолсноор гэр хорооллын халаалт, дулаан алдагдал, түлштэй холбоотой асуудлыг бүрэн шийдвэрлэж чадвал



агаарын бохирдлыг 50 хувь хүртэл бууруулах боломжтой гэсэн тооцоо гарчээ. Энэхүү арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн хажуугаар Засгийн газар, Улаанбаатар хотоос дунд болон урт хугацааны арга хэмжээ болох төвлөрсөн дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэх, орон сууцжуулах, хувийн хэвшилд өртөг багатай орон сууцыг барьж байгуулах хөшүүргийг бий болгоход анхаарлаа хандуулах шаардлагатай. Гэр хорооллын иргэдийг орон сууцжуулахад иргэдийн орлогоос шалтгаалан тодорхой хугацаа шаардлагатай тул хотынхоо амьдрах орчинг сайжруулах ажлууд

орхигдох ёсгүй билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нийслэлийн агаарын бохирдлын асуудалд анхаарлаа хандуулан гамшгийн байдалд хүрсэн энэ асуудлыг шийдвэрлэхэд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хуулийг санаачлан батлуулсан нь цаг үеэ олсон дээд түвшиндээ энэ асуудлыг шийдвэрлэх хүсэл эрмэлзэл байгааг харууллаа. Энэ оны хоёрдугаар сард батлагдсан энэхүү хуулинд гэр хороололд агаарын чанарыг сайжруулах бүсүүдийг тогтоох, энэхүү бүсүүдэд түүхий нүүрсийг хэрэглэхгүй байх, газрын гүний дулаан, цахилгаанаар

халаах, хагас кокс, хийн түлшийг ашиглах, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, стандартын хэмжээнд орон гэрээ дулаалсан өрхүүдэд урамшуулал олгох, орон сууцжуулах бодлогыг дэмжих, ажлын байрыг бий болгох зэрэг тодорхой асуудлыг хуульчилж өгсөн болно.

Өнөөдрийн байдлаар Мянганы сорилтын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Японы Олон улсын хөгжлийн агентлаг зэрэг гадаад түншүүдээс ойролцоогоор 47 сая ам.долларын төсөл арга хэмжээнүүд хэрэгжих шатандаа явж байна. Хувийн компаниуд мөн нийгмийн хариуцлагаа ухамсарлан төрөл бүрийн санаачлага гаргаж ажиллаж эхэллээ. Энэхүү хувийн хэвшлээс гарч буй санаачлагыг Засгийн газраас дэмжиж, татварын ч юм уу хөнгөлөлтийг үзүүлж хөхүүлэн дэмжвэл улам үр дүнгээ өгөх болно.

УИХ-аас “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийг саяхан баталсан бөгөөд энэхүү хөтөлбөрт орон сууцны, дэд бүтцийн, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн олон төсөл арга хэмжээг багтаасан нь бий.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ойролцоогоор 18 их наяд төгрөг буюу манай улсын гурван жилийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай билээ. Харин ач холбогдлын хувьд улс төрийн амлалтууд илүү жин дарж байгаа тул ойрын хугацаанд энэхүү хөтөлбөр хэрэгжих магадлал бага байна. Ямар ч байсан төлөвлөсөн арга хэмжээнүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, ойрын хугацааны арга хэмжээнүүдийг даруй хэрэгжүүлэхийн зэрэгцээ дунд болон урт хугацааны арга хэмжээнд анхаарч ажиллах нь хамгийн боломжит хувилбар мэт харагдаж байна.

Тухайн үедээ Лондон хотын агаарын бохирдлыг бууруулахад 10 орчим жил шаардагдсан байдаг. Улаанбаатарын хувьд яаралтай арга хэмжээнүүдийг харилцан уялдаатайгаар нэн даруй авч хэрэгжүүлэхгүй бол түүнээс ч удаан хугацаа шаардлагатай байж мэднэ. Тэр болтол Улаанбаатар хотын иргэд эрүүл мэндээрээ хохирч, төлөөсийг нь төлөхөөс өөр сонголт алга байна.



ДОХИОЛЛЫН СИСТЕМ

Телефоны шугам, интернэт, GSM, GPRS системийн сүвгийг ашиглан дохиоллын өгөгдөл болон дүрсийн сигналыг SMS, MMS-аар дамжуулах, цахилгаан хэрэгсэлийг удирдах иж бүрдэл

ПОЛВЕР
СТАЦИОНАРИ
РАДИО



Оюу Толгой Монголын хөгжилд юу авчрах вэ?

Брижет Сторри (олон улсын сэтгүүлч)

Оюу Толгой төслийн Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй болон үзүүлэх нөлөөний талаарх судалгаанд үндэслэн олон улсын сэтгүүлч Брижет Сторригийн бичсэн нийтлэлийг орчуулан хүргэж байна.

Улаанбаатар хотын өмнөд хэсэгт орших Ерөнхийлөгчийн өргөөнөөс хотын төв хүртэл ердөө зургаан км. Энэ зам саяхан шинэчлэгдсэн Маршалын гүүрээр дайрч, тансаг зэрэглэлийн Маршал хотхон, Олон улсын сургуулийн өргөтгөл барих гэж байгаа газрын хажуугаар өнгөрнө. Төмөр замын гарам гатлангуут Монголын Диснейлэнд болох Хүүхдийн парк зүүн гар талд байх. Хүүхдийн паркийг өнгөрсөн жил шинэчилж, шарилжинд баригдсан уйтгартай талбайг өөрчилжээ. Километр гаруй яваад зам Энхтайвны өргөн чөлөөтэй нийлэх агаад эсрэг талд нь Сүхбаатарын талбайн дэргэд Луи Вуиттоны тансаг дэлгүүр бий.

Зам зуур борооны дараах мөөг адил сүндэрлэн босч буй орон сууцны барилга дээр ажиллаж байгаа өргөгч цамхгийг тоолбол 50 хол давна. Энэ бол маш хурдтай өөрчлөгдөн хөгжиж буй Улаанбаатар хотын дүр төрх. Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд 2009 оны сүүлээр гарын үсэг зурснаар гадаадын хөрөнгө оруулалт огцом нэмэгдэж хот өргөжин хөгжих боломж нэмэгджээ.

Заримбаримтаасдурьдахад, Үндэсний статистикийн хорооны мэдээллээр модон хаалга болон цонхны үйлдвэрлэл өнгөрсөн оны нэгдүгээр сартай харьцуулбал 258, зүссэн банзных 300 хувь нэмэгдсэн бол цементийн үйлдвэрлэл даруй нэг дахин өсчээ. Зөвхөн барилгын ажил нэмэгдээд зогсохгүй, Улаанбаатар хотын зоогийн газруудын нийт орлого өнгөрсөн оны эхэн үеийнхээс 800 хувиар өссөн үзүүлэлт ч байна. Энэ бүх өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлийн тухайд шинжээчид бараг эргэлзэхгүй байгаа юм. Австралийн эдийн засагч доктор Брайн Фишер “Энэ үйл явцын үндэс уул уурхай гэдэг нь маш тодорхой” гэж дүгнэв. Юутай ч өсөлт хөгжлийн ийм таатай үйл явц цаашид ч удаан үргэлжлэх нь тодорхой.

Доктор Фишер болон Монголын эдийн засагчид Оюу Толгой төслийн Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн цогц үнэлгээг саяхан хийж дуусчээ. Рио Тинто компанийн захиалгаар энэхүү үнэлгээг хийхдээ эдийн засгийн салбар хоорондын харилцан нөлөөлөл, уялдаа хамаарлыг шинжилдэг ерөнхий тэнцлийн загварыг ашигласан байна. Уг загварчлал нь эдийн



засгийн хувьд сонгодог хэлбэрийг агуулж байгаа бөгөөд дүн шинжилгээнд ашигласан мэдээллийн цар хүрээ, нарийвчлал зэрэг нь судалгааг онцгой болгож буй. Ийм өргөн цар хүрээтэй эдийн засгийн загварчлалыг Монголд анх удаа хийсэн нь энэ.

Оюу Толгой бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр ирэх 10 жилд Монгол Улсын эдийн засаг жилийн 10 хувийн өсөлттэй байна гэдгийг судалгаа харуулжээ. Тодруулбал, 2020 он гэхэд эдийн засаг хоёр дахин өснө гэсэн үг. Цалин хөлсний хэмжээ бодитой өсөхийн зэрэгцээ валютын ханш тогтвортой болно. Доктор Фишерийн үзэж байгаагаар “хүн бүрийн байр суурийг хөдөлгөх өсөлтийн давалгаа” болох аж. Ингэхдээ тэрхүү давалгаа хэлбэлзэл төсөөлснөөс ч их байх нь. Дээрх загвараар мөн эдийн засгийн үр өгөөжийг тооцоолжээ. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар Оюу Толгойгоос төвлөрүүлэх бүх орлогыг хөрөнгө оруулалт болгосноор офшор сан байгуулах бололцоотой юм. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн Судалгааны хүрээлэнгийн захирал, доктор Б. Түвшинтөгс доктор Фишерийн хамт загварыг гаргасан бөгөөд офшор сан ийм том болно гэж төсөөлөө ч үгүй гэдгээ хэлжээ.

“Хэдийгээр бид тодорхой төсөөлөлтэй байсан ч баялгийн сан ийм ихээр өсөн нэмэгдэх боломжтойг хараад үнэндээ гайхсан. Хэрэв орлогыг бүгдийг нь офшор болговол баялгийн сан 2040 он гэхэд 31-32 тэрбум ам.доллартай тэнцэнэ. Оюу Толгой маш их боломжийг авчирч байгаа гэдгийг би мэддэг ч үнэндээ үр дүн түүнээс их байсан” гэж тэрбээр хэлсэн юм.

Доктор Б. Түвшинтөгсийн хувьд чухам энд л судалгааны үнэ цэнэ оршиж буй. “Энэ том төслийг



<http://www.mongolianeconomy.mn>

хэрэгжүүлснээр эдийн засаг өснө гэдгийг бид бүгд мэдэж байгаа. Гагцхүү хамгийн гол нь ямар өсөлттэй байх вэ гэсэн асуулт хариу нэхэж байна. Харин одоо бид Оюу Толгой эдийн засагт ямархуу хамааралтайг олж харлаа. Их тодорхой болсон гэж бодож байна” хэмээн тэр онцлов.

Тэгвэл энэ бүхэн Монгол Улсад ямар ач холбогдолтой вэ? Брайн Фишерийн дүгнэснээр бол дэд бүтцийн салбарын хөгжилд хамгийн их нөлөөлөх бөгөөд Улаанбаатарт өрнөж буй бүтээн байгуулалт үүний нэг илрэл аж. “Уул уурхай эдийн засгийг өөрчилнө. Уурхайнууд руу нислэг үйлддэг болсноор орон нутагт хөгжил авчирна. Зам, төмөр зам бий болж, түүнийг дагаад барилга байгууламж баригдаж, ажлын байр нэмэгдэнэ гэсэн үг” хэмээн Фишер тодотголоо.

Монголын иргэний нисэхийн үйлчилгээ огцом өсч буйг зөөвөрлөж байгаа зорчигчдын тооноос харж болно. Олон улсын нислэг 38 хувиар нэмэгдсэний зэрэгцээ өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулбал дотоодын нислэг 98 хувиар өсчээ. Доктор Фишер Монголын эдийн засаг өргөн уудам нутагтай, хүн ам цөөтэй, баялаг ихтэй Австралийнхтай адил өсч байгаа гэж үздэг. “Өнгөрсөн долоо хоногт Кантас авиа компани Сидней, Пертын хооронд Боинг 747 онгоц нисгэхээр болсноо зарласан. Хүн амыг нь тооцвол үнэндээ гайхмаар шийдвэр шүү” гэж тэрбээр жишээ татсан юм. Гэхдээ ашигт малтмалаар баялаг, хөгжиж буй орон бүр ийм биш гэдгийг Нигер эсвэл Конгын нөхцөл байдал харуулна. Тэдгээр улсын үндэсний мөнгөн тэмдэгтийн хөрвөх чадвар уламжлалт экспортын бүтээгдэхүүнд дарамт болж, импортыг хямдруулдаг. Эдийн засаг нь дотогшоо чиглэсэн буюу импортоос хамааралтай. Үүнийг

“Голланд өвчин” хэмээн нэрийддэг бөгөөд Рио Тинто дээрх судалгааг хийх болсон үндсэн шалтгаануудын нэг нь энэ. Өөрөөр хэлбэл, судалгаа хийж, загварыг гаргаснаар Монгол Улсын Засгийн газарт эдийн засгаа удирдах, эрсдэлийг бууруулахад дэмжлэг болох юм. “Оюу Толгой маш том учир “Голланд өвчин”-ий шинж тэмдэг гарах магадлалтай. Гэхдээ ашигт малтмалын ухаантай бодлого явуулбал үүнээс сэргийлж болно” гэж доктор Б. Түвшинтөгс сануулсан. Харин доктор Фишерийн хувьд “ашигт малтмалын хараал” гэх нь буруу нэр томьёо аж. **“Газрын гүнд байгаа хөрөнгө яаж хараал болох юм бэ?” гэсэн асуултыг тэрбээр тавиад “Муу бодлоготой байвал л тэр нь хараал болно” хэмээв.**

Б.Түвшинтөгс, Фишер зэрэг бие даасан эдийн засагчид Монгол Улсын Засгийн газарт зөвлөгөө өгөхөөс зайлсхийдэг. Рио Тинто ч ийм зүйл хийдэггүй. “Засгийн газарт юу хийхийг нь бид хэзээ ч заахгүй, тэгэх ч ёсгүй” гэж Оюу Толгой компанийн Бүсийн хөгжил, олон нийтийн харилцааны дэд Ерөнхийлөгч Дэвид Патерсон хэлсэн юм. Тэрбээр “Бид гаргасан загвараа Засгийн газар, эдийн засгийн агентлагууд болон бусад сонирхогч талуудад өгснөөр тэд бодлого боловсруулахдаа ашиглах боломжтой. Ингэснээр Оюу Толгой төслийн Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөний талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломж нээгдэх юм” гэлээ.

Фишер, Б.Түвшинтөгс болон тэдний багийнхан Монголын эдийн засагчдад загварчлалын сургалт явуулж байгаа. Загварыг Монголын эдийн засагт гарч болох өөрчлөлтийн нөлөөллийг тооцож гаргахад ашиглаж болох агаад Засгийн газар ирээдүйд дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулахад тусламж болох ажээ.

“Оюу Толгой эдийн засагт маш том нөлөө үзүүлнэ. Гагцхүү мөнгө санхүүгийн сайн бодлого болон орлого зарцуулалтад гол анхаарлаа хандуулах ёстой” хэмээн доктор Б. Түвшинтөгсийн хэлснийг энд дурдууштай. Тэр Монгол Улсын замнаж буй чиглэлийг хадгалахыг хүсч байгаа нэгэн. Түүний хэлснээр гадаадад ажиллаж буй найз нөхөд нь бүгд эх орондоо эргэж ирэх тухай ярьдаг болжээ. Монгол Улсад сайхан амьдрах нөхцөл бүрдэж, боломж нээгдэж эхэллээ гэдгийг тэд олж харсан байна.

“Их цэвэрлэгээ”


Д.Мөнхчимэг

Монголын Топ 20 дэлхийн хамгийн өсөлттэй индексээр шалгарсан билээ. Гэвч баярлахад эрт байна. “Хүмүүс ямар ч мэдээлэлгүйгээр хувьцаа авч байна шүү дээ” хэмээн Компанийн засаглалын хөгжлийн төвийн захирал Ж.Үнэнбат Монголын эдийн засгийн форумын үеэр анхааруулсан юм.

Үнэхээр Монголын компаниудын хувьцааг авах сонирхолтой хөрөнгө оруулагчид нүдээ аньж байгаад мөнгөө өгөхөөс өөр аргагүй. Дараа нь юу болохыг тэнгэр л мэднэ. Яагаад гэвэл манай компаниудын ихэнх нь ил тод байдал гэдгийг ор тас мартсан. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 336 компаниас 33 нь л 2010 оны санхүүгийн тайлангаа ирүүлсэн бол ердөө 19 нь ногдол ашиг тараажээ.

Та дэлгүүрт ортол хаана, хэзээ үйлдвэрлэсэн нь тодорхойгүй, ямар орц найрлагатай нь мэдэгдэхгүй бялуу зарж байвал тэрийг авч иднэ гэсэн бодол орж ирэхгүй нь лавтай биз ээ. Гэтэл Монголын хувьцаат компаниудын ихэнх нь яг л ийм бүтээгдэхүүн санал болгож байна шүү дээ. Санхүүгийн тайлангаа гаргахгүй, хувь нийлүүлэгчдийн хурлаа товлохгүй, ногдол ашгаа тараахгүй байх нь энүүхэнд. Бүр хаана байршиж байгаа нь тодорхойгүй, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь эргэлзээтэй “сайхан гар”-ууд Монголын хөрөнгийн биржээр дүүрэн хөглөрч байна. Ийм байхад хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаална гэдэг бүтэхгүй даваа. Тиймээс Монголын хөрөнгийн биржид “цэвэрлэгээ” хийж, хувьцаат компаниудыг шинээр бүртгэх саналыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргаад байгаа юм. Ингэж байж л хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх, компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах нөхцөл бүрдэхийг олон мэргэжилтэн сануулж буй.

Ингэхэд компанийн засаглал ямар хэрэгтэй юм бэ? “Компаниуд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байж л хөрөнгө татаж чадна. Харин энэ нөхцөлийг компанийн засаглал бүрдүүлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалдаг гэх үү дээ. Угаасаа мэдээллийн ил тод бөгөөд бодитой байдал нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд маш чухал. Хөрөнгө оруулагчид мэдээллээр л тэжээгдэж байдаг юм. Үүнд л компанийн засаглалын ач холбогдол оршино” хэмээн Ж.Үнэнбат тайлбарлав. Өөрөөр хэлбэл, компанийн засаглалын тулгын гурван чулуу нь шударга, хариуцлагатай, ил тод байдал ажээ. 1990-ээд оноос дэлхий даяар тархаж эхэлсэн компанийн засаглал гэх ойлголт Монголд орж ирээд удаагүй байна. Тодруулбал, 2007 оны сүүлчээр Санхүүгийн зохицуулах хорооны хурлаар “Компанийн засаглалын кодекс”-ыг баталсан байдаг. Харин хэрэгжилтийн




тал дээр хэлэхэд ч ичмээр дүр зураг ажиглагдах аж. Саяхан Засгийн газар Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэлэлцэн баталлаа. Гэхдээ энэ ойлголтыг Монголд нутагшуулахын тулд төр өөрөөсөө эхэлж “цэвэрлэгээ” хийх хэрэгтэйг учир мэдэх хүмүүс анхааруулж буй. “Компанийн засаглал нь зөвхөн хувьцаат компани гэлтгүй банк, олон нийтийн болон төрийн байгууллага гээд бүгдэд хамаатай” хэмээн Ж.Үнэнбат онцолж байна.

Гэтэл өнөөдөр төрийн өмчит компаниудын хэд нь ашигтай ажиллаж байна вэ? Тэдний ТУЗ-ийг хэн ямар шалгуураар томилдог билээ? ТУЗ ямар нэгэн хариуцлага хүлээж чадаж байна уу? гэх мэт асуулт шил шилээ даган хөврөх нь лавтай.

“ТЭЦ IV” компанийн захирал Б.Цэвээн “ТУЗ-ийн гишүүд хурал дээр ирдэггүй. Ирлээ ч бүтээлчээр ханддаггүй. Гэтэл ажлаа үнэлүүлмээр байна шүү дээ. Буруу ажиллаж байвал зэмлүүлмээр байна” хэмээн Монголын эдийн засгийн чуулганы хүрээнд зохион байгуулагдсан “Компанийн засаглал” сэдэвт салбар хуралдааны үеэр тэмдэглэв.

Өнөөгийн төрийн өмчит компаниудад бэлгэдэл төдий ТУЗ ажиллаж, хариуцлага хүлээх ямар ч чадваргүй байгааг Төрийн өмчийн хорооны даргын зөвлөх Д.Байлхүү хүлээн зөвшөөрч, “Компанийн эзэн төр байсан ч ТУЗ нь буюу менежмент нь хувьчлагдсан байх ёстой” хэмээн тун ч оновчтой хэлсэн юм. Харин “Монгол” дээд сургуулийн захирал Н.Дашзэвэг “Бид төрийн өмчит компанийн удирдлагын томилгоонд

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тоо



анхаарах хэрэгтэй. ТУЗ-ийн есөн гишүүний гурав нь л төрийнх, бусад нь хараат бус захирлуудын зөвлөлөөс томилогдох ёстой” гэсэн санал гаргасан билээ.

“Цэвэрлэгээ”-г яагаад төр өөрөөсөө эхлэх хэрэгтэйг гэрчлэх баримт үүгээр зогсохгүй ээ. Учир нь Монголын хөрөнгийн биржид арилжаалагдаж буй 2.7 орчим тэрбум ширхэг хувьцааны 1.8 гаруй тэрбум ширхэг нь төрийн өмчит хувьцаат компаниудад харьяалагдаж байгаа гэсэн мэдээлэл байна. “Төрийн өмчит компаниудад ямар ч засаглал алга. Тиймээс бид Монголын хөрөнгийн биржид бүртгэлийн шалгуураа өндөрсгөж, түүнийг хангаж чадахгүй байгаа компаниудын арилжааг зогсоох үүрэг өгсөн” хэмээн Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан тэмдэглэв.

1991 оноос төрийн өмчит 520 компанийг ямар ч шалгуургүйгээр бүртгэсэнээс эдүгээ 320 нь үлдээд буй аж. Бусад нь дампуурч, татан буугдсан хэрэг л дээ. Эдгээр 320 компанийн 22 нь 100 хувь төрийн өмчит хэвээрээ, 29 нь төрийн өмчийн оролцоотой байгаа юм. Үлдсэн нь иргэдийн өмчид шилжсэн боловч цөөн тооны хүний гарт оржээ. “Одоо Монголд байгаа компаниудын ихэнх нь төрийн өмчит, эсвэл гэр бүлийнх болчихоод байна. Ийм байхад жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаална гэдэг хамгийн чухал” хэмээн “Монгол 999” үндэсний нэгдлийн ТУЗ-ийн ажлын албаны дарга Б.Аюуш онцолсон юм.

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооныхон Азийн хөгжлийн банкныхантай хамтарч “Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах нь” сэдэвт судалгааг 2009 оны сүүлчээр хийсэн бөгөөд Монголын хөрөнгийн биржид арилжаалагдаж буй нийт хувьцааны 93.7 хувь нь нэгдмэл сонирхол бүхий цөөн хүний гарт төвлөрснийг олж тогтоосон байдаг. Ийнхүү манай хөрөнгийн зах зээлийг эзэгнэж буй төрийн өмчит болоод “гэр бүлийн” компаниуд хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тал дээр ёстой “НО шүү дээ” гэж байна. ТУЗ-ийн шийдвэрт жижиг хувьцаа эзэмшигчид нөлөөлөх боломжгүй хэмээн дээрх судалгаанд оролцогчдын 94 хувь нь үзжээ.

“336 хувьцаат компанийн 86 хувь буюу 288 нь сүүлийн хоёр жил дараалан үнэт цаасны бүртгэлийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй. Эдгээрээс 72 хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг зогсоолгох, цаашид бүртгэлээс хасуулах саналыг ойрын хугацаанд

Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхээр болоод байна” хэмээн Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд мэдэгдсэн байх аж.


2008 онд Санхүүгийн зохицуулах хорооноос хуулиар хүлээсэн үүргээ гурваас дээш жил биелүүлээгүй 166 хувьцаат компанийн арилжааг зогсоосон удаатай. Гэтэл эдгээрээс найм нь арилжаагаа сэргээж, гурав нь татан буугджээ. Харин 22 хувьцаат компани нь хэлбэрээ өөрчилж, ХХК болсон байна. Үлдсэн 133 компанийг одоо хүртэл шалгаж байгааг албаны хүмүүс дуулгав. Ингээд 50-ийг нь цагдаад шилжүүлэхээс аргагүй байдалд хүрсэн бол бусдыг нь цагдаад шилжүүлбэ ч гэсэн материал нь бүрдэхгүй зовоож байгаа гэх. Учир нь зарим “нүүдэлчин” компанийн хаяг байршил нь хүртэл тодорхойгүй, орон нутгаар явж хайсан ч олдохгүй байгаа ажээ.

“Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй компаниудад албан бичиг илгээхэд үл тоомсорлон, хариу өгдөггүй. Ногдуулсан торгуулийг ч төлдөггүй. Яагаад гэвэл манай хувьцаат компаниудын ихэнх нь бодит байдал дээр үйл ажиллагаа явуулахгүй байна. Тиймээс шинэчилсэн бүртгэлийг зайлшгүй хийх хэрэгтэй” хэмээн Д.Баярсайхан учирлав.

Монголд хөрөнгийн зах зээл үүссэнээс хойш ердөө 16 компани л IPO хийжээ. Яагаад манай томоохон компаниуд хөрөнгийн зах зээлээс мөнгө босгохдоо хойрго байна вэ? Зүгээр л монголчуудын хөрөнгийн зах зээлд итгэх итгэл “О” заачижжээ. Шударга, хариуцлагатай, ил тод байдал гэдгийг уландаа гишгэсэн компаниуд өнөөдөр Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа арилжаалж буй юм хойно арга ч үгүй биз. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах ямар нэгэн бодлого, зохицуулалт үнэхээр үгүйлэгдэж байна шүү дээ.

“Хөрөнгийн зах зээлийн механизмыг ажиллуулдаг тос нь мэдээлэл бөгөөд бусад оронд түүний техникийн стандартыг тогтоочихсон, зөвхөн тэр стандартаар мэдээлэл тардаг юм. Энэ мэдээллийг үнэн зөв эсэхийг шалгадаг систем бас байдаг. Манайд энэ стандартыг тогтоохгүй бол та бидэнд хэн ч итгэж мөнгөө өгөхгүй” гэж эдийн засагч Д.Жаргалсайхан “Хөрөнгийн итгэл” нийтлэлдээ онцолсон байдаг. Харин мэдээллийн ил тод байдал нь компанийн засаглалын амин чухал бүрэлдэхүүн билээ.

Ногдол ашиг тараасан компанийн тоо



Хөрөнгийн зах зээл

“Засаглалыг сайжруулна гэдэг гурван сарын ажил биш. Дор хаяж нэг жил шаардлагатай. Эдүгээ мөнгөний дотогшлох урсгал байгаа дээр нь компаниуд бэлтгэлээ хангах хэрэгтэй байна. Засаглал гэдэг хөрөнгө төвлөрүүлэхэд л чухал шүү дээ” хэмээн Б.Аюуш сануулав.

Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ үлэмж ихээр нэмэгдэж байгаагийн зэрэгцээ үндэсний компаниуд ч мөнгөжиж, төсвийн орлого ч өсөх хандлагатай. Манай орны эдийн засаг энэ жил 10 хувиар томорч, цаашдаа ч өсөлтийн хурд саарахгүй байх төлөвтэй. Энэ бүхнээс аж ахуйн нэгжүүд “халбаганыхаа хэрээр хутгах уу, шанаганыхаа хэрээр самрах уу?” гэдэг чухам өөрсдөөс нь шалтгаалах буй за. Товчхондоо, компаниудын удирдлага сайн ажиллаж байж л хөрөнгөжиж чадах билээ.

“Компанийн засаглалын ач холбогдлыг монголчууд сүүлд нь ойлгодог юм болов уу. Энэ нь ямар чухал, ач холбогдолтой болохыг ойлгуулж, мэдрүүлэх хэрэгтэй” хэмээн MCS группийн ерөнхий захирал Ж.Оджаргал хэлсэн юм. Ер нь компанийн засаглалыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэх вэ? “Гол урамшуулал нь хөрөнгийн зах зээлээс илүү их хөрөнгө босгоход л оршино шүү дээ” хэмээн Ж.Үнэнбат учирлав. Үүнээс сайн засаглалтай байх нь тухайн компанийн үйл ажиллагаанд л хэрэгтэй гэсэн хялбар тодорхойлолт урган гарч байгаа юм. Тэгвэл яагаад Монголын аж ахуйн нэгжүүд Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхгүй байна вэ?

“Мэдээж хуулийн хэрэгжилт, түүнд тавих хяналт чухал. Гэхдээ тэр хуулийг хэрэгжүүлэх хүмүүсийн чадавч буюу захирлуудын мэргэжлийн мэдлэг, чадвар бүр чухал юм. Компанийн засаглалын ач холбогдол, үр өгөөжийг мэдэхгүй захирлууд хэчнээн сайн кодекс байлаа ч дагаж мөрдөх нь юу л бол” хэмээн Олон улсын компанийн засаглалын форумын тэргүүн

Филипп Армстронг тэмдэглээд “Тиймээс захирлуудыг яаж ийгээд сургах хэрэгтэй. Засаглалын тухай сайн сурталчилах ёстой” гэсэн юм. “Манай өмчийн эзэд компанийн засаглалын талаар ямар ч ойлголтгүй байна” хэмээн Д.Баярсайхан анхааруулсан бол сургалт, сурталчилгааны ажилд анхаарал тавих шаардлагатайг Ж.Үнэнбат хүлээн зөвшөөрөв. “Хатуу шаардлага тавихаас эхлээд компаниудын рейтингийг тогтоож урамшуулах гээд компанийн засаглалыг сайжруулах олон механизм байдгийг Филипп Армстронг мөн тайлбарлалаа.

АНУ компанийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хуулийн тогтолцооны хэрэгжилтээрээ дэлхийд тэргүүлэгч билээ. Тэгвэл тус улс арга хэмжээ авсан зөрчлүүд болон оноосон торгуулийн хэмжээгэрээ бусад орноос хол түрүүлж байгааг сануулах нь зүйтэй болов уу. Гэтэл манайд зөрчил илэрсэн тохиолдолд ямар хариуцлага оноох нь тодорхойгүй. Ямар сайндаа л Санхүүгийн зохицуулах хорооныхон хувьцаат компаниудаа орон нутгаар хайж явах вэ дээ. Тэгээд ч олдоогүй аж ахуйн нэгжүүдийг бүртгэлээс эргэлт буцалтгүйгээр хасчих эрх энэ байгууллагад алга.

Өнөөдөр бид үсрэнгүй хөгжлийн гараан дээр ирээд байгааг шинжээчид тэмдэглэж буй. Хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг эрчимжих нь нэгэнт тодорхой болсон ийм үед хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх тал дээр төр, засаг анхаарч эхлээд байна. Гэхдээ Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын 86 хувь нь хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа өнөө үед бид хөгжлийн тухай мянга ярилаа ч ямар нэгэн үр дүн гарна гэж үү? Энэ нь төмс тарьчихаад алим ургахыг хүлээж суухтай адил бус уу? Дээрх бүх асуудлыг цэгцэлж, “их цэвэрлэгээ” хийж байж гэмээнэ компанийн засаглалын үрийг тарих үржил шимтэй хөрс

Зөвлөгөө

Та хэрхэн хувьцаа эзэмших вэ?

Хувьцаа эзэмшихийн тулд та үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд хувийн данстай байх хэрэгтэй.

Хэрэв та хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцаа худалдан авч эзэмшсэн бол өөрийн анх бүртгүүлсэн брокер дилерийн компанид хандаж дансаа нээлгэнэ.

Хэрэв та шинээр данс нээлгэх бол Монголын хөрөнгийн биржийн гишүүн брокер дилерийн компаниудаас өөрийн сонголтоо хийж болно.

Сонголт хийхэд дараахь зүйлсийг анхаарна уу. Үүнд:

1. Дансны хураамж
2. Арилжааны гүйлгээний шимтгэлийн хувь
3. Үйлчилгээний төрөл
4. Байршил, холбоо харилцаа
5. Үйл ажиллагааны тасралтгүй байдал

Та брокер дилерийн компанид данс нээлгэхийн тулд иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах бичиг баримтаа авчрах шаардлагатай бөгөөд данс нээлгэж дансандаа хөрөнгө байршуулснаар та үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй болох юм. Хувьцаа худалдаж авахын өмнө дараахь зүйлсийг анхаарах хэрэгтэй.

Үүнд:

1. Үнэт цаасны зах зээлийн ханшийн талаарх мэдээлэл
2. Компанийн үйл ажиллагаа
3. Компанийн санхүүгийн тайлан
4. Ногдол ашиг тарааж байсан эсэх
5. Захиалга биелэх хугацаа
6. Удирдлагын менежмент
7. Салбартаа эзлэх зах зээлийн байр суурь зэргийг харилцагч брокер дилерийн компаниасаа заавал лавлах хэрэгтэй.

Хэрэв та хувьцаа худалдан авахаар

шийдсэн бол өөрийн сонгосон брокер диллерийн компанитай худалдах, худалдан авах захиалгын гэрээг хоёр хувь үйлдэх ба нэг хувь нь танд үлдэнэ. Энэхүү гэрээ нь харилцагч болон брокер диллерийн компанийн хооронд ямар нэгэн маргаан гарсан тохиолдолд шийдвэрлэхэд чухал баримт болохыг анхаарах хэрэгтэй.

Өгөөж ба Эрсдэл

Хэрэв таны худалдан авсан хувьцааны ханш өсвөл хувьцааны үнийн өсөлтийн зөрүүгээс ашиг олох, ханш буурвал алдагдал хүлээх болно. Энэ нь хувьцааны хөрөнгө оруулалт өндөр өгөөж буюу ашиг авчрахаас гадна эрсдэл дагуулдаг гэсэн үг юм. Иймд танд сонголтоо зөв хийхийг зөвлөө. Таны зах зээлийн мэдрэмж өндөр байх болтугай. ■

Санхүүгийн салбарыг хурдан хөгжүүлэх нь маш чухал

Харилцан ашигтай хамтарч ажиллах байгууллага хувь хүмүүстэй холбоо хэлхээ тогтоож, Монголын эдийн засгийн тухай ойлголтоо нэмэгдүүлэхээр Монголд ирсэн "ТСХ Fund" байгууллагын дэд захирал Харалд Хэрихофертэй ярилцлаа. Түүнийг Монголын эдийн засгийн чуулганд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн асуудлаар үг хэлэхийг урьсан юм.



Д.Баяр

-Монголын эдийн засгийн чуулганы үр дүнгийн талаарх таны бодол юу вэ?

-Энэ талаар чуулган дээр өргөн хэлэлцүүлэг явагдсан. Монгол Улс нь ялангуяа ашигт малтмалаар баян учир хөгжих боломж ихтэй орон юм. Тус чуулганаар хэлэлцсэн асуудлууд нь энэхүү боломжийг хэрхэн ашиглаж, хөгжихөд чиглэсэн. Эрдэс баялгаар баян бусад орнын туулсан туршлагаас харахад эдгээр нөөц баялаг нь ард түмэнд нь ашиг тус авчрахаас гадна бас бэрхшээл ч авчирч болдог. Ерөнхийдөө байгалийн баялаг ихтэй орнууд асар их хөгжил дэвшил болон дампууралын орчилд орж, эрдэс баялгийн бус эдийн засгийг шахан гаргаж болно. Энэхүү үзэгдэл нь Голланд улсад байгалийн хий нээж илрүүлэхэд ажиглагдсан учир дэлхий дахинаа Голланд өвчин гэж нэрлэдэг. Макро эдийн засаг, хөгжлийн бодлого нь эрдэс баялгаас гарах сайн муу үр дагаврын аль

алиныг нь анхааралтай авч үзэх хэрэгтэй. Сайн цагт нь төсвийн илүүдэл, хөгжил сааруу цагт нь төсвийн алдагдал бий болгох бодлого нь түүхий эдийн үнэ маш бага болох ба экспортын барааны хувьд байгалийн баялгын үнэ цэнийг түр зуур бууруулах зэргээр өөр бусад хүндрэл гарч болох юм. Гэхдээ л Монголын эдийн засагт тодорхой өсөлтийг бий болгоход тусална.

Монголын эдийн засгийн чуулган хүмүүст өөрсдийнхөө санаа зовоосон асуудлыг нээлттэй илэрхийлэхэд маш чухал зүйл болсон гэж бодож байна. Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг байгууллага Монголд төсвийн бодлого эдийн засгийн өсөлттэйгээ урвуу хамааралтай буюу эдийн засаг нь өсөж байхад төсөв маш их хэмжээний алдагдалтай байгаад санаа зовж буйгаа илэрхийлсэн. Одоогийн төсвийн бодлогоор Төвбанкны инфляцийг бага түвшинд барих гэсэн ажлыг маш их

хэцүү болгож байна. Инфляци асар их өсч, одоогоор 14 хувьд хүрээд байгаа бөгөөд цаашдаа ч өсөх хандлагатай байна шүү дээ.

-Монгол Улс хөрөнгө, санхүүгийн шинэ зах зээлд хөл тавьж байна. Энэ талд та ямар зөвлөгөө өгөх бол?

-Монголын эрх баригчид болон хувийн хэвшлийнхний зүгээс эхний ээлжинд барьж авч хийх хамгийн чухал асуудал бол санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх явдал юм. Эрдэс баялгын бус эдийн засгийг, ялангуяа жижиг үйлдвэрлэлийг үр дүнтэй санхүүжүүлэхэд орчин үеийн санхүүгийн зах зээлийн сайн ажиллагаатай орчин маш их хэрэгтэй. Энэ нь Монголын эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн олон талт байдлыг хангахад чухал. Эрдэс баялгийн эдийн засгийг санхүүжүүлэхэд нэлээд хялбар байдаг. Харин ханшийн, цалин хөлсний өсөлт, өрсөлдөх чадварын

доройтлоос болж эрдэс баялгийн бус эдийн засаг санхүүжилтээр дутагддаг. Оновчтой макро эдийн засгийн бодлогоос гадна харьцангуй өрсөлдөх чадвар сайтай бүтээгдэхүүнтэй, мөн үйлдвэрлэлийн, хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой сайхан боломжийг бий болгож байгаа компаниудад санхүүжилт боломжтой эсэхийг нягтлах хэрэгтэй. Эрсдэлийг хуваалцах хэрэгсэл, мөн боломжуудаар хангахад санхүүгийн үйлчилгээ бас чухал байдаг. Жишээлбэл манай "TCX Fund" нь монгол төгрөг болон бусад орны валютын хооронд хүүний түвшний своп солилцоог 3-4 жилийн хугацаатайгаар гадаад валютын ханшны эрсдлийг хуваалцах хэрэгслийг санал болгох замаар иймэрхүү эрсдэл хуваалцах боломжийг хөгжүүлэхийг оролдож байна.

Яагаад эрсдэлийг хуваалцах нь илүү их чухал байгаа юм бэ гэдгийг тайлбарлая. Төвбанкны гол зорилт бол аероер хэлбэл, инфляци тодорхой босгыг давахгүй гэдгийг баталгаажуулах явдал юм. Мөнгөний бодлогоо энэ зорилттойгоо нийцүүлэн гаргадаг. Ерөнхийдөө инфляцийн зорилт хэрэгжсэн үү хэрэгжээгүй юү гэдгийг Төвбанкнаас үнэлсэн үнэлгээтэй холбоотойгоор хүүний түвшинг өсгөх буюу бууруулдаг.

Хүүний түвшин болон инфляци дээр анхаарлаа хандуулан Төвбанк валютын ханшийг илүү хувирамтгай болгож болох юм шиг. Хэрвээ валютын ханш илүү хувирамтгай болох юм бол хүмүүс ханшийн өсөлтийн эрсдэлтэй тулгарч ингэснээр тэдэнд санхүүгийн хувьд эрүүл байхад нь учрах иймэрхүү эрсдлийг хуваалцах буюу бууруулахад илүү их хэрэгсэл хэрэгтэй байх болно.

Яг одоо олон хүн төгрөгийн ханшийг өсөөсэй гэж хүсэн хүлээж байгаа. Гэхдээ энэ нь гарцаагүй нөхцөл байдал биш бөгөөд саяхны гэнэтийн уналтын тохиолдлыг хүмүүс сайтар санаж байгаа билээ. Тийм учраас хүмүүс болон аж ахуйн нэгжүүд болгоомжтой байж валютын ханшийн савалгаанд өртөхгүй л байгаасай гэж бодож байна. Тэд

байнгын өсөлттэй байлгахын тулд валютын ханшаар наймаалцаж болохгүй. Эрсдэлийг хуваалцах хэрэгслийг хөгжүүлэхийн тулд нэг чухал алхам хийх хэрэгтэй. Энэ нь дотоодын валютад хүүний жишиг түвшинг бий болгох явдал юм. Засгийн газраас бонд буюу вексель гаргах ба 2-3 жилд аажмаар үр өгөөжөө өгөх замаар үүнийг хийдэг.

-Манай Засгийн газраас Монголын хөрөнгийн биржийг гадаадын багаар удирдуулах гэж байгаа?

-Найдвартай байхын тулд санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг сайн бөгөөд ил тод удирдах явдал чухал. Би хувьдаа Монголын санхүүгийн салбарын хөгжилд гадаадын санхүүгийн байгууллагуудын оролцоо хэрэгтэй байж болох юм гэж үзэж байгаа. Ингэснээр орчин үеийн техник технологи хурдан шуурхай нэвтэрнэ. Танай улсад. Монголын хувьд сайн ажиллагаатай санхүүгийн салбарыг хурдан хөгжүүлэх нь маш чухал гэж би дээр хэлсэн. Хэрвээ гадаадын хөрөнгө оруулагчид өөрийн хувь нэмрээ оруулж чадах юм бол тэднийг хүлээн авч энэ нь мөн хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд ч сайнаар нөлөөлөх болно.

-Монголын ашигт малтмалын салбарт гадаадын хөрөнгө оруулалт маш ихээр орж ирж байна. Үүнтэй холбоотой ямар эрсдэлүүд гарч болох вэ?

-Танай баялаг одоогийн болоод ирээдүй хойч үедээ аль алинд нь ашигтай байх арга замаар л эдийн засгийн эргэлтэд орох нь хамгийн чухал сорилт юм.

-Таны Улаанбаатарт ирсэн гол зорилго юу байсан бэ?

-Танай эдийн засгийн хөгжлийг өөрийн биеэр ирж үзэх, мөн ирээдүйн харилцагч нартайгаа холбоо хэлхээ тогтоохоор ирсэн. Энд бид

валютын ханшийн хөджийн хэрэгсэл санал болгож байгаа бөгөөд хэд хэдэн банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар ярилцаж байна.

"TCX Fund" нь ихэвчлэн хөгжлийн банк болон хөгжлийн байгууллагууд болох 20 гаруй хувь нийлүүлэгчээс бүрдсэн хамтарсан байгууллага юм. Зарим нь Монгол Улсад төлөөлөгчийн газартай. Голландын EBRD, KfW, JBIC, FMO байгууллагууд манай хувьцаа эзэмшигчдийн дунд байдаг. Валют солилцооны сангийн зорилго нь тухайн орны валютаар зээл олгох болон хөгжлийн зээллэгээс валютын ханшийн эрсдэлийг үүрэхийг дэмжих явдал юм.

Бид хэрэв ерөнхийдөө дээр дурдсан санхүүжилтээс үүссэн валютын ханшийн эрсдэл олон оронд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагаар удирдуулбал хөгжил жигд явах болно гэж үзэж байна. Хатуу валютын орлогогүй жижиг зээлдүүлэгч буюу жижиг дунд үйлдвэрлэл байж болно. Валют солилцооны сан нь валютын ханшны эрсдэлийг дэлхийн түвшинд өөрийн хувьцаа эзэмшигчдээс нэгтгэдэг учир бид маш үр дүнтэй валютын ханшийг удирддаг хэрэгсэл юм. Бид нэлээдгүй амжилттайгаар үүнийг өнгөрсөн гурван жилийн турш хийж байна.

-Та Монголд анх удаагаа ирж байна. Манай улсын талаарх таны сэтгэгдэл ямар байна вэ?

-Би хурдан өөрчлөгдөж буй нийгэм, бас олон боломжийг харж байна. Танай ард түмэн мянга мянган жилийн түүхтэй тодорхой амьдралын хэв маягаар соёлын хэм хэмжээг бий болгосон. Одоо энэ бүхэн хурдан өөрчлөгдөх болно. Соёлын хэм хэмжээ нь техникийн болоод эдийн засгийн өөрчлөлтийг ерөнхийдөө удаан хүлээн авдаг гэдгийг бид мэднэ. Энэ бол түүхийн маш сонирхолтой үе байх болно. Харамсалтай нь би хөдөөгүүр аялж байгалийн сайхныг үзэж чадсангүй. Гэхдээ энэ нь миний буцаж ирэх сайхан шалтгаан болж байгаа шүү.



Японы эдийн засаг

Цунами

2011 оны III.11. Газар хөдлөлт Токиогийн 15.00 цагт болсон болохоор баасан гаригийн хөрөнгийн захын арилжаанд нөлөөлж амжаагүй. Энэхүү аймшигт явдлын дараа Токиогийн хөрөнгийн бирж хаалгаа барьсан бол хэн ч гайхахааргүй байв. 2001 оны есдүгээр сард террорист халдлага болох үед Нью-Йоркийн арилжааны талбарууд нэлээд хэд хоногоор хаагдсан шүү дээ. Гэтэл япончууд ийм арга заль хэрэглэхгүй байхаар сэтгэл шулууджээ. Токиогийн хөрөнгийн бирж даваа гаригт ажилладгаараа л ажиллав. Үр дүнд нь Nikkei 225 индекс 6.2 хувиар буурсан юм. 2008 оноос хойших хамгийн огцом уналт болсон юм. “Toyota”, “Mitsubishi”, “Honda”, “Sony” зэрэг Наран улсын урдаа барьдаг компаниудын үнэлгээ мэдэгдэхүйц доошилсон бол даатгалын “Tokio Marine” компанийн хувьцааны ханш 16 хувиар навс унасан байна. “Reuters” агентлагийн мэдээлснээр Японы зах зээлийн нийт үнэлгээ энэ ганц өдөрт 286 тэрбум ам.доллараар хумигджээ. Европ, Америк, Азийн голлох индексүүд ч Японд нүүрлэсэн гамшгийн улмаас уруудсан. Мягмар гаригт байдал бүр дордож, Nikkei 225 индекс 10 гаруй хувиар ахиад уналаа. Гэвч лхагва гаригаас Токиогийн хөрөнгийн үзүүлэлтүүд сэргэж эхэлсэн нь алдагдал хүлээсэн трейдерүүдэд “шархаа нөхөх” боломж олгосон гэлтэй.

Японы нийт үл хөдлөх хөрөнгийн 14-17 хувь нь газар хөдлөлтийн даатгалд хамрагдсан байдгийг “AIR Worldwide” компанийн мэргэжилтнүүд сануулаад, цунамигаас үүдсэн хохирлын нөхөн төлбөр 34.6 тэрбум ам.долларт хүрч магадгүйг мэдэгдсэн билээ. Өөрөөр хэлбэл, байгалийн гамшгийн нийт хохирлоос 34.6

тэрбум орчим ам.долларыг нь Японы төр засаг биш, олон улсын даатгалын компаниуд гаргах төлөвтэй. Үүнээс үүдэн “Allianz”, “Munich Re”, “Swiss Reinsurance”, “Hanover Re”, “Admiral”, RSA, “Prudential”, AIG зэрэг даатгалын томоохон компанийн хувьцааны ханш мэдэгдэхүйц урууджээ.

Газар хөдлөлт, цунами, атомын цахилгаан станцуудад нүүрлэсэн аюул... Ар араасаа хөврөх энэ бүх асуудлыг Наран улсын төр засаг, ард түмэн хэрхэн эв нэгдэлтэйгээр, хамгийн гол нь хариуцлагатайгаар даван туулж байгааг бид харж байна. Цунами цөмийн эрчим хүчний салбарт ч сөргөөр нөлөөлөх нь нэгэнт тодорхой болсон. Байгалийн гамшиг нүүрлэх үед ямар ч найдвартай хамгаалалт хүчин мөхөхтөгийг дэлхий ажиглаж байна. Тийм ээ, япончууд 50 гаруй атомын цахилгаан станцынхаа нэгийг ч Чернобыль шиг болгочихгүй авч гарсан. Бөмбөрцгийн анхаарлын төвд ороод буй “Фүкүшима 1” атомын цахилгаан станцын дэлбэрэлт, үнэн худал нь мэдэгдэхээ байсан олон янзын мэдээлэл... Хэдийгээр Наран улс шуурхай арга хэмжээ авч, энэ асуудлын хор хөнөөлийг аль болох бага байхаар шийдвэрлэсэн ч цөмийн эрчим хүчний салбарт итгэх хүн төрөлхтний сэтгэлийг сэвтүүлэх талтайг мэргэжилтнүүд хүлээн зөвшөөрч байна.

Тэнд цахилгаан станцууд дэлбэрлээ л гэнэ. Хэдхэн цагийн дараа эргүүлээд ашиглалтад оруулчихлаа л гэнэ. Ард иргэдээ аврах, тайвшруулах, нүүлгэн шилжүүлэх их ажлын хажуугаар сэргээн босгох, засварлахаа ч амжуулж яваа Японы эрх баригчид ямар чадварлаг, шуурхай арга хэмжээ авч байгааг хүн төрөлхтөн харж



байна. Хэдэн зуун үйлдвэр хаалгаа барьж, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа зогсоож, олон сая хүн усгүй, тоггүй амьдарч, төр засгаа царайчилж сууна. Засаг нь ч тэднийхээ итгэлийг алдсангүй. Эдийн засаг, бизнесийн салбараа ч гаргуунд нь гаргачихсангүй.

Японы Төвбанк эдийн засагтаа эхний ээлжинд 18 их наяд иен буюу 220 тэрбум ам.доллар оруулсан. Энэ ажиллагаагаа хэд хэдэн удаа давтан хийж, нийт 688.3 тэрбум ам.доллар “цутгаад” байгааг “Associated Press” дамжуулсан юм. Орон гэр, идэх хоол, өмсөх хувцсаа алдсан хүмүүс банкнаас хадгаламжаа татаад ирэхээр санхүүгийн салбарт аюул нүүрлэхээс сэргийлж байгаа нь энэ ажээ. Гэвч яаж ч шуурхай арга хэмжээ аваад хүч хүрэхгүй зүйл гэж бас бий. Гамшиг, сүйрлийн араас хөрөнгийн зах зээлийн савлагаа, валютын ханшийн хэлбэлзэл Японы эрх баригчдын “толгойны өвчин” болж буй.

“Их 7”-гийн эрх баригчид гуравдугаар сарын 18-нд хуралдахдаа иенийн ханшийг тогтворжуулах арга замыг эрэлхийлсэн юм. Наран улсад нүүрлээд буй хямралыг хамтдаа давахын тулд эдийн засгаараа дэлхийд тэргүүлэх долоон гүрний төлөөлөл ухаанаа уралдуулж байгаа нь энэ. Францын Сангийн сайд Кристина Лагард тухайн үед “Японы өрийн дарамтыг хэрхэн бууруулж болох талаар бид хэлэлцэж байна” хэмээн учирлажээ. Эдүгээ эдийн засгаараа дэлхийд гуравдугаарт эрэмбэлэгддэг Наран улсын өрийн хэмжээ ДНБ-ээсээ хоёр дахин давсан байгаа. Байгалийн гамшиг энэхүү үзүүлэлтийг улам ч цойлоход хүргэж буй нь нууц биш.

Ямартай ч Японы ард түмэн сэргээн босголтын ажилдаа ханцуй шамлан ороод буй. Энэ нь хэзээ дуусахыг хэлэхэд хэцүү. Гэхдээ усанд урссан байшин барилга, зам, гүүрийг шинээр бий болгохын тулд асар их хэмжээний бетон, асфальт, металл хэрэг болж таарна. Үүнээс үүдэн дэлхийн зах зээл дэх таваарын үнэ өсөх хандлагатайг “UFG Wealth Management” компанийн шинжээч Антон Толмачёв тэмдэглэжээ.

Газар хөдлөлт, цунамигийн үр дүнд Японы ДНБ-ий өсөлт буурна, гэхдээ энэ нь тур зуурын байх хандлагатай гэж Дэлхийн банк таамаглаж байна. “Зүүн Азид Япон улс чухал байр суурь эзэлдэг учир энэхүү эмгэнэлт үйл явдлын үр дүнг бүс нутаг мэдрэх нь дамжиггүй. Гэвч гарах хор хохирлыг зөв тодорхой үнэлэхэд хэтэрхий эрт байна” хэмээн Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийн тэргүүн эдийн засагч Викрам Неру онцолжээ. 1995 оны Кобегийн газар хөдлөлтөөр жишээ татан үзвэл Японы худалдааны бууралт хэдхэн улирал үргэлжилж, нэгжилийн дотор импорт нь бүрэн сэргэж, экспорт газар хөдлөлтийн өмнөх түвшнийхээ 85 хувьд хүрсэн юм. Гэхдээ энэ удаа, үйлдвэрлэлийн сүлжээ, тэр дундаа авто машин, электроникийн үйлдвэрлэлийн тасалдал бэрхшээл үзүүлсээр



Бурхнаас илгээсэн байгалийн эм

Ц.Болормаа

“Бурхнаас илгээсэн эм”, “шингэн алт” гэгдэх чацаргана жимсний тариалалт нэмэгдсээр. Энэ жимсээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолтой газрууд ч олон болж. Монгол чацаргана хэдийнэ өндөр шаардлагатай Япон улс руу экспортод гарчээ. Экспортыг чацарганы өтгөрүүлсэн жүүсний үйлдвэрлэл эрхэлдэг Б.Билгээ эмээгийн компани хийжээ. ХХААХҮЯ-ны холбогдох мэргэжилтнүүдэд өндрөөр үнэлэгддэг тэрбээр хүнсний салбарт 40 гаруй жил хүчин зүтгэсэн. Манай сэтгүүл жижиг, дунд үйлдвэрлэл хийгээд ногоон бизнесийг дэмжин ажиллах үүднээс Билгээ эмээгийн Гэмтлийн эмнэлгийн зүүн талд байрлах “Эко-Эрдэнэ” компанийг зорилгоо. Тэрбээр үйлдвэрийнхээ тоног төхөөрөмжийн загвараа өөрөө гардаж хийсэн болохоороо ноу-хоугаа нэлээд нууцалдаг бололтой. Үйлдвэрийг нь сурвалжлах гэсэн боловч зөвшөөрсөнгүй.

1968 онд Москвагийн Хүнсний үйлдвэр технологийн сургуулийг төгссөн тэрбээр 2004 онд чацаргана боловсруулах тоног төхөөрөмж, “Чацарганы өтгөрүүлсэн шүүс бэлтгэх арга” ашигтай технологийн загвараа боловсруулж өмчлөх эрх авчээ. “Эко-Эрдэнэ”

компанийн үйлдвэр рүү ороогүй ч Билгээ гуайн ярьсныг хүргэе.

Тэд долуулаа. Хэдий цөөхүүлхнээ ч жилд аньс, нэрс, чацаргана гэсэн гурван төрлийн жимсээр дөрвөн төрлийн шүүс, хоёр төрлийн чанамал үйлдвэрлэдэг аж. Нийтдээ жилд дунджаар 100 сая төгрөгийн бүтээгдэхүүн хийдэг байна. 2000 оноос үйлдвэрлэлээ эхэлсэн “Эко-Эрдэнэ” компанийнхан бүтээгдэхүүнээ “Номин”, “Миний дэлгүүр”, “Макс” хүнсний сүлжээ болон “Барс”, “Бөмбөгөр” зэрэг захаар борлуулдаг. Саяхныг болтол түрээсийн байранд байсан тэдэнд экспортын ашиг нь өөрсдийн үйлдвэрлэлийн байртай болоход ихээхэн нэмэр болжээ. Анх Япон руу 2004 онд 10 кг чацарганы шүүс экспортолж байсан бол өдгөө 33 тонн болтлоо нэмэгджээ. Мөн Билгээ гуай Засгийн газрын “Чацаргана” хөтөлбөрт хамрагдаж, зээл авснаар Ар жанчивлангийн ойролцоо чацарганы 1500 суулгац тарьжээ. Ингэснээр түүхий эдийнхээ багахан хэсгийг ч болов өөрсдөө тариалах боломжтой болох аж. Нэг га талбайд 1200-1600 чацарганы суулгац суулгаж нэг бутнаас 7-10 килограмм жимс хурааж, нэг



Б.Билгээ
/ “Эко-Эрдэнэ” компанийн захирал/:

тонн жимснээс 20-50 килограмм тос, 600 литр шүүс болон бусад төрлийн бүтээгдэхүүн гарган авах боломж бий. Харин зардлаа 2-3 жилд нөхөх боломжтой гэсэн. Цаашид тоног төхөөрөмжөө шинэчилж олон шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн гаргах бодолтой байгаагаа ч дурдав. Банкны хоёр болон түүнээс дээш хувийн хүүтэйг бодвол ЖДҮДС-гийн хоёр жилийн хугацаатай, нэг хувийн хүүтэй зээл харьцангуй ашигтай байгаа гэсэн. Түүнчлэн Засгийн газраас хүнсний бүтээгдэхүүний тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлсөн таатай шийдвэр ч гарчээ. Эндээс үзэхэд Монголд төр, засгийн дэмжлэгтэйгээр ашигтай ажиллаж болох нь чацаргана тарьж, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид.

ХХААХҮЯ, Монголын чацаргана үйлдвэрлэгчдийн үндэсний холбооноос 2010-2016 онд чацарганыг 20 мянган га хүртэл талбайд тариалах зорилт тавьсныг дуулгая. Чацаргана жимсийг ингэж онцолдог нь учиртай. Чацарганыг манай орны аль ч бүсэд тариалах бололцоотой. Дээрх чацаргана хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бусад төрлийн жимс жимсгэний тариалалтыг дэмжин улмаар Ногоон барааны тэмдэгтийг нэвтрүүлэх, “Ногоон аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх таатай орчин бүрдэх тухай мэргэжлийн хүн хэлж байсан. Хэрэв уг хөтөлбөр амжилттай хэрэгжвэл “Монгол-Чацаргана” брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, жимс, жимсгэний дотоодын хэрэгцээг 30 хувиар хангах, 20 мянгаас доошгүй хүн ажлын байртай болох нөхцөл бүрдэнэ гэсэн үг.

Одоо харин жимсний хаан гэгддэг чацарганы талаар сонирхуулъя.

Чацаргана С, В1, В2, В9, А, К, В8, Р бүлгийн олон төрлийн витамин болон эрдэс бодис агуулдаг. С витамин агуулгаараа нохойн хошууны дараа буюу хоёрдугаарт ордог байна. Товчхондоо хүний биед хэрэгцээтэй витаминь цогц байдлаар хангаж чаддаг гэсэн үг. Жимс, хальс, үрнээс нь гурван өөр төрлийн тос гарган авч болох ба эмийн үйлдвэрийн үнэт түүхий эд болдог байна. Урд хөршийнхөн чацарганаар олон төрлийн эм хийж 50-800 доллараар зардаг ажээ. Түүнчлэн Өвөр Монголын Бугат хотод чацарганы найрлагатай гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэр байдаг бол япончууд монгол чацарганыг өөрийн орны хөрсөнд нутагшуулах талаар судалж байгаа юм билээ.

Мөн Канадад төвтэй чацаргана судлалын олон улсын байгууллага бий болоод судалгаа хийж байгаа бол германчууд оросуудтай нийлж судалгаа хийж байжээ. Зарим оронд чацаргана тариалдаг ч манайх нэмэлт химийн бордоогүй экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдгээрээ онцлог.

Мэдээллийн гэх тодотголтой өнөө үед химийн гаралтай амт, үнэр оруулагч, будаггүй монгол чацарганыг сонирхох орны тоо нэмэгдсээр. Өөрөөр хэлбэл, зөвхөн дотоодын гэлтгүй гадаадад зах зээлд ч уг жимсний эрэлт их. Манай аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнээ дотооддоо борлуулахад ашгийн татвар, хүн амын татвар төлдөг бол гадныхан мөнгөө бэлэн төлдөг, НӨАТ-өөс чөлөөлөгддөг болохоор экспортлох сонирхол их байдаг юм билээ. Гагцхүү гадныхны стандартад хүрсэн бүтээгдэхүүн гаргах гэдэг хэцүү даваа. Гэхдээ эдийн засгийн ашиг олж, эх орноо сурталчлах нь зүйн хэрэг ч дотоодын хэрэглээгээ бүрэн хангах хэрэгтэй.

Манайд хүн амын физиологийн хэрэгцээт жимс жимсгэний маш бага буюу 0.4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг гэсэн мэргэжилтнүүдийн тооцоо бий. Өөрөөр хэлбэл ихэнхдээ “гадаадаас ирсэн” чанарын баталгаагүй жимс хэрэглэдэг гэсэн үг. Гэтэл тэр нь манай цэвэр хөрсөнд ургасан жимсийг гүйцэх нь юу л бол. Гадныхан манай 500 мл чацарганы шүүсийг хоёр литр усанд найруулж хэрэглэдэг. Харин бид импортын хэзээ үйлдвэрлэж, ямар тээврийн хэрэгслээр ирж, хэр удаан хадгалагдаж буй нь тодорхойгүй жимсний жүүсийг хэрэглэсээр. Харин чацаргана тариалагчдын зарим нь “гурил будаа, үр тариаг ганц намар хураадаг гээд НӨАТ-аас чөлөөлдөг. Чацарганыг ч гэсэн ганц намар л хураадаг шүү дээ. Яагаад адилхан чөлөөлж болохгүй гэж” гомдоллодог юм билээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоогоор насанд хүрсэн хүн жилд дунджаар 87,6 килограмм, өдөрт 240 грамм жимс, жимсгэнэ хэрэглэх нь зохистой гэж үзсэн байна. Манай улсын нэг хүн 2007 онд дунджаар 8,4 килограмм жимс, жимсгэнэ хэрэглэж байсан гэсэн тооцоо бий.





Green energy

Усны эрчим хүчний нөөц

Б.Болдбаатар

/Эрчим хүчний газрын мэргэжилтэн/

Сэргээгдэх эрчим хүчний дундаас усны эрчим хүч хамгийн өргөн хэрэглэгддэг. Байгалийн нөөц хязгаартай тул улс орнууд эрчим хүчний төлөө тэмцэлдэж байна. Цаг уурын өөрчлөлт, байгаль орчны бохирдол, түлш шатахууны үнийн өсөлт зэрэг тулгамдаж буй асуудал нь сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэх, хэрэглэх шаарлага бийг харуулж байгаа. Ялангуяа хямд өртгөөр гарган авч болох усны эрчим хүчний асуудал зүй ёсоор тавигдаж буй. Дэлхийн олон оронд эрчим хүчээ усан цахилгаан станцаас гарган авдаг. 2006 оны байдлаар дэлхийн нийт эрчим хүчний бараг 20, сэргээгдэх эрчим хүчний

ойролцоогоор 88, 2008 онд дэлхийн нийт сэргээгдэх эрчим хүчний 50-иас илүү хувийг усны эрчим хүч эзэлж байв. Бразил, Канад, Шинэ Зеланд, Норвеги, Парагвай зэрэг орон эрчим хүчнийхээ дийлэнхийг усан цахилгаан станцаасаа гаргаж авдаг байна. Норвегид л гэхэд эрчим хүчнийхээ 98-99 хувийг усан цахилгаан станцаас хангадаг гэсэн тооцоо бий.

Манай орны нийт нутаг дэвсгэр дээр нар, салхи, усны эрчим хүчийг хуваарилсан мэт жигд тархалттай байдаг. Тодруулбал Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутагт усны, говь, хээрийн бүсэд нар, салхины эрчим хүчийг ашиглах

боломжтойг сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаанаас харж болно. Монголд усны эрчим хүчний нөөц бий боловч энэ талаарх судалгаа хангалтгүй байдаг аж.



Ногоон эдийн засаг

Усны эрчим хүчийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр ашиглах асуудлыг 1950 оноос эхлэн судалж, нөөцийн анхны үнэлгээг 1960 онд хийж Монголын эрчим хүчний нийт чадлыг 3800 МВт гэж тооцсон байдаг.

Манай анхны УЦС нь 1959 онд Хархоринд Орхон гол дээр баригдсан 528 КВт-ын чадалтай станц юм. Одоогоор бага чадлын 150-2000 КВт-ын есөн УЦС ажиллаж байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд Ховдын Дөргөний 12 МВт, Говь-Алтайн Тайширын 11 МВт-ын дунд чадлын, Завханы Цэцэн-Уулын 150 КВт-ын, Завханмандалын 110 КВт-ын бага чадлын усан цахилгаан станцыг ашиглалтад оруулаад байгаа. Ийнхүү бага чадлын УЦС-ыг ашиглалтад оруулж хөдөөгийн сум, сууринг цахилгаанаар хангах нь цаашид усны эрчим хүчийг ашиглах боломж бийг харуулж байгаа юм.


Монгол Улсын эрчим хүчний системийн 2009 оны оргил ачаалал 695 МВт-д хүрч байжээ. Харин 2010 оны арван хоёрдугаар сарын 15-нд системийн оргил ачаалал 728 МВт-д хүрэхэд ОХУ-аас 70 МВт эрчим хүч импортолсон бөгөөд манай дулааны цахилгаан станцууд бүрэн хүчин чадлаараа ажиллаж байсан. Манай орны хөгжлийн хэтийн чиг хандлагаар 2020 онд оргил ачаалал 1128 МВт-д хүрэх магадлалтай бөгөөд тэр үед импортоор 500 орчим МВт эрчим хүч авахаар байна. Жил бүр ийм хэмжээний цахилгааны чадал авахад хүрвэл эдийн засаг доройтолд орж, шугамын дамжуулах чадвар хүрэлцэхгүй. Иймд төвийн эрчим хүчний системд үүссэн дутагдлыг нөхөх, ачааллыг тохируулах, шаардлагатай үед богино хугацаанд ажилд оруулах боломжтой том чадлын усан цахилгаан станц барьж ашиглалтад оруулах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Мөн “Сэргээгдэх эрчим хүчний тухай” хууль, “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”,

“Сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөр” болон Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан заалтын дагуу эрчим хүчний хангамжийн бүтцийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг багасгах, хөдөө орон нутгийг эрчим хүчээр найдвартай хангах замаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд том болон дунд чадлын усан цахилгаан станц байгуулах шаардлагатай юм. Эрчим хүчний системд усны эрчим хүчний оролцоог нэмэгдүүлэх, сүлжээний доголдлын горимыг сайжруулахад Эгийн голын 220 МВт, Шүрэнгийн 200 МВт, Орхон голын 100 МВт, Ховдын Эрдэнэбүрэнгийн 60 МВт, Хөвсгөлийн Чаргайтын 25 МВт зэрэг усан цахилгаан станцын төслүүд тодорхой үүрэг гүйцэтгэх юм. Дэлхий дахины шинэ хандлага ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд усан цахилгаан станцуудыг байгуулж, хөгжүүлэх нь чухал.



Монгол орны усны эрчим хүчний нөөц



Нүүрсний эрин юу авчрах вэ



Олон жилийн турш зэс, алтны үйлдвэрлэлд дөрөөлж ирсэн Монголын уул уурхайн салбарт нүүрсний зах зээл хүчээ авч, өнгө нэмэх боллоо. Тавантолгой болон бусад нүүрсний ордыг тойрсон чимээ үндэстэн дамнасан корпорациудын хорхойг хүргэн, говийн нутаг руу даллах аж. Үүний зэрэгцээ үндэсний компаниуд өсөн томорч, нүүрс баяжуулах үйлдвэр, дэд бүтцэд хөрөнгө оруулж эхлэв. Монголыг “Нүүрсний Саудын Араб” болно гэсэн Роберт Фрийдландын үг бодит амьдрал дээр биеллээ олж эхэлснийг “Coal Mongolia 2011” чуулга уулзалт бататгасан юм. Анх удаагаа зохион байгуулагдсан уг уулзалтад төр засгийн төлөөлөл, дэлхийн 12 орны зочид гээд 450 гаруй хүн оролцож, монгол нүүрс дэлхийн тавцанд хүч түрэн гарч ирж байгааг тунхаглалаа.

“Монголд хөрөнгө оруулах нь ямар ашигтайг, манай нүүрсний салбар Австралиас юугаараа давуу талтайг хөрөнгө оруулагчид сонирхож байгаа. Хятадын зах зээлд бүгд шунаж байхад бид дэргэд нь байна. Их хэмжээний нөөц ч Монголд бий. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчдыг татах соронзон хангалттай байна” хэмээн Ашигт малтмалын газрын дарга Д.Батхуяг тайлбарлав. Монгол Улс өнөөгийн байдлаар 162 тэрбум тонн нүүрсний нөөцтэй гэдэг. Үүгээрээ бид дэлхийд эхний 10-т эрэмбэлэгдэж, Австралитай дүйцэж ирж байгаа юм. Зарим мэргэжилтний үзэж буйгаар манай оронд 200 тэрбум тонн нүүрсний нөөц байх магадлалтай. Юутай ч нүүрсний салбарт урд хожид үзэгдээгүй үлэмж их хөрөнгө орж ирж, хайгуулын ажил эрчимжиж буй өнөө үед дээрх тоо цаашид ч өсөх бололцоо тун өндөр ажээ. Дэлхийн уул уурхайн акул “Vale” л гэхэд Монголд нүүрсний хайгуулын таван төсөл хэрэгжүүлж, 5.5 сая ам.доллар зарцуулах төлөвлөгөөтэй байна. “Монголын нүүрсний салбар асар их ирээдүйтэй” хэмээн тус компанийн төслийн менежер Пол Сулливан тэмдэглэв.

“Монгол улс хуучин зэсээр амьдарч байлаа шүү дээ. Одоо нүүрсний экспортын орлого зэсийнхээс даваад гарчихсан. Эдийн засаг сэргэж байгаатай холбоотойгоор дэлхийн, ялангуяа Ази тивийн нүүрсний эрэлт асар нэмэгдэж байгаа юм. Энэ нь мэдээж бидний хувьд сайн мэдээ. Монголын нүүрсний салбарын хувьд хувьсгалын тохироо бүрдэж байна” хэмээн “Энержи ресурс” компанийн гүйцэтгэх захирлын орон тооны зөвлөх Р.Сундуй онцлов. 2010 онд монголчуудын экспортолсон зэсийн баяжмал 770.6 сая ам.доллар болсон бол нүүрсний экспортын орлого түүнээс 100 гаруй сая ам.доллараар давж, 877.6 ам.долларт хүрчихээд байна. 2003 онд манай орон ердөө 500 мянган тонн нүүрс экспортолж байсан бол долоон жилийн дотор энэ үзүүлэлт 33 дахин нэмэгдэж, 16.6 сая тоннд хүрчээ.

“10 жилийн өмнө байдал шал өөр байсан. 2000 онд бид Тавантолгойг яаж эдийн засгийн эргэлтэд оруулах вэ гэж их боддог байлаа. Энэ ордод хөрөнгө оруулж өгөөч гэж олон оронд хандаж, гуйж байсан боловч хэн ч тоохгүй байв. Гэтэл өнөөдөр дэлхийд тэргүүлэх компаниуд Тавантолгойд хөрөнгө оруулах гээд өрсөлдөж байна шүү дээ” хэмээн Р.Сундуй онцлов. Монгол орон “Дэлхийн эрчим хүчний шинэ тоглогч” гэдгээ даян дэлхийд зарлаж байгаатай зэрэгцэн дотоодын нүүрсний салбарт цэгцлэх ажил олон байгааг “Coal Mongolia 2011” чуулга уулзалтад оролцогчид анхааруулж байлаа.

Өнөөдөр “Монгол нүүрс” Хятад хэмээх ганцхан худалдан авагчтай. Олон улсын эрчим хүчний агентлагийн таамаглалаас харахад эрчим хүчнийхээ 70 хувийг нүүрснээс гаргаж авдаг БНХАУ-ын эрэлт асар ихээр нэмэгдэх аж. Японы “Nomura” банкны шинжээчдийн үзэж буйгаар 2020 он гэхэд хятадууд нүүрсний үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлэх ажээ. “Citigroup” хятадууд энэ онд 233 сая тонн нүүрс импортолно хэмээн дүгнэж байна. Гэтэл “Deutsche Bank” хөрөнгө оруулалтын банкны мэргэжилтнүүд энэ нь дэлхийн хамгийн том нүүрсний боомтууд болох Өмнөд Африкийн “Richards Bay” болон Австралийн “Newcastle”-ийн бүтэн жилийн хүчин чадлаас мэдэгдэхүйц давсан үзүүлэлт болохыг тэмдэглэж байна. Олборлосон нүүрсээ шууд урагш зөөдөг монголчуудын хувьд энэ бүхэн мэдээж сайн мэдээ. “Хятадын коксжих нүүрсний импортын 50 хувийг Монголоос хангах боломжтой” хэмээн Худалдаа хөгжлийн банкны ерөнхийлөгч Рандолф С.Коппа илтгэлдээ дурдсан юм. 2009 онд БНХАУ нийт 34.5 сая тонн коксжих нүүрс импортолсны 66 хувийг Австрали, 11 хувийг Монгол Улс нийлүүлсэн. Тэгвэл 2010 онд монголчууд 30 гаруй хувийг нь дангаараа хангаснаас үзэхэд С.Коппагийн таамаглал тун ч удахгүй биелж мэднэ.

Гэхдээ урд хөрш маань байнга л нүүрсний томоохон



импортлогч байна гэж хөөрцөглөвөл эндүүрэл болох вий. Байгаль орчноо хамгаалахын төлөө 2015 он гэхэд нийт эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх нүүрсний хэмжээгээ 63 хувь болтол бууруулна гэсэн зорилгыг урд хөршийн эрх баригчид өвөртөлж буй. Энэ зорилгодоо хүрэхийн тулд сэргээгдэх эрчим хүч, цөмийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг олноор нь бий болгож байгааг сануулах нь зүйтэй болов уу. Үүний хажуугаар хятадууд манай нүүрсийг байж болохоор нь “миалж”, хямд үнээр авахыг оролддог. Тиймээс бид ганц худалдан авагч түшин хөгжилд хүрнэ гэдэг худлаа. Өөрөөр хэлбэл, нүүрсийг өндөр үнээр авдаг Япон, БНСУ зэрэг оронд нийлүүлэлт хийж, олон худалдан авагчтай болох хэрэгтэйг мэргэжилтнүүд сануулж байгаа юм.

“Өнөөгийн нөхцөлд нүүрсээ БНСУ мэтийн гуравдагч зах зээл рүү тээвэрлээд ашиггүй юм билээ. Мэдээж нүүрсний үнэ цаашид өссөөр байвал ашигтай болохыг үгүйсгэхгүй. Эдийн засгийн тооцоог л өндөр түвшинд хийх хэрэгтэй дээ” хэмээн МІСС хөрөнгө оруулалтын банкны ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ анхааруулав. Монголын баялгийг дэлхийн зах зээлд хүргэх хамгийн дөт замыг Тяньжин дахь Улаанбаатар хотын төлөөлөгчийн газрын захирал Ж.Ганхуяг илтгэлдээ онцолсон юм. Ингэхдээ олон сайхан боломж байгааг танилцуулсан ч автозам, төмөр зам гэсэн холимог тээврээр Тяньжинд хүрэхээс өөр арга үгүй тул зардал их гарах тухай нүүрс олборлогчид ярьж байлаа.

“Нүүрс олборлох, түүнийг зах зээлд хүргэх тал дээр тээвэр ложистикийн асуудал амин чухал. Энэхүү ашигт малтмалыг машинаар тээвэрлэнэ гэдэг эдийн засгийн талаасаа ч өртөг ихтэй, байгаль орчиндоо ч сөрөг нөлөөтэй. Уг нь бол төмөр замаар тээвэрлэх хэрэгтэй” гэж Р.Сундуй тайлбарлав. “Аж хуйн нэгжүүд хувийн хөрөнгө оруулалтаар урагшаа төмөр зам тавих санал гаргасан ч Засгийн газар зөвшөөрөөгүй. Тиймээс автозамаар нүүрс тээвэрлэж буйтай холбоотой гарч ирэх байгаль орчны асуудалд Засгийн газар хариуцлага хүлээх ёстой” хэмээн Дэлхийн банкны уул уурхайн ахлах мэргэжилтэн Грэм Хэнкок сануулж амжив. Цаг үеийн хувьд урагшаа төмөр зам тавих хэрэгцээ, шаардлага байгааг УИХ-ын гишүүн Д.Оюунхорол ч онцолсон. Төр бодлогоор Монголын нутаг дэвсгэрт зөвхөн өргөн царигтай төмөр зам байхыг хуульчилж, урагш нь төмөр зам тавихыг үндсэндээ боогдуулсан билээ. Тэгсэн

хэрнээ хойшоо чиглэх төмөр замын барилгын ажлаа түргэвчлэхгүй удаж байгааг мэргэжилтнүүд шүүмжилж, энэ нь монгол нүүрс дэлхийн зах зээлд нэвтрэхэд хамгийн том тушаа болж буйг анхааруулж байлаа.

Зам тээвэр, барилга хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ “Төмөр замаа энэ жилдээ ямар ч байсан эхлүүлж, эхний ээлжинд Сайншанд хүртэл барина. Энэ ажилд хоёр жилийн хугацаа орох болов уу. Харин Чойбалсангаар дамжаад хойшоо гарах төмөр замын барилгын ажлыг үүний дараа эхэлнэ. Ер нь төмөр замын шугам Сайншандад хүрчихвэл төв магистралаар дамжаад хойшоо, урагшаа гарах боломж нээгдэнэ” хэмээн тайлбарлав.

Төмөр зам өнөөдөр баригдаж эхлээгүй юм чинь хоёр жилийн дараа ашиглалтад орчихно гээд шууд хэлэхэд бэрх. Тиймээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” маань ч олборлосон нүүрсээ эхний ээлжинд автомашинаар л урагш зөөж таарах ажээ.

“Манай суманд 1500 гаруй хүнд даацын автомашин нүүрс татан холжилдож байна. Үүнээс үүдэлтэй тоосжилт нэлээд бэрх асуудал болсон” хэмээн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга Г.Цог-Өрнөх яриад, “Энержи ресурс” энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Тавантолгойгоос Гашуун Сухайт хүртэл 250 орчим км хатуу хучилттай зам барьж байгааг онцоллоо. Гэхдээ автозамын тал дээр ч төрийн бодлого үгүйлэгдэж байгааг гэрчлэх баримт цөөнгүй.

Урагшаа чиглэсэн автозамыг өнөөдөр “Оюутолгой”, “Энержи ресурс”, “Чинхуа Мак” барьж байгаагийн зэрэгцээ “Эрдэнэс Тавантолгой” хүртэл зам барих төлөвтэй. “Баялгаа урагш нь зөөх 10 салаа зам барих юм уу? Тэгээд баахан машин зэрэгцээд, уралдаад байх юм уу?” хэмээн Р.Сундуй тэмдэглэв. Ингээд бодохоор бидэнд дэд бүтцийн нэгдсэн бодлого хэрэгтэй ажээ.

“Нүүрсний олборлолтыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь бидний зорилго. Одоо дотоодын томоохон компаниуд нүүрсээ угааж эхэлж байна. Цаашлаад Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд бүр сайн боловсруулах шаардлага тавих юм” хэмээн Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт яриу.

“Энержи ресурс” компани баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулж байгаа бөгөөд энэ онд долоон сая тонн нүүрс олборлон, таван сая тонн баяжмал гаргах ажээ. Мэдээж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортолно гэдэг хаа хаанаа ашигтай. Ажлын байр бий болно, нүүрсний борлуулах үнэ нэмэгдэнэ, тээврийн зардал ч багасна. Үүнийг төрөөс бодлогоор дэмжиж эхэлснийг мэргэжилтнүүд сайшааж байлаа. Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр буюу роялти болон Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль батлагдсанаар нүүрсийг боловсруулах тусам ногдох татвар нь буурах тун ч оновчтой бодлого хэрэгжиж эхлээд байна.

Аж ахуйн нэгжүүд одооноос нүүрсээ угааж, боловсруулж байгаа нь сайн хэрэг. Цаашдаа бүр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүхий нүүрс биш, түлш, эрчим хүч экспортлох зорилго тавих шаардлагатайг эрдэмтэд тэмдэглэж буй. “Нефтийн үнэ нэмэгдсэн учир хүрэн нүүрснээс шингэн түлш гаргах зардал боломжийн болсон. Энэ технологийг манай эрдэмтэд эртнээс судалсан болохоор одоо ажил хэрэг болгох нь зүйтэй.

Бид нүүрснээс шингэн түлш гаргаж авах үед дагалдах маш олон төрлийн бүтээгдэхүүн бий болно шүү дээ” хэмээн Уул уурхайн төсөл судалгааны төвийн захирал, доктор, профессор С.Цэдэндорж ярьж байна.

За тэгээд Монголын нүүрсний салбар өсөн томорч буй өнөө үед байгаль орчны асуудал мэдээж хурцаар тавигдах билээ. “Эдүгээ манай нүүрсний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын олонх нь шаардлага хангасан нөхөн сэргээлт хийдэггүй, үйл ажиллагааны тайлангаа холбогдох албаныханд өгдөггүй. Гэтэл хуулийн хүрээнд ажиллаагүй аж ахуйн нэгжүүдийг хаах эрх Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд алга. Энэ бүхэн манай уул уурхайн салбар бодлогын

хувьд задгай байгааг харуулна” хэмээн Д.Оюухорол гишүүн учирлав. Байгаль орчноо хамгаалах тал дээр одооноос л анхаарах хэрэгтэйг хүн бүр сануулж байна. Энэ хүрээнд Нөхөн сэргээлтийн сан байгуулах хуулийн төсөл боловсруулж байгаагаа С.Оюун гишүүн “Coal Mongolia 2011” чуулганы үеэр дуулгасан юм.

Дээрх асуудлуудыг л төр, засаг зөв зүйтэй зохицуулж чадвал “Монгол нүүрс” жинхэнэ утгаараа дэлхийн тавцанд гарч, монголчууд олон улсын нүүрсний зах зээлд баттай байр сууриа эзэлж чадах билээ. Нүүрсний эрин бидэнд нэмүү өртөг шингэсэн “Монгол брэнд”, ажлын байр, дэд бүтцийн зөв бодлого, нөхөн сэргээлтийн зохицуулалтыг авчрах болтугай!

Ашигт малтмал

“Шар нунтаг” үнэд орох цагаар...



Д.Чимэг

Бөмбөрцгийн хүн амын тоо 2050 он гэхэд 9.8 тэрбумд хүрч, өнөөгийнхөөс 42 хувиар өснө гэсэн таамаглалыг НҮБ гаргасан билээ. Энэ нь дэлхийн эрчим хүчний хэрэглээ тэр хэрээр нэмэгдэхийг зөгнөж буй хэрэг юм. Гэтэл газрын тос, байгалийн хийг дэлхий нийт өнөөдрийн хэрэглэж байгаа хэмжээгээр ашиглаад байвал 50-100 жилийн дараа нөөц нь дуусна гэсэн тооцоо бий. Тиймээс хүн төрөлхтөн “гал гаргах” бусад хувилбарыг эрэлхийлэх болоод удлаа. Ногоон эдийн засаг хаяагаа тэлэхийн хэрээр “Clean energy” буюу “Цэвэр эрчим хүч” гэх ойлголт моодонд орж, сэргээгдэх эрчим хүч, цөмийн эрчим хүч улам бүр газар авч байна.

Цөмийн эрчим хүчний эрэлт, хэрэгцээ дэлхий даяар 2030 он гэхэд 66 хувиар нэмэгдэнэ гэсэн судалгаа бий аж. Эдүгээ 30 оронд төвлөрсөн 443 цөмийн реактор ажиллаж байгаа бөгөөд дэлхийн нийт эрчим хүчний 16 гаруй хувийг

атомын цахилгаан станцууд гаргаж байгаа юм. Гэвч энэ үзүүлэлт орон тус бүрт огцом ялгардаг. Францад ашиглаж буй нийт эрчим хүчний 80 гаруй хувийг атомын цахилгаан станцууд үйлдвэрлэж байгаа бол Хятадад энэ үзүүлэлт ердөө хоёр хувьтай байх жишээтэй. Хөгжингүй орнууд байгаль орчноо хамгаалах зорилготойгоор нүүрснээс татгалзаж, тэр хэрээрээ цөмийн эрчим хүч хэрэглэж байгаа билээ. Тухайлбал, АНУ-ад 104, Францад 59, Японд 55, ХБНГУ-ад 17 атомын цахилгаан станц ажиллаж байна. Гэвч хөгжиж буй орнууд ч сүүлийн үед цөмийн эрчим хүчийг ихэд сонирхож эхэлснийг гэрчлэх баримт цөөнгүй. 2010 онд дэлхийн 60 улс цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг судалж буйгаа Олон улсын атомын энергийн агентлагт мэдэгдсэний ихэнх нь хөгжиж буй орнууд байжээ. Энэ зууны дунд үеэс уран дэлхийн эрчим хүчний гол эх үүсвэр болох хандлагатайг мэргэжилтнүүд тэмдэглэж байна.

“Шар нунтаг” гэх энэхүү баялгийг өнөө үед цөмийн зэвсэг үйлдвэрлэх бус, энхийн зорилгод, хүн төрөлхтний сайн сайхан амьдралын төлөө ашиглахыг илүүд үзэх болсон билээ. Тэр ч утгаараа цөмийн эрчим хүчний салбарт техник, технологийн дэвшил байнга гарах болов. Ослын үед автоматаар унтардаг, газар хөдлөлтийг мэдрэх тоног төхөөрөмжтэй технологи нэвтэрч байгаа бөгөөд цаашид үүнээс ч илүү сайжрах төлөвтэйг мэргэжилтнүүд мэдэгдэж байна.

Нэг фунт уран 20 мянган фунт нүүрсний гаргах эрчим хүчийг ялгаруулдаг гэсэн тооцоо бий. Дэлхий даяар цөмийн эрчим хүч хаяа тэлж эхэлсэн өнөө үед цацраг идэвхт ашигт малтмалын үнэ тэнгэрт хадах хандлагатайг шинжээчид онцолж байна. Аз болж Монголд ураны арвин нөөц бий. Гэвч “шар нунтаг” үнэд орох цагийг бид ашиглаж чадах уу гэдэг л хамгийн чухал асуулт билээ.

Монгол Улс нөөцөөрөө 15 дугаарт жагсдаг

Манай улсын зүүн хэсэгт орших Дорнод аймгийг ураны өлгий нутаг гэж нэрлэх нь бий. Учир нь энд нэлээд сайн судлагдсан Дорнод, Гурванбулаг, Мардайн ураны орд оршдог. Дорнодын ураны ордыг 1988-1992 онд ЗХУ-ын “Эрдэс” уулын үйлдвэр ашиглаж, 550 тонн уран олборлосон гэх баримжаа бий агаад хүдрээ Краснокаменскийн баяжуулах үйлдвэрт боловсруулж байсан гэдэг.

Зарим эрдэмтэн Монгол орны ураны судалгаа 1948 оноос эхэлсэн гэж үздэг ч 1970-аад оноос л хайгуулын ажил эрчимжсэн байна. Чухам энэ үеэс ЗХУ-ын мэргэжилтнүүд манай нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг судалгаандаа хамруулсан бөгөөд ураны зургаан орд, 100 орчим илрэл, 1000 гаруй радиогеохимийн гажлыг олж тогтоон олон тооны өрөмдлөг, малталт хийсэн байдаг. Оросууд Дорнод, Мардай, Гурванбулаг, Нэмэр зэрэг ордын нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тогтоосон бөгөөд нийт 49 мянган тонн гэж дүгнэсэн баримт бий. Үүгээрээ Монгол Улс дэлхийд 15 дугаарт эрэмбэлэгдэж байгаа юм. Харин Олон улсын атомын энергийн агентлаг Монгол Улсын ураны нөөцийг 62 мянган тонн гэж нэгтгэн дүгнэсэн билээ.

Гэхдээ Монголын ураны бүх орд жижиг, дунд ангилалд багтах бөгөөд 10-15 жилийн настайд тооцогддог хэмээн зарим мэргэжилтэн анхааруулж байна. Өөрөөр хэлбэл, бид өнөөгийн нөөцөө олборлож эхэлбэл цаад зах нь 20 жилийн дараа уранаа барж дуусах юм. Тиймээс ураны эрэл, хайгуулаа үргэлжлүүлж, нөөцөө нэмэгдүүлэх шаардлагатайг эрдэмтэд сануулдаг. “Бид одоо ураныхаа хайгуулыг ихээхэн өргөжүүлж, хаана байгааг нь илүү сайн мэдэж авах ёстой. Дэлхийн зах зээлд ураны эрэлт нэмэгдэх хандлага байгаа учраас хүмүүс ч мөнгөө харамгүй хаяна шүү дээ. Тэгээд ураныг олборлож, цааш нь боловсруулах хэрэгтэй. Энэ тал дээр технологийн өндөр түвшинд хүрсэн гүрнүүдийн анхаарлыг татаж, хамтран ажиллах тал дээр төрийн бодлого төвлөрөх ёстой” хэмээн ШУТИС-ийн “Экологи-

тогтвортой хөгжлийн төв”-ийн захирал П.Очирбат онцолж байсан юм.


Австралийн үерээс болж ураны үнэ огцом өсчээ

2007 оны дунд үед ураны оксидын баяжмалын спот үнэ оргил цэгтээ хүрч, нэг фунт буюу 0.45 кг нь 136 ам.доллараар арилжаалагдаж байв. Гэвч уг бүтээгдэхүүний ханш ганц жилийн дотор гурав дахин буурсан билээ. Энэхүү үнийн уналт хийгээд дэлхийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал ураны хайгуул, судалгааны олон төслийг “царцаасан” учир эдүгээ зах зээлд хомсдол бий болж байгааг шинжээчид анхааруулж буй.

“Ux Consulting” (UxC) компанийн цахим хуудаснаас харахад нэг фунт ураны оксидын баяжмалын үнэ он гарсаар огцом өсч, өнгөрсөн хоёрдугаар сард 73 ам.доллараас давсан байна. Энэ нь “Rio Tinto” групп Австралид болсон үерээс болж дэлхийн ураны олборлолтын өсөн хувийг дангаараа бүрдүүлдэг “Ranger” уурхайн үйл ажиллагааг гурван сарын турш хаах шийдвэр гаргаснаа өнгөрсөн нэгдүгээр сард мэдэгдсэнтэй холбоотойг “Bloomberg” мэдээлсэн байна. Харин Канадын “Scotiabank Group” банкны тайлбарлаж буйгаар ураны үнийн өсөлт зах зээлд хомсдол нүүрлэсэнтэй шууд хамаатай ажээ. 2010 онд дэлхий даяар ураны эрэлт 82.5 мянган тоннд хүрсэн бол олборлолтын хэмжээ ердөө 63.5 мянган тонн байсан аж.

Уран нь ихэвчлэн урт хугацааны гэрээгээр худалдаалагддаг тухай мэргэжилтнүүд сануулж байна. Зах зээлд энэ бүтээгдэхүүний ердөө 10 орчим хувийг арилжаалдаг бөгөөд үнийг нь UxC болон “TradeTech” нийтэлдэг юм. Энэ зах зээлийн ханш ураны худалдааны урт хугацааны гэрээнд ч ихээхэн нөлөөлдгийг шинжээчид тайлбарлав. Ойрын таван жилийн хугацаанд нэг фунт ураны үнэ 100 ам.доллараас ч давж магадгүйг Их Британийн “CRU Group” компанийн мэргэжилтнүүд анхааруулжээ. 2030 он гэхэд дэлхий даяар 158 цөмийн реактор шинээр ашиглалтад орохоор байгаагийн 50 нь Хятадад баригдах төлөвтэйг Дэлхийн цөмийн ассоциацийн (World

Дэлхийн үйлдвэрлэлийн хэмжээ



Nuclear Association) цахим хуудсанд тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, манай урд хөрш ураны эрэлтээрээ дэлхийд тэргүүлэх нь нэгэнт тодорхой болжээ.

2010 онд л гэхэд БНХАУ ураны импортоо жилийн өмнөхөөсөө бараг гурав дахин өсгөж, 17 гаруй мянган тонн болгосон тухай “The Wall Street Journal” мэдээлсэн юм. Манай урд хөрш уранаа ихэвчлэн Казахстан, Узбекистан, Намиби, Австрали болон ОХУ-аас худалдаж авдаг аж. UxC компанийн гаргасан таамаглалаас үзэхэд хятадууд 2020 он гэхэд ураны хэрэглээгээ дөрөв дахин өсгөхөөр байна.

Нөөцөөр Австрали, үйлдвэрлэлээр Казахстан тэргүүлж байна

Бөмбөрцгийн ураны батлагдсан нөөц 5.4 сая тонн хэмээн мэргэжилтнүүд үзэж буйг Дэлхийн цөмийн ассоциаци мэдээлэв. Үүний 31 хувийг Австралидангаараа эзэлж, 1.67 сая тоннын нөөцөөр дэлхийд тэргүүлдэг аж. Харин Монгол Улс 49 мянган тонноор 15 дугаарт жагсаж байгааг дээр дурдсан билээ. 2009 онд дэлхий даяар 50,772 тонн уран олборлосон нь жилийн өмнөхөөсөө 15.8 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү цацраг идэвхт ашигт малмалын олборлолтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж буй ч эрэлтээ дийлэхгүй байгааг мэргэжилтнүүд анхааруулсаар.

Эдүгээ дэлхийн ураны нийт олборлолтын 60 гаруй хувийг Казахстан, Канад, Австрали улс бүрдүүлж байна. Казахстаны “Казатомпром” компани 2010 онд 17,803 тонн уран олборлосон бол энэ онд хүчин чадлаа 10 хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэйг тус компанийн захирал Владимир Школьник мэдэгджээ.

Цацраг идэвхт ашигт

малтмалын нийт үйлдвэрлэлийн 89 хувийг ердөө 10 компани бий болгодог тухай <http://www.world-nuclear.org> цахим хуудсанд мэдээлсэн байна. 2009 онд л гэхэд ураны нийт олборлолтын 17 хувийг “Areva”, “Cameco” болон “Rio Tinto” тус бүр 16 хувийг эзэлснийг графикаас харна уу. Түүнчлэн уг цацраг идэвхт ашигт малтмалын дэлхийн зах зээл дэх нийт нийлүүлэлтийн 59 хувийг Канадын “McArthur River”, “Rabbit Lake”, Австралийн “Ranger”, “Olympic Dam”, Намибийн “Rossing”, ОХУ-ын “Kraznokamensk”, Казахстаны “Tortkuduk”, “Budepovskoye”, Нигерийн “Arlit”, “Akouta” уурхай гаргаж байгаа аж. Гэвч томоохон уурхайнууд “хөгширч”, ураны үйлдвэрлэлийн өөрийн өртөг нэмэгдэж байгааг “Business Resource” компанийн мэргэжилтнүүд тогтоожээ. Тодруулбал, нэг фунт уран олборлох өөрийн өртөг 40 ам.доллараас бага байх эдийн засгийн үр ашигтай уурхайн тоо багассаар байгаа нь үнийн өсөлтөд нөлөөлөх хандлагатай байна.

Дашрамд сонирхуулахад, ураны салбарт тодорхой байр суурь эзэлсэн томоохон компаниудын ихэнх нь Монголд аль хэдийнэ хөл тавьсан байгаа юм. 2003 оноос “Cameco”, “East Asia Minerals”, “Khan resources”, “Solomon resources limited”, “Mega uranium”, “Western Prospector Group” зэрэг Канадын компани Монголын ураны салбарт орж ирсэн. Түүнчлэн ураны олборлолтоороо дэлхийд толгой цохидог “Areva”, “BHP Billiton”, “Rio Tinto”, “Rosatom” зэрэг компани ч Монголд үйл ажиллагаа явуулж байгаа билээ.


Атомын цахилгаан станцаас сураг байна уу?

2030 он гэхэд 158 цөмийн реактор шинээр ашиглалтад орох төлөвтэйг дээр дурдсан. 2010 оны байдлаар 62 цөмийн реакторын барилгын ажил явагдаж байсан нь 1992 оноос хойших дээд үзүүлэлт болохыг Дэлхийн цөмийн ассоциаци тэмдэглэж байна.

“Монголын нөхцөлд байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд халгүй, эдийн засгийн үр ашигтай сонголт бол атомын цахилгаан станц гэдэгт эрдэмтэд эргэлзэхгүй байна хэмээн” академич Х.Намсрай онцолсон удаатай. Уг нь манай оронд

цөмийн эрчим хүчний хэрэглээ, атомын цахилгаан станцын талаар яриа, хэлэлцээр өрнөж эхлээд гурван жил улирч байгаа билээ. Олон улсын атомын энергийн агентлагийн тэргүүн Мохамед эл Барадей 2009 оны дөрөвдүгээр сард Монгол Улсад айлчилсны дараахан манай Цөмийн энергийн агентлагийн дарга С.Энхбат “Бид ирэх оноос эхлэн атомын цахилгаан станц барина. Энэ ажлыг яаравчлах хэрэгтэй” хэмээн “Ройтерс” агентлагт ярилцлага өгч байв. Гэтэл үүнээс хойш хоёр жилийн нүүр үзэж байгаа ч атомын цахилгаан станцыг хаана барих тухай судалгаа хийснээс цаашгүй байна.

Өнгөрсөн оны сүүлчээр “Монгол Улсад цөмийн эрчим хүчний станц барих урьдчилсан судалгаа” төслийн хээрийн туршилт, судалгааны анхдугаар их хуралдай болсон билээ. Эрдэмтэн, судлаачид Төв аймгийн Баянжаргалан сумын нутаг



	Тонн	Хувиар
Australia	1673000	31%
Kazakhstan	651000	12%
Canada	485000	9%
Russia	480000	9%
South Africa	295000	5%
Namibia	284000	5%
Brazil	279000	5%
USA	207000	4%
China	171000	3%
Jordan	112000	2%
Uzbekistan	111000	2%
Ukraine	105000	2%
India	80000	1,5%
Mongolia	49000	1%
Other	150000	3%

Малхийн тал хэмээх газрыг “атомайн цахилгаан станц барих боломжтой нутаг” хэмээн дүгнэсэн байдаг. Тодруулбал, Хэрлэнгийн доод гүүр орчмын 100 ам км талбайг цөмийн реактор барихад тохиромжтой хэмээн “онилсон” билээ. Байршлын судалгааны ерөнхий шинжээч, академич Д.Доржготов дээрх хуралдайн үеэр “Монголчууд ураны хангалттай нөөцтэй атлаа яагаад атомын цахилгаан станц бариагүй өдий хүрэх” хэмээн онцолж байсныг сануулах юун.

“Одоо бид ямар хүчин чадалтай станц барих вэ, түүнийг барихад юу хэрэгтэй вэ гэсэн дэд бүтцийн нарийн судалгаа хийнэ. Энэ ажил ойрын гурван жилийн хугацаанд дуусах ёстой” хэмээн С.Энхбат тэмдэглэсэн билээ. Үүнээс үзэхэд цөмийн эрчим хүчний “ид шид”-ийг монголчууд ойрын хэдэн жилдээ үзэхгүй бололтой. Дулааны хэдэн цахилгаан станц нь элгээрээ хэвтэх гээд байгаа өнөө үед цөмийн реакторын асуудлыг төр засаг яаралтай шийдэх хэрэгтэйг мэргэжилтнүүд сануулж буй. Мэдээж аюулгүй байдал талаасаа энэ нь долоо хэмжиж, нэг огтлох ажил боловч долоон жил сунжрах хэрэг ердөө ч биш гэдгийг учир мэдэх хүмүүс тайлбарлаж байна.

“Чернобыльд болсон явдлаас бид бүгд, бүх дэлхий, атомын эрчим хүчний салбар тэр чигээрээ тодорхой дүгнэлт хийсэн. Түүнээс хойш аюулгүй байдлыг тас хянадаг болсон. Хэрэв Монголд атомын цахилгаан станц барина гэвэл энэ нь ямар ч аюулгүй байна гэдгийг хариуцлагатайгаар хэлэх байна” хэмээн “Rosatom”-ын ерөнхий захирлын орлогч Н.Н.Спаский ярьж байсан билээ. Байгаль эхээс заяасан нөөц баялгаа ашиглан “Цэвэр эрчим хүч”-ний эх үүсвэрийг бий болгож, дэлхий нийтийн





Хөдөө аж ахуй

Түүхэнд байгаагүй өндөр ханштай туулай жилийн ноолуур

И.Отгонжаргал

Ноолуур 70.000 төгрөгийн ханштай байна гэвэл Табитгий гайхаарай. Энд гэхдээ зүгээр сайхан ханш мөрөөдөж байгаа юм биш. Энэ жилийн ноолуурын үнийн хандлага ийм байгааг Монголын ноос, ноолуурын холбооны дэд тэргүүн Г.Ёндонсамбуу гуайтай уулзах үеэрээ олж мэдлээ. Гэхдээ энэ нь ханш яг 70.000 болчихно гэсэн үг биш шүү. Ямартай ч жил бүрийн ноолуур гарах үеийн анхны үнэ бүтэн жилийн ханшийг тодорхойлдог уламжлалтай. Энэ үүднээс авч үзвэл энэ жилийн ноолуурын ханш өмнөх жилүүдээс харьцангуй өндөр байх аж. Ямааны ноолуур жилийн жилд Хэнтий аймгаас эхэлж гардаг. Гуравдугаар сарын 18-ны байдлаар тус аймагт ямаа самналт эхлэл төдий хүмүүс цаг агаарын байдлыг харзсан бадалтай байна гэж мэргэжлийн хүмүүс ярьж байсан. Манай сэтгүүл хэвлэгдэх үед мэдээж дээрх ажил эрчимжих биз ээ.

1990-ээд оны сүүлчээс хойш ноолуурын ханш өссөн-буурсан-өссөн-буурсан-өссөн үзүүлэлттэй явж ирсэн. Дээрх хугацаанд ноолуурын ханш дээд тал нь 52000

төгрөг хүрч өсч, доод тал нь 17000 болж буурч байсан санагдана. Тэгвэл Хэнтийд энэ сарын 18-ны байдлаар 53000-55000 төгрөгийн ханштай байгаа дуулдав. Үүнийг үйлдвэрлэгчдийн санал болгож байгаа үнэ гэж үзэж болох юм билээ. Харин малчид “Поо, ямар өндөр ханш вэ? Бушуухан ямаагаа самнаж, ноолуураа өгье” гэж яарахгүй байна гэсэн шүү. Өшөө үнэ хүрэх ёстой. Ядаж 60.000 болохоор нь өгнө гэсэн бодолтой байгаа юм билээ. Тэгэхээр энэ жилийн ханш 60000-аас эхлэх нь бараг хөдлөшгүй болж байх шиг байна гэсэн таамгыг Ёндонсамбуу гуай нуугаагүй. Одоо тэгэхээр үндэсний үйлдвэрлэгчид ийм өндөр ханштай түүхий эд базааж чадах болов уу гэдэг асуудал тулгарна. Яагаад ийм өндөр ханштай байх хандлага бий болов гэдгийг сонирхоё.

Үнэ өндөр байна гэж гоншигонохгүй ээ

Шалтгаан 1. 2009 оны жилийн эцсийн мал тооллогоор 19.9 сая толгойд хүрч өссөн манай ямаан

сүргийн тоо толгой 2010 онд 13.8 сая толгой болж огцом буурсан. Энэ нь бэлчээрийн талхагдал судалж, ямааг нүд үзүүрлэдэг эрдэмтэн судлаач, байгууллагынхны хувьд сайхан мэдээ ч Монголын эдийн засагт муу нөлөөтэй, таагүй зүйл. Өөрөөр хэлбэл, 20 орчим сая ямаанаас жилдээ 7000 орчим тонн ноолуур бэлтгэдэг байсан бол өдгөө дөнгөж 3500-4000 тонн ноолуур бэлтгэх болчихоод байна. Түүхий эдийн нөөц их байхад өрсөлдөөнд сүүл хормойлдог байсан үндэсний үйлдвэрийнхэнд энэ нь аймшиг санагдах нь мэдээж. Харин олон жил Монголын ноолуурын салбарт хүч үзэж байгаа хятадуудын хувьд байдал өөр. Тэд мөнгөтэй учраас санаа зовох зүйлгүй. Харин ч баярлаж байж ч болох.

Бага нөөц, өндөр ханштай холбоотойгоор туулай жилийн ноолуур бэлтгэлийн ажилд нэлээд хүндрэлтэй асуудлууд гарч ирэхээр байгааг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болоод мэргэжлийн холбооны удирдлагууд ярьж байна.


Шалтгаан 2. Юуны өмнө Монголын ноолууран бүтээгдэхүүн

үйлдвэрлэгчид өнгөрсөн оныг хэрхэн даван туулсан бэ гэдгийг товч хүргэх шаардлагатай юм билээ. Өнгөрсөн онд ноолуурын бизнес эрхлэгчдийн дунд өрсөлдөөн тун чиг ширүүн явсан. Эцэст нь ялагч нь тодорхой. Монголын ноолуурыг Хятадууд үнэ цохиж авдаг уламжлал хадгалагдсан гэж хэлж болно. “Говь”, “Ээрмэл” зэрэг томоохон үндэсний үйлдвэрлэгчдийн “дайны талбар”-аас арай гэж базаасан жаахан түүхий эдийн нөөц нь оны сүүл рүү ёроолдоо хүрч, баларчээ. Австралиас хонины нарийн ноос, Хятадаас ноосон утас худалдан авч байж захиалгаа чадан ядан хийжээ. Тэгвэл урьд хожид байгаагүй өндөр үнэ юу авчрах вэ. Малчдын хувьд арвин ашиг, орлого авчрах нь мэдээж. Харин эргэлтийн хөрөнгө муу, банкны зээл ихтэй үндэсний үйлдвэрлэгчдийн хувьд хүндээр тусна. Гэхдээ тэд өмнөх жилүүд шиг ноолуур өндөр үнэтэй байна гэж гоншигонохгүй гэсэн бодолтой байна. Угаасаа зах зээлийн ханш тогтсон учраас тэр. Энд бяцхан тайлбар хэрэгтэй байх. Дэлхийн ноолуурын зах зээлийг ойлгоход хялбархан. Дэлхийн ноолуурын зах зээлийг ерөөсөө л Монгол, Хятад хоёр тодорхойлж байгаа. БНХАУ-д мөн өнгөрсөн онд ямаан сүргийнх нь тоо толгой буурсан. Түүнчлэн дундаж давхаргын хэрэглээ ихэссэн учраас тус улсын дотоодод ноолууран бүтээгдэхүүний хэрэгцээ нэмэгдсээр байгаа аж. Тийм ч учраас урд хөрш самнасан ноолуурын экспортыг хоригложээ. Үүнээс гадна дэлхийн эдийн засаг сэргэж байгаа учраас ноолууран бүтээгдэхүүний хэрэглээ ихэссэн байна. Тэгвэл манай сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид өндөр үнийг цааргалахгүй яаж түүхий эдээ авах болж байна.

Үндэсний үйлдвэрлэгчид төр, засгаас ганц хоёрхон зохицуулалтыг яаралтай хийхийг хүсч байна. Нэгдүгээрт, самнасан ноолуурын экспортын татварыг 2008 онд тэглэснийг сэргээх. Сонгуулийн өмнөх жил урчаас УИХ-ын гишүүдийн хувьд экспортын татварыг нэмэх асуудалд уриалгахан хөдлөхгүй л болов уу. Тэгэхээр эрхэм гишүүдэд ноолуурын экспортод татвар тавихаар малчдын орлого буурна гэсэн ойлголт цагаа өнгөрөөснийг дуулгая. Асуудлын цаад утга учрыг сэтгүүлчийнхээ хувьд ойлгомжтой

хүргэхийг хичээе. Яагаад гэвэл ноолуурын өмнө нь байгаагүй өндөр үнэ экспортын татварт үл дарлуулахаар байна. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн 60 орчим мянган төгрөгийн ханш экспортын татвартай, татваргүй хадгалагдахаар байгаа гэсэн үг. Монголд ч, Хятадад ч эрэлт хэрэгцээ огцом нэмэгджээ. Дэлхийн ноолууран бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлага ямар байгааг дээр хэлсэн шүү дээ. “Говь”, “Гоёо”, “Ээрмэл”-ийн гадаад захиалга ч өмнөхөөс нэлээд нэмэгдсэн байх жишээтэй. “Говь” компани гэхэд л өнгөрсөн онд 180000 ширхэг сүлжмэл гаргасан бол энэ жил 300000-ыг гаргах төлөвлөгөөтэй байгаа юм билээ. Тийм ч учраас манай ноос, ноолуурын томоохон үйлдвэрүүд нийт 5000 орчим сүлжигч шинээр дадлагажуулж авахад бэлэн байгаа аж. Ийм хэмжээний хүнийг 300000-500000 төгрөгийн цалинтай ажлын байраар хангах боломжтой гэнэ. Ийм ажлын зарыг ч хэдийнэ хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж эхэлжээ.

Ноолуурын үйлдвэрлэлийн гол тоглогч урд хөрш дотоодын үйлдвэрлэлдээ түлхүү анхаарч эхэлсэн учраас ноолуурын дундын зуучлагчид Монголыг нэлээд сонирхох болжээ. Ийм үед ноолуурын экспортын татвар зайлшгүй хэрэгтэйг эрхбиш, УИХ-ын гишүүд гадарлах байлгүй дээ. Экспортын нэг кг ноолуур тутамд 10000 төгрөгийн татвар ногдуулах боломжтой тооцоог ч холбогдох хүмүүс хийж, Засгийн газарт хүргүүлсэн аж. С.Баяр “Атрын III аян”-ыг зарлаж, түүхэн гавьяа байгуулсан шиг Ерөнхий сайд С.Батболд хөдөө аж ахуйн салбараас мах, ноолуур хоёрын үйлдвэрлэлийг хөл дээр нь баттай зогсоох идэвх чармайлттай ажиллаж байна. Ерөнхий сайдын энэ идэвх чармайлтад ноос ноолуурын салбарынхан урамшиж, хүндрэл бэрхшээлийг даван туулах урам зориг өвөртөлжээ. Ерөнхий сайд ноолуурын үйлдвэрийнхэнтэй гурван ч удаа уулзаж, тулгарч буй бэрхшээлийг нь сонсч, шийдвэрлэх асуудлын гарцыг хамтдаа хайсан юм билээ. Хамгийн сүүлд Сангийн сайд С.Баярцогт “Ноолуур үйлдвэрлэгчдэд 100 тэрбум төгрөг өгье. Гэхдээ нэг хоёр том компанид өгөөд үр дүн багатай байдаг юм билээ. Энэ мөнгийг авахын тулд та нар том, жижиг гэлтгүй нэгдэж,



нийлэх ёстой” хэмээн амлажээ. Өөрөөр хэлбэл, Түүхий эдийн өндөр ханшаас айхгүй байгаа үйлдвэрлэгчдийн эцсийн найдлага Сангийн сайдын дээрх 100 тэрбум төгрөгийн амлалт болоод байна. Хамгийн гол нь дээрх 100 тэрбумыг 10 жилийн хугацаатай өгөх боломжтой гэж хэлсэн нь жилийн жилд хөрөнгө мөнгөөр гачигддаг ноолуурын үйлдвэрийнхний дотрыг уужруулсан бололтой. Харин Засгийн газрын зүгээс үйлдвэрлэгчдэд зүгээр мөнгө өгөхгүй. Та нар ажлын байр нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрийнхнийг өсч томроход нь тусла гэдэг үүргийг өгчээ. Тиймээс ч үйлдвэрлэгчид энэ талаар чадах чинээгээр хичээж ажиллахаар болжээ. “Говь” компанийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Наранбаатар” Нийслэлийн дүүрэг бүрт ажлын байрны төв ажиллуулах юм билээ. Уг сургалтад сурсан хүмүүст улсаас цамц хийх машин тавьж өгнө гэсэн. Захиалга, хэрэгцээ нэмэгдэж байгаа энэ үед бид нэгж бүтээгдэхүүнийхээ өртөг зардлаа бууруулж, бүтээмжийг дор хаяж 30-40 хувь дээшлүүлж байж Хятадын өндөр үнэтэй бүтээгдэхүүнтэй өрсөлдөж чадна. Манайх бүтээмжээ дээшлүүлж, үйлдвэрлэлээ хоёр дахин өсгөж байгаа. 250-300 ажлын байр бий болно” гэв. Тус компанийн Бизнес төлөвлөлтийн газрын захирал А.Ариунболд “Өнөөдөр дэлхийн зах зээл дээр нэг тонн самнасан ноолуур 130000 ам.долларын үнэтэй байна. Гэтэл нэг тонн нүүрс 25000 ам.долларын

үнэтэй байх жишээтэй. Энд их ялгаа харагдаж байгаа биз дээ. Манай төр, засаг ганц байгалийн баялагт шүтэх биш, эдийн засгаа ондоошуулах бодлого явуулмаар байна. Өөрөөр хэлбэл, хос морьтой байх хэрэгтэй. Тухайлбал, Монголын нөхөн сэргээгддэг баялаг болох ноолуур дэлхийд брэнд болж гарч ирэх бүрэн боломжтой. Нөгөө нэг асуудал нь нэг кг ноолуур тутамд 10000 төгрөгийн экспортын татвар ногдуулснаар ноолуурын үнэ ханш буурахгүй. Харин ч дотоодод нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болох нөхцөл бүрдэнэ” хэмээн ярилаа.

УИХ-ын хаврын чуулганы хэлэлцэх асуудлуудын нэлээд дээгүүр ноолууртай холбоотой асуудлууд байгаа гэж үйлдвэрлэгчид горьдож сууна. Манай ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэл харьцангуй сайн хөгжсөн гэж үзэж болно. Тухайлбал, өнөөдрийн байдлаар сүлжмэлийн 10 гаруй, мөн тооны бэлэн бүтээгдэхүүний, анхан шатны боловсруулалтын 20 гаруй, жижиг сүлжих цех 200 гаруй үйл ажиллагаа явуулж байгаа аж. Түүнчлэн Улаанбаатар хотын 22-ын товчооны наахна “ММГ капитал” гээд Шиньжаан-Уйгарын хөрөнгө оруулалттай асар том хүчин чадалтай анхан шатны боловсруулалтын үйлдвэр дөнгөж ашиглалтад ороод байгаа ажээ. Эндээс харахад дотоод, гадаад зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан түүхий эдийн хамгаалалтын хатуу бодлого явуулах цаг иржээ гэдгийг төрийн түшээд маань ойлгох байх гэж найдъя.

Үйлдвэрлэл явуулахад ёо ёо байна

Шинэ түүхий эдтэйгээ залгахаас өмнө “Эрдэнэт хивс”, “Гоёо” зэрэг ноос, ноолуурын үйлдвэр бараг хаалгаа барихдаа хүрээд байга аж. Учир нь, энэ оны нэгдүгээр сарын 1-нээс Тэмдэгтийн хураамжийн хууль хэрэгжиж эхэлсэн нь ноос, ноолуурын үйлдвэрүүдийн хувьд том бул хар чулуу босгожээ. Юу тэр вэ гэхээр ноос, ноолуурын үйлдвэрүүдэд угаахаас авахуулаад цөөнгүй шат дамжлагад химийн бодис хэрэглэдэг. Гэтэл Тэмдэгтийн хураамжийн 21.1.1-д Байгаль орчинд онцгой хор нөлөө учруулж

болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 8000000 төгрөгийн татвар авна. 21.1.3-д Химийн хортой болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдаалах, устгах, тусгай зөвшөөрөл олгоход 75000000 төгрөгийн татвар ногдуулна гэж тусгажээ. Та хар даа, байгаль орчинд онцгой аюултай хор нөлөө үзүүлэх химийн бодист юу орох билээ. Мөнөөх алдартай цианит натри.



Гэтэл ийм аюултай химийн бодисын тусгай зөвшөөрлд 8000000-хан сая төгрөгийн татвар, онц аюултай биш хортой бодист нь 75000000 төгрөгийн төлбөр хураамж төлөхөөр байгааг юу гэж ойлгох вэ?

Ноос, ноолуурын үйлдвэрт ашигладаг угаах бодис нь НҮБ-аас гаргаж, дэлхий нийт мөрддөг онц аюултай болон хортой бодисын жагсаалтын аль алинд нь байдаггүй аж. Гэтэл манайх шинэ Тэмдэгтийн хураамжийн хуулиар химийн л бодис бол хуульд заасан төлбөр хураамжийг төлөх ёстой гэж гэдийж, үйлдвэрүүдэд асуудал үүсгээд байгаа нь хачирхалтай. Хамгийн гол нь хууль дүрэм хэрэгжүүлэгч яам тамгын газрын холбогдох албаны хүмүүс нь хуулиа уншиж ойлгодоггүй нь дараах баримтаас тодорхой харагдана. Монголын ноос,

ноолуурын холбооны дэд тэргүүн Ёндонсамбуу гуай БОАЖЯ-нд манай үйлдвэрүүд Тэмдэгтийн хураамжийн хуулиас болоод хил дээрээс химийн бодисоо авч чадахгүй хүндрэл учраад байна гэдгээ тайлбарласан бичиг хүргүүлсэн чинь удтал байсны эцэст тус яамны нэг газрын даргаас нь “Танай химийн бодисыг уг жагсаалтад оруулаад өгье” гэсэн утгатай хариу ирүүлж, гайхширалд оруулжээ. Тэмээ гэхээр ямаа гэдэг шиг юм болж Ёндонсамбуу гуай арга ядахдаа “...химийн бодис л бол хортой, хоргүй ялгаагүй 21.1.3-д хамааруулна гэсэн заалт байдаг юм бол бид хуулиа дээдэлж, хураамжаа төлье” гэж хүртэл бичиж суугаагаа үзүүлэв. Тэрхүү асуудал хариуцаж байгаа хурган дарга нь НҮБ-аас гаргасан дэлхий даяар мөрддөг хортой бодисын жагсаалтын дагуу БОАЖ сайд, Эрүүл мэндийн сайдын тушаалаар химийн хортой болон аюултай бодисын жагсаалтыг хавсралтаар гаргасныг ч мэддэггүй бололтой. Тэр жагсаалтад нь ноос, ноолуурын үйлдвэрлэгчдийн хэрэглэдэг химийн бодис багтдаггүй юм билээ. Багтах ч үндэслэл байхгүй аж. Учир нь, ноос ноолуурын салбар нь дэлхийд нэрд гарсан компани пүүсийн чанарын шаардлага хангасан будаг, химийн материал хэрэглэж үйлдвэрлэлээ явуулдаг байна. “Говь”, “Гоёо”-гийн бүтээгдэхүүнийг зөвхөн хэрэглээндээ хайхрамжгүй ханддаг монголчууд хэрэглээд зогсдоггүй. Япон, Америк, Англи, Итали гээд дэлхийн өнцөг булан бүрээс захиалга өгч байгаа. Тэд өмсөх зүүхдээ хүртэл идэх хоол шигээ анхаардаг улс шүү дээ. Тиймээс аль орноос авсан ямар химийн бодис хэрэглэдэг вэ гэдгийг захиалгаа өгөхдөө л асууж шалгааж, үзэж хардаг байна. Ялангуяа япончууд бол энэ тал дээр бүр няхуур гэнэ. Ёндонсамбуу гуай “Бидний үсээ угаадаг шампунь гэсэн үг шүү дээ. Хүний хэрэглэхийг нь анхилуун үнэр оруулчихдаг, үйлдвэрт хэрэглэх нь элдэв гоё үнэргүйгээрээ ялгаатай. Ийм юмыг л ойлгож өгөхгүй чирэгдэл учруулаад байх юм. Үйлдвэрлэл явуулахд ёо ёо байна” гэж үнэхээр залахсан байдалтай хэлэв. Гааль дээрээс авч чадахгүй байгаа химийн бодисын жагсаалтыг нь сонирхож үзлээ. Их Британи улсаас импортлож байгаа зөөлрүүлэгч, угаалгын бодис, ноосны тосолгооны

бодис, цайруулагч, органик саван, шампунь, органик хүүхдийн бие угаагч, органик шил цэвэрлэгч гэсэн жагсаалт байв. Юм мэддэг хүмүүст бол угаалгын бодисын хайрцагных нь дээр сертификат, кодтойгоо бүх зүйл нь тодорхой байдаг аж. Монголын ноос, ноолуурын холбооныхон БОАЖЯ-ыг асуудлыг шийдээд өгөх байх гэж харсаар суугаад, сүүлдээ учир байдлаа Улаанбаатар хотын гаальд танилцуулж, ханджээ. Гаалийнхан

уг бодисоос дээж авч, шинжлээд өгч болох юм байна гэж үзсэн ч холбогдох төрийн яам нь хөдлөхгүй байгаад эргэлзсэн бололтой юм. “Ер нь өгөхөө болилоо. БОАЖЯ-наас олгож болно гэсэн бичиг аваад ир” гэсэн аж. Хөхөөтэй юм гэдэг шиг хачирхалтай байгаа биз.

Мөн Ёндонсамбуу гуай НӨАТ-ын тухай хуульд хоёр гуравхан газар бяцхан нэмэлт, өөрчлөлт оруулаад л асуудлыг шийдчих юман дээр л Засгийн газар хөдөлж өгөхгүй явсаар

байгаад малчид, үйлдвэрлэгдийг улам холдуулаад байх юм. Энэ хүнд цаг үед дотоодын хамтын ажиллагаа хамгаас чухал байна. Манайд төсөл хэрэгжүүлсэн нэгэн япон мэргэжилтэн “Үйлдвэрлэл, Засгийн газар хоёр нэг амьсгаатай, нэг халаасанд орж байж хөгждөг” гэж хэлж байсан. Тэр зүгээр ч нэг хэлчихээгүй юм шиг байна. Ямар нэгэн зүйл ажиглаад л хэлж. Манай Засгийн газар ноолуурын үйлдвэрлэлийг уг нь ойлгож, дэмжих

Шилдэг эссэ

Монгол орны Хөдөө аж ахуйн салбарын хөгжилд миний оролцоо

Гадаадад амьдарч буй иргэдийнхээ эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулахаар гаргаж буй бүтээлч, шинэ санаа санаачлагыг дэмжих, төр, засагтаа санал бодлоо хүргэх боломжийг бүрдүүлэх зорилгоор зарласан “Эх орныхоо хөгжилд – Миний оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд тэргүүн байр эзэлсэн нийтлэлийг уншигчдадаа хүргэж байна.

А.Наранбаатар

/Ирланд, Дублин хот, Дублины их сургуулийн мастер/

НҮБ дэргэдэх хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас (FAO) гаргасан судалгаагаар дэлхийн хүн ам 2050 он гэхэд 9.8 тэрбумд хүрч, өнөөдрийнхтэй харьцуулахад 42 хувиар өсөх ба ялангуяа хурдацтай хөгжиж байгаа Хятад, Энэтхэг (Дэлхийн хүн амын 40 хувь) ба ОХУ-ын хүн амын өсөлтийг дагаад хүнсний хэрэгцээ ихээхэн нэмэгдэж, малын гаралтай мах, сүүн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээний огцом өсөлтийг хангах нь ирээдүйн тулгамдсан асуудал болох юм. Сүүлийн 30 жилд хөгжиж байгаа орнуудын махны хэрэгцээ 150 хувиар, сүүний хэрэгцээ 60 хувиар өссөн. 2030 он гэхэд 44 хувиар нэмэгдэнэ гэж гаргасан.

Дэлхий нийтээрээ өнөөдөр тогтвортой хөгжил болон байгаль орчны талаархи асуудлыг хурц тавих болжээ. Бид өдөр болгон мэдээллийн суваг бүрээр шахуу озоны давхарганы нимгэрэлт, сэргээгдэх эрчим хүч, ногоон хувьсгал болон дэлхийн дулааралт гэж сонсож байгаа. Энэхүү байгаль, цаг уурын өөрчлөлт нь Монгол орны хөдөө аж ахуйд ихээхэн нөлөөлөл үзүүлж, олон сая мал ган, зудад үрэгдэж, олон айл өрх хот суурин бараадах болсон. Мөн дээр яриад байгаа том гүрнүүд ч мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийхээ хэрэгцээг ирээдүйд хэрхэн хангах талаар тодорхой бодлого баримтлан арга



хэмжээнүүдийг авч байгаа хэдий ч өөрсдийн хэрэгцээг ирээдүйдээ импортгүйгээр хангах боломжгүй юм байна. Хэдийгээр ашигт малтмалаас улсад орох орлого өсөх нь тодорхой болж, түүнд тавих анхаарал дийлээд байгаа манай орны хувьд хөдөө аж ахуйн салбарын хөгжилдөө ч чухалчлан ач холбогдол өгч хөгжүүлэх талаар ихээхэн зүйлийг хийх хэрэгтэй байна. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээл асар том учир экспортоос ихээхэн орлого олж, ирээдүйд өсгөн нэмэгдүүлэх боломж байгаа.Өнөөдөр манай улсад малаас хүнд халдварладаг өвчнөөр (zoonosis) хүмүүс өвчилж байгаа нь сэтгэл эмзэглүүлсэн асуудлын нэг. Малыг өвчлөлийг таслан зогсоох боломжтой. Үүнийг зөвхөн Төрөөс дорвитой бодлого боловсруулж, хөрөнгө мөнгө гаргаж, далайцтай арга хэмжээ авч байж л хийх ажил. Бид малаа эрүүлжүүлэхгүйгээр хүн амаа эрүүл байлгаж чадахгүй.

Малын өвчлөлийг зогсоож, хяналт тавихад малыг бүртгэлжүүлэх ажил зайлшгүй шаардлагатай. Малыг бүртгэлтэй болгосноор малын шилжилт хөдөлгөөнийг хянах, зах зээл дээрх малын гаралтай түүхий эд,

бүтээгдэхүүнүүдэд хяналт тавих боломж бүрдэх ба тухайн бүтээгдэхүүн аль малчны хотноос гарсан болох, эрүүл гэдэг нь баталгаатай эсэх, тухайн мал улсын бүртгэлээс хасагдсан эсэх гэх мэт мэдээллийг гаргаж болно. УИХ-аар 2008 онд “Малын онлайн бүртгэл” хуулийн төслийг З.Энхболд гишүүн оруулсан хэдий ч шийдвэрлэгдээгүй буцаагдсан. Бэлчээрийн мал аж ахуйд тохирсон бүртгэлтэй бол бид малын өвчний тархалтыг цаг алдалгүй хянах, хулгай болон алдагдаж сарнихаас сэргийлэх, олон улсын экспортыг нэмэгдүүлэх гэсэн олон талын ач холбогдолтой.

Өнөөдөр Засгийн газрын болон гадаадын хөрөнгө оруулалттай малыг бүргэлтэй болгох төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа гэх боловч тодорхой, харагдахуйц үр дүн гарахгүй байгаа. Мөн дэлхийн хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын малын бүртгэлийн практикуудад тулгуурлан Монгол орны мал аж ахуйд тохирсон загварыг нэвтрүүлэх нь нэн чухал. Дараах ажлуудыг хийж болох юм:

- Малын бүртгэлийг туршилтын хэлбэрээр бүсчилэн, дэс дараатайгаар нэвтрүүлж, адуу, үхэр, тэмээг эхлээд бүртгэлд хамааруулах.
- Малчин өрх бүрийг кодын системд оруулах, энэ нь малын шилжилт хөдөлгөөн, вакцинжуулалт, эрүүл мэндийг хянахаас гадна хулгайгаас хамгаалах, алдагдсан малыг таних ач холбогдолтой.
- Бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр давхар хийх,
- Малыг (ялангуяа адууг) паспортжуулах, чихний зэмэг болон микрочип (RFID) гэсэн төрлөөр бүртгэлд оруулж болно.

Өнөөдөр бид малаа бүртгэлжүүлж, дэлхийн улсуудын жишигт хүргэчихвэл цаашдаа улам боловсронгуй болгож, бүтээгдэхүүний гарцыг сайжруулж, тоо толгойн өсөлтийг түргэсгэж, зардлыг багасгах гэх мэт дэс

дараатай арга хэмжээнүүдийг авч хөгжүүлээд явах боломжтой юм. Төр засгаас хөдөө аж ахуйн салбартаа алсыг харсан оновчтой бодлого баримталж, судалгаа, шинжилгээний багуудын үйл ажиллагааг өргөжүүлж, тэдгээрийн гаргасан дүгнэлт дээр үндэслэн зөв далайцтай арга хэмжээнүүдийг авбал өргөн уудам нутагтай, мал аж ахуйн асар их туршлагатай манай улсын хувьд мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх ихээхэн боломж байгаа. Энэ салбарыг хөгжүүлснээр дараах үр дүнд хүрэх болно:

- Малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйн асуудал шийдэгдэнэ,
- Малаас хүнд халдварладаг өвчлөл үгүй болно,
- Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ,
- Ажлын байр нэмэгдэнэ.
- Экспортыг нэмэгдүүлнэ,
- Хөдөөгийн ард иргэдийн амьдрал сайжирна,
- Хөдөөгөөс хот руу нүүх нүүдлийг багасана

Төрөөс тавих хяналт суларснаас хойш малын олон төрлийн өвчний тархалт нэмэгдсэн. Бид үргэлж өвчтэй малын мах идэх, сүү ууж байсан ард түмэн биш. Үүнийг шийдвэрлэх боломж гарцаагүй байгаа, манай орон мал аж ахуйгаа дэлхийн стандартад нийцүүлэн авч явах цаг тун ойрхон байгаа гэдэгт би итгэлтэй байгаа. Ялангуяа судалгаа, шинжилгээний байгууллагууд шинэ төрлийн овор багатай, илчлэг ихтэй малын тэжээлийг гаргаж, үйдвэрлэх тал дээр түлхүү ажиллах хэрэгтэй. Мал аж ахуйн салбарын хөгжилд илчлэг ихтэй тэжээл зайлшгүй шаардлагатай.

Мөн дэлхийн улс орнуудын мал аж ахуйн хөгжлийн түүх, онцлог, алдаа оноог одоогийн байдал, хэтийн төлөвтэй нь харьцуулан судалж манай оронд ямар бодлого, чиг хандлага, арга, туршлагыг нэвтрүүлбэл алдааг нь давталгүй алгасаж, оноог нь нэвтрүүлж болох юм бэ.

Хоолны бизнес

Тахиа, пицца захиалмаар байна уу?

Улаанбаатар хотын хүн ам өдөр ирэх тусам нэмэгдэж буй. Үүнийг дагаад үйлчилгээний газар олон, тэр дундаа нийтийн хоолны. Өрсөлдөөн их ч гэж жигтэйхэн. Хаа сайгүй, энд тэндгүй жижиг цайны газруудаас авахуулаад том ресторонууд Япон, Солонгос, Хятад гэх мэт орон орных. Тэгвэл “зайгүй” энэ салбарт ашигтайхан ажиллачих нүх сүв бас байнаа, цаана чинь. Энэ бол хүргэлтийн үйлчилгээ. Манайд хоол хүргэлтийн үйлчилгээ анх 1996 оноос эхэлжээ. Мэдээж пиццагаар. Харин завгүй хүмүүсийн сонголт нэгээр нэмэгдсэн нь тахианы мах хүргэлтийн үйлчилгээ юм.

Хоол хийх гэтэл залхуу чинь хүрээд эсвэл ажил ихтэй амжихгүй, гадуур хооллоё гэхээр орой болчихсон байна уу? Тэгвэл танд хүргэлтийн үйлчилгээ хэрэг болно. Утас цохиод л болоо. Хэрэв та хүргэлтийн үйлчилгээ захиалах бол хэдэн зүйл дуулгая. Юун түрүүнд, хэдэн минутын дотор хүргэж ирэхийг асуугаарай. Таны захиалга байрлал, хүргэлтийн унаа зэргээс шалтгаалан

дунджаар 30-40 минутын дараа “ирнэ”. Хол газар бол хүргэж чадахгүй гэнэ эсвэл нэмэлт мөнгө авж магадгүй шүү. Зарим оронд захиалгын үйлчилгээний байгууллага “Бид 30 минутын дотор хүргэж өгнө. Үгүй бол та үнэгүй аваарай” гэх мэт уриатай. Харин Улаанбаатарт ийм “тэнэг” уриа хэлэх “гэнэн” газар мэдээж байхгүй. Арга ч үгүй биз юу л байна машин бас түгжрээ байхад. Мартын наймны өмнөх өдөр буюу долоонд Mr.Chicken рүү захиалга өгөхөөр утас цохитол 30-40 минут болохыг хэлэв. Гэтэл захиалга ихтэй байсан уу цаг гаран хүлээсэн юм. Уг нь гэрээт 40, гэрээт бус 50-60 машин байнгын хүргэлтэд явдаг гэсэн.

Та захиалгандаа ямар амтлагчийг хэр хийхийг ч “тушааж” болно. Учир нь бид “хаан” шүү дээ. Үнэ, дагалдах зүйлийг сайн тодруулах хэрэгтэй. Аягүй бол зарим нэг “юм” нь дутуу байж магад. Захиалсан бүтээгдэхүүн тань халуунаараа байх ёстой нь мэдээж. Гадны оронд бүтээгдэхүүний сав баглаа боодол тэр ч бүү хэл хүргэлтийн цүнхнийхээ материалд нухацтай



<http://www.mongolianeconomy.mn>

Газрын нэр	Бүтээгдэхүүний төрөл	Үнэ	Хүргэлт	Түүхий эдээ хаанаас авдаг	Хаяг	Дагалдах зүйлс
Mr.Chicken	Тахианы гуяыг 2 төрлөөр бүрж шарсан /2-3 хүний порц/	24900	24 цагийн турш 20-30 минут	НВЦ	Баруун 4 зам, 13-р хороолол, 19-р хороолол 332277, 1950	Ундаа, соус, шарсан төмс, салфетка
BBQ chicken	Шаржигнууртай, утаж гриллдсэн, сармис цуугаар амталсан	17000-23000	40-50 минут / хүргэлтийн үнэ 1000 төг, Москва хорооллоос цааш хүргэхгүй/		5-р сургуулийн хажууд 70163000	Кола ундаа, цагаан манжингийн хачир
Queen chicken	Хуурай, соустай, холимог /2-4 хүний/	18500-19500	30-40 минут 10-24 цаг хүртэл /хотын төвд үнэгүй, хол бол 2000 төг/	Tyson	Төмөр замын дээд сургуулийн урд 333435	Даршилсан цагаан лууван, кола ундаа, эко тор
Chekovo	Тахианы мөч, тахианы нуруутай гуя	18000-20000	24 цагаар 30-40 минут	Американ тахиа	10-р хороолол 50001100	Ундаа, талх, салат
Питолстойка куленир	Тахианы мөч, тахианы утаж гриллдсэн гуя	10000-15000	30-40 минут /хүргэлт 1000-6000 төг/	НВЦ	Бичил хороолол 95934444	Амталсан будаа, соус, байцааны салат

Пицца хүргэлтийн зарим газрууд

Газрын нэр	Бүтээгдэхүүний төрөл	Үнэ	Хүргэлт	Хаяг	Дагалдах зүйлс
Mr.Pizza	Саямитай, кимчитэй, махтай, холимог гэх мэт 9 төрлийн	14900-18900	24 цагаар 30-40 минутад хүргэлт үнэгүй	Баруун 4 зам, 332277, 1950	кола ундаа, соус
Chicago pizza	Нэрийн, холимог, хавай, саямитай 4 төрлийн	16000-18000	хүргэлт үнэгүй	10-р хороолол 50001100	пепси ундаа
Pizza della casa	Туна, хиамайттай, тахианы мах, үхрийн махтай, ногооны гэх мэт 19 төрлийн	15000-17000	хүргэлт үнэгүй	Улсын их дэлгүүрээс цирк уруудах замд 99094172, 324114	ундаа
Pizza king	Холимог, тахианы махтай, хавай, ногоотой	18900-23500	хүргэлт үнэгүй	Хүнсний 1-р дэлгүүр 320900	дарсан өгөрцийний хачир
My pizza	Холимог, хавай, ногооны, гахайны махтай гэх мэт 10 төрлийн	12900, 14900, 21900	24 цагаар хүргэлт үнэгүй	Баруун 4 зам 50045454	пепси ундаа

Гэр бүлийн бизнес ойлголцоход амар байдаг

Тэмдэглэсэн И.Отгонжаргал

Манай сэтгүүлийнхэн “New idea & business” булангийнхаа энэ удаагийн зочдоор “Батбайгаль” компанийн захирал С.Байгальмаа, “Энхжин сувинер” компанийн захирал Э.Урхан нарыг урилаа. Бизнесийн завгүй хөдөлмөрийн хажуугаар үр хүүхдээ төрүүлж, өсгөх, эхнэрийн, эзэгтэйн их ажлаа амжуулах, гоо сайхандаа анхаарах гээд эмэгтэй хүний хувьд бизнес эрхлэнэ гэдэг амаргүй. Энэ бүхнийг амжуулж, шалгуур өндөртэй бизнесийн талбарт амжилттай яваа дээрх хоёр бүсгүй нь МУХАУТ-аас хоёр жилд нэг удаа шалгаруулдаг “Lady entrepreneur-2009”-ын Оны онцлох хатагтайгаар шалгарч байжээ. Бялууны үйлдвэрлэл, гар урлалын салбарт өөрийн гэсэн мөрөө гаргаж яваа энэ хоёр эмэгтэй өсч томрох, өргөжин тэлэх өрнүүн тэмүүлэлтэй бизнесмэн хүүхнүүд. Тэдний яриа олон сонирхолтой сэдвийг хөндөж чадсан.

С.Байгальмаа:

Манай салбарыг сонирхож байгаа хүн байх юм бол бид юмаа зааж өгнө

-Бизнесээ анх яаж эхэлж байсан бэ?

С.Байгальмаа:

-Ерээд онд зах зээлийн ороо



бусгаа үе байсан. Тухайн үед наадам болсон санагддаг юм аа. Наадмын дараа харсан чинь бүх дэлгүүрийн лангуу хоосорчихсон байсан. Ер нь бол гэртээ бялуу хийж, зарим дэлгүүрт тавьдаг байсан л даа. Тэрийгээ бизнес болгоё. Харин яаж эхлэх вэ гэдэг талаар бодож, ярилцдаг байсан. Би тэгэхэд төрчихсөн, хүүхэд маань нэг ой гарантай байсан. “Яг одоо л эхэлмээр байна. Оройтлоо шүү, гялс эхэлье” гээд нөхрөө байн байн шахна аа. Эрэгтэй хүн болохоор цаг хугацааг хардаг байсан ч

байх, ямар ч гэсэн над шиг нэг их адгаад байдаггүй байсан юм. Тэгээд ч манай хүн тэр үед өөр ажил эрхэлдэг байсан. Бид хоёр нэг ахдаа энэ талаараа хэлдэг байсан. Тэр ах маань одоо манай зөвлөх хийдэг л дээ. Тэгсэн нэг өдөр ах “Та нар яг хийж чадах уу?” гэж асууж байна. “Чадна чадна” гэсэн. Тэгсэн ах маань 600 ам.долларын зээл олж өгөөд, “За одоо хэрэгтэй тоног төхөөрөмжөө аваад, бэлдээд тавьчих” гэсэн. Ах бас нэлээд шамдуулдаг байсан л даа.

Тухайн үед дөнгөж зах зээлд



Зүүн гар талаас: *С.Байгальмаа /"Батбайгаль" компаний захирал/
Э.Урьхан /"Энхжин сувинер" компаний захирал/*

орж байсан болохоор газраа хаана түрээслэхээ ч мэдэхгүй. Манай найзын нэг хоосон байшин байхаар нь зуурагч, шарх шүүгээгээ аваачиж тавиад эхэлж байсан. Ажлаа эхлээд сар арай болоогүй байсан чинь, 17 дугаар сургуулийн хажуу дахь дэлгүүр нарийн боовны цех байсан газар түрээслэнэ гэж дуулаад, очиж үзэнгүүтээ л "болно болно" гээд шууд орчихсон /инээв/. Тэгж л бизнесээ эхлүүлж байсан даа. Санаа бол тэр үед Улаанбаатарт бялууны ганц, хоёрхон газар байсан санагддаг юм. Харахаар л санаанд

багтаад бялууны зах зээлийг илүү өргөжүүлж чадна гэсэн хүсэл байсан л даа.

-Тухайн үед "Жүр үр" гарч ирсэн байсан уу?

-Хараахан гарч ирээгүй байсан. Одоо бодоод байхад бэйкэри юм шиг байна лээ. Оросод намайг сурч байхад кулинар кондитирский цех гээд хажуугаар нь гарахаар нэг их гоё үнэртдэг газрууд байсан. Ер нь оюутан байхын цаанаа тийм нууцхан хүсэл байсан юм шиг байгаа. Тэгээд л бид нэг их удалгүй Германы

Элчин сайдын яамны хажуу талын салбараа нээсэн. Анхны хэрэглэгч рүүгээ ойртсон алхам тэр байсан. Одоогоос 14 жилийн өмнө манайд дэлгүүрийн бизнес төдийлэн сайн хөгжөөгүй байсан. Бүтээгдэхүүнээ лангуугаар тараадаг байлаа. "Далай ээж", "Меркури", "Дөрвөн -Уул" зэрэг хүнсний захын хувь хүмүүст өгдөг байсан.

Э.Урьхан:

-Ер нь бол бизнесийн түүх замнал ерөнхийдөө адилхан юм байна /инээв/. Би зураач мэргэжилтэй. Оюутан байхаасаа л сонин, сэтгүүлийн газарт "халтуур" хийдэг байсан. Өнөөдрийнх шиг компьютер энэ тэр байгаагүй. Манай аав бас зураач хүн л дээ. Аавтайгаа хоёулаа байгалийн хатаамал хийгээд ханын чимэглэл болгоод бас л Байгальмаа эгч шиг гадуур лангуунуудаар өгдөг байсан. Тэр үед "Их дэлгүүр"-ийн тавдугаар давхарт бэлэг дурсгалын тасаг байсан, тэнд өгнө. Яваандаа олон төрлийн бүтээгдэхүүн хийгээд ирэхээр өөрийн гэсэн лангуутай болох шаардлага гарсан. Тэгээд "Цэцэг" төвд анх лангуу түрээслэсэн. Тухайн үед бол хэцүү л байсан. Хамаг орлогоо лангууныхаа түрээсэнд өгчихөөд 1500 төгрөг атгаад үлдэж байсан үе ч бий. Гэхдээ би шантраагүй. Хажуугаар нь сургуульдаа сураад л, юмаа ч хийгээд бүгдийг амжуулаад явсан. Лангууныхаа ард гар урлалынхаа бүтээлийг хийгээд л сууж байдаг байлаа шүү дээ. Сүүлдээ "Цэцэг" төвөөс гараад "Мөнгөн завъяа"-д өөрийн гэсэн лангуутай болсон. Тэгээд жилийн өмнөөс "Энхжин сувинер" гээд өөрийн төвийг байгуулсан. Манай төв хэрэглэгчдэд гар урлал хийгээд бэлэг дурсгалын цогц үйлчилгээг хүргэдэг. Мөн манайх арьсан эдлэлийн үйлдвэрлэл явуулдаг.

-Танай компанийн нэр сонирхол татсан. Эзнийг нь Энхжин гэдэг юм байх гэж таамаглаж байлаа шүү дээ.

-Манай том охиныг Энхжин гэдэг. Одоо 13 настай.

-Эмэгтэй хүмүүсийн хувьд бизнес эрхлэнэ гэдэг амаргүй. Та хоёрын хувьд ажил амьдралаа хэрхэн зохицуулдаг вэ? Гэр

бүлийн бизнесийн онцлог юу байдаг бол?**С.Байгальмаа:**

-Гэр бүлийн бизнесийн онцлог гэх юм бол хамтраад, хүсэл зорилго нэгтэй нэг зүгт харж чаддаг болохоор "Чи тэрийгээ тэгээрэй, би үүнийг ингэе" гэх байдлаар ажлаа арай хялбар ойлголцоход амар байдаг юм болов уу. Хэрвээ манай бизнесийн хувьд нөхөр маань өөр ажил хийдэг байсан бол надад маш хүнд байх юм шиг санагддаг. Хүнсний үйлдвэрлэл гэдэг чинь маш эгзэгтэй, хариуцлагатай ажил байдаг. Дээр нь аж ахуй гэж том зүйл бий. Борлуулалтын тэрэгнүүд, машин тоног төхөөрөмжүүд, ус, цахилгаанаас өгсүүлээд үйлдвэрт маш их асуудал гарна. Бид хоёр нөхрийнхөө ахын гэр бүлтэй дөрвүүлээ хамтарч хийдэг. Хүүхдүүд нь ч гэсэн сургуулиа төгсөөд энэ бизнес рүү орж байгаа. Ажлаа хуваагаад авчихад гэр бүлийн бизнес амар байдаг.

Эмэгтэй хүний хувьд бизнес эрхлэнэ гэдэг мэдээж сайн хань нөхөр, ах дүү, хамт олны хүчинд явдаг гэж боддог. Бид баярт зориулсан хүнс хийдэг болохоор гэр бүлээ баярлуулахаасаа илүүтэй хэрэглэгчдээ бялуугаар тасалчихгүй байх юмсан гэдэг үүднээс баярын үеэр хагас цэргийн зохион байгуулалтад ордог. Тийм тийм материал аваад, тэгж тэгж ажиллана, тийм тийм хүмүүс хариуцлагатай жижүүрт гарна гээд бүх ажлаа хувааж авна. Юуг ч дутуу хийж болохгүй. Хамгийн наад зах нь бялууны хайрцагны боодол хүртэл чухал. Хэрвээ бялуугаа боодолгүй өгчих юм бол хэрэглэгч маань савчиж явж байгаад унагаачих тохиодол байдаг. Тэрийг хүртэл маш нарийн бодож төлөвлөж хийдэг л дээ.

Гэр бүлээ баярлуулж эхэндээ амждаггүй байсан сүүлийн үед амжуулаад байгаа. Хүн бүхэн ажлаа хувааж аваад, баяр гэдгийг өөрсдөө мэдрэхтэйгээ болж байгаа шүү. Тэгэхгүй бол хүүхдүүд хүртэл зүрх сэтгэл нь аав, ээжийнхээ бизнес рүү чиглэчихдэг юм шиг байгаа. За за аав ээж ажилтай юм чинь бид нар баярлах ч яах вэ гэсэн бодолтой болчихдог юм шиг санагддаг. Тэр бүхнийг зохицуулж сурч байна аа.

Э.Урьхан:

-Байгальмаа эгч бид хоёрын бизнес баярын үеэр адилхан хүн баярлуулж, ачаалалтай ажилладаг юм байна. Манай хувьд зундаа борлуулалт харьцангуй сайжирдаг. Аялал жуулчлалын улирал эхлэхээр жуулчид олноороо үйлчлүүлдэг. Өвөл ч гэсэн муугүй ээ. Монголчууд сүүлийн үед баярыг өргөн тэмдэглэж, нэгэндээ бэлэг өгөх дуртай болсон.

Мэдээж гэр бүлийн бизнес эрхлээд өдий зэрэгтэй явж байгаа маань гэр бүлийн хүний нөмөр нөөлөгийн ач тус л даа. Санасан бодсоноо хийж хэрэгжүүлэхэд хань маань ойлгож, тусалж дэмжихгүй бол хэцүү шүү дээ. Залуу хүмүүсийн хувьд үр хүүхдээ гаргаж, өсгөх, ажил амьдралаа авч явах гээд хүндрэлтэй л дээ. Шаргуй хичээсний дүнд өөрсдөө ч гэсэн биеэ эрүүл авч явахаа мэддэг. Тийм болохоор үр хүүхдээ ч төрүүлж, өсгөнө, ажлаа ч хийнэ. Ээж аав, ах дүү нар бас туслана л даа. Яаралтай ажил гарлаа гэхэд хүүхдээ оруулж орхиод явна. Тиймэрхүү юмнуудаа сайн мэддэг болохоор байр саваа ч гэсэн ээж аавынхаа хажууд авах жишээтэй. Үнэнийг хэлэхэд тэгж л зохицуулахгүй бол болдоггүй. Улсын ажил биш болохоор төрөх орон дээр гарчихсан байсан чиг л утсаар ярьж, "Тэгсэн үү, ингэсэн үү" гээд ажлаа амжуулна шүү дээ/инээв/. Иймэрхүү бужигнаан дунд л амьдрал өнгөрч байна л даа. Тэрнээсээ ч гэсэн эрч хүч авч амьдардаг. Ачаалал ихтэй, юм юм зохицуулаад яваа хэрнээ огт ядардаггүй. Ажил маань бүтэж, үр хүүхэд маань өсч том болж байвал зовлон бэрхшээлийг умартаад л, 4-5 нас хүрэх үед нь дахиад нэгийг гаргачихдаг ч юм бил үү гээд явдаг.

-Бэлэг дурсгалын бизнесийн онцлог юу байдаг вэ?

-Бид худалдаандаа маш их шинэ зүйл санаачилдаг. Яагаад гэхээр хүнд бэлэг өгөхөд өгч байгаа хүн ч сэтгэл хангалуун, авч байгаа хүн нь ч сэтгэл хангалуун байх ёстой ш дээ. Манайх шинэ төвөө нээхдээ бэлэг дурсгалын цогц үйлчилгээг нэвтрүүлсэн. Тэр нь юу вэ гэхээр манайхаас бэлэг авч байгаа хүнд дурсгалын үг үнэгүй бичиж өгч, сав баглаа боодлоор үнэгүй үйлчилдэг болохоор худалдан авагч маань сэтгэл өндөр гардаг. Одоогоор

манайх шиг бүх үйлчилгээг нэг дороос өгч байгаа газар бараг байхгүй л дээ.

Мөн манай гар урлалын салбарт мэргэжлийн хүнцөөн. Тийм болохоор ерөнхийдөө суурь хүмүүжил сайтай хүүхдүүдийг сургаж авдаг. Тэдэндээ хэрэглэгчдэдээ бараагаа яаж танилцуулахыг заана, инээхийг сургана.

-Манай үйлчилгээнд тэр инээсэн үйлчилгээ үнэхээр дутагдаж байгаа шүү.

-Манайхан хүнтэй харилцах харилцаан дээр их дутагдалтай санагддаг. Эелдэг үйлчилгээ, үйлчилгээний соёлыг Азид бол Хятад, Солонгос хоёр улс үнэхээр сайн нэвтрүүлж байна. Бид тэднээс суралцах ёстой.

-Сүүлийн үед монголчууд баярыг өргөн тэмдэглэдэг болсон. Бялуугүй баярын ширээ гэж байхаа больсон. Жил бүрийн гуравдугаар сард бялуу үйлдвэрлэгчид хамгийн ачаалалтай ажиллахаас гадна орлого сайн байдаг байх.

С.Байгальмаа:

-Манай үйлдвэрлэл улирлын чанартай л даа. Өвлийн улиралд олон баяр ёслол тохиодог болохоор борлуулалт сайн байдаг. Шинэ жил, Цагаан сар, Валентин, Март, Цэргийн баяр гээд ар араасаа хөвөрдөг. Хүмүүс яагаад ийм ойр ойрхон баяр тэмдэглээд байна гээд шүүмжлэлтэй ханддаг. Манай нөхцөлд цаг агаар хүнд болохоор тэр болгон гараад баярлаад байх боломжгүй. Тийм болохоор би хувьдаа монголчуудыг байр ойрхон тэмдэглээд байгааг буруутгадаггүй. Чадаж л байвал тэмдэглэж л байг л дээ/инээв/.

-Танайх бол маш өрсөлдөөнтэй салбар шүү дээ. Сүүлийн үед өрсөлдөөнд ямар өөрчлөлт, онцлог ажиглагдаж байна вэ?

-Сүүлийн үед өрсөлдөөн маш хүчтэй болж байгаа. Эхэн үедээ бид манлайлж явж байсан бол сүүлийн үед хараад байхад хүмүүс халуун, шинэ нарийн боов идэх хүсэлтэй болсон. Тэгэхдээ тэр шинэ нарийн боовоо яг үйлдвэрлэж байгаа газар дээрээс нь авч хэрэглэх сонирхолтой. Хэрэглэгчийг хараад сууж байхад нь дэргэд нь үйлдвэрлэл явагдаад, тэр сайхан үнэрийг нь гаргах чиглэлд нарийн

боовны хөгжлийн чиг хандлага яваа. Нэг үгээр хэлбэл, ширээнээс ширээнд хүрэх тэр түвшинд хүрээд байгаа.

-Танайх энэ чиглэлээр хэр ажиллаж байгаа вэ?

-Бид нарт нэгэнт эргэсэн хүрдийг зогсоох эрх байхгүй. Баярын дараа нэг өдөр хаая гэхэд ерөөсөө зогсох аргагүй болчихжээ. Манайх “Батбайгаль” гэсэн салбар дээрээ нарийн боовоо үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргээ гэсэн төлөвлөгөө бий. Мөн бид хүмүүст ах дүү, хамаатан садан, ойр дотныхоо хүнтэй ороод тухтай үйлчлүүлэх хаус ресторан нээсэн. Эндээ цогц үйлчилгээ явуулахыг эрхэмлэдэг. Халуун бэйкэри, халуун хоол, халуун ундаа гээд өөрийнхөө юу хийж чадаж байна тэрүүгээрээ үйлчилдэг. Манай энэхүү шинэ кафе, ресторанд зочлоход шинэлэг үйлчилгээг мэдрэх болно гэдгийг танай уншигчдад дуулгая.

Үүнээс гадна үйл ажиллагаагаа өргөжүүлэхтэй холбоотой Франчайзингийн үйлчилгээний чиглэлээр ажилладаг юм бил үү гэсэн бодолтой байгаа. Хүмүүс “Танайх чиглэлийн юмыг хиймээр байна, яаж хийх үү, танайх юмаа зааж өгөөч” гээд нэлээд хандаж байгаа. Бид үүнийг бодож үзээд, Франчайзингийн үйл ажиллагааг яаж нэвтрүүлдэг туршлагыг судалж байна. МҮХАҮТ-ын франчайзингийн гишүүн болсон. Хэрвээ хууль дүрэм нь гарах юм бол энэ чиглэлд ажиллана гэсэн бодолтой байгаа. Франчайзингийн үйлчилгээ гэдэг нь манай салбарыг сонирхож байгаа хүн байх юм бол бид юмаа зааж өгөөд, хөрөнгө оруулалтын тал дээр хамтарч ажиллана гэсэн үг. Ирээдүй бол иймэрхүү харагдаж байгаа.

Э.Урьхан:

-Одоо бол манай гар урлал хоёр хөршдөө нэг юмаараа нэр хүндтэй байгаа

-Монголын гар урлалын бүтээгдэхүүн чанар муутай санагддаг. Хүнд бэлэглэхээс өмнө салаад унах нь энүүхэнд. Үүнийг чанаржуулж, сайжруулах талаар юу хийх ёстой вэ?

-Үнэн үнэн. Монголын гар урлал гэхээр тээвэрлэлтийн явцад салаад уначихдаг, халуун оронд очихоороо арьс нь умайгаад

татчихдаг, эсгийн бүтээгдэхүүнээс нь эвгүй үнэр гардаг ч юм уу. Үүнийг бид сайжруулахын тулд юу хийх ёстой вэ гэхээр хамгийн гол нь үйлдвэрлэлдээ анхаарах ёстой. Бид гадаад худалдааг эрхлээ гэж бодож байгаа бол бараагаа чанаржуулах л шаардалагтай. Нэг ч өө сэвгүй байх ёстой. Одоо бол манай гар урлал хоёр хөршдөө нэг юмаараа нэр хүндтэй байгаа л даа. Монголчууд хиймэл материалаар хийдэггүй, жинхэнэ цэвэр арьсаар хийдэг гэдгээрээ нэр хүндтэй яваа. Өөрөөр хэлбэл, бидний болхи бүдүүлэг байдал нь нэр хүндтэй яваад байгаа. Жинхэнэ арьсаар хийдэг бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулахад манай гар урлал гадаад зах зээлд гарах бүрэн боломжтой.

Монголын хүн ам цөөхөн болохоор бидний үйлдвэрлэл тооны хязгаартай байдаг. Нэг бүтээгдэхүүнийг 2000 ширхэгээс илүү хийж болдоггүй. Заавал загвараа солих хэрэгтэй болдог. Нэг хэтэвч гаргалаа гэхэд 1000-аас илүү хийж болохгүй. Арьсан хэтэвчийг хэдэн жил хэрэглэнэ ш дээ. Чанар нь тэндээ байдаг. Нэг хүн хоёрыг авч хэрэглэхгүйгээс цааш. Дээр нь гадаад зах зээлээ маш сайн судлах хэрэгтэй байдаг. Зах зээлд чанартай бараа хүргэхийн тулд үйлдвэрлэлээ сайжруулах ёстой. Үйлдвэрлэл явуулахын тулд маш сайн бэлтгэгдсэн боловсон хүчин хэрэгтэй байна. Тийм хүмүүсийг бэлтгэхийн тулд өөрсдөө дунд нь орж ажиллахаас аргагүй болдог. Сургууль байгуулахын тулд наад зах нь багш нараа өөрсдөө бэлтгэх хэрэгтэй. Манай гар урлалын зах зээлийг хөгжиж байна гэж хэлэхэд хэцүү. Уг нь бол хөгжүүлэх санаа нь байгаад байдаг. Цаг хугацаа яваад байдаг /инээв/.

С.Байгальмаа:

-Манай монголчууд өмсөх хувцасаа урдаас оруулаад ирж байна. Тэгэхээр бэлэг дурсгалын зүйлсээ л жуулчдад сайн борлуулах хэрэгтэй байх. Ирсэн хүн бүрт зараад явуулах хэрэгтэй юм шиг байна лээ. Уг нь тэр боломж нь байгаад байх шиг байгаа.

Э.Урьхан:

-Тэр боломж нь байгаа. Манайх дэлгүүртээ ирж байгаа гадаад

хүмүүст “Та дараа манайхаар үйлчлүүлээрэй” гээд нэг түлхүүрийн оосор өгчих жишээтэй. Тэр хүн баярлалаа гэж гараад заавал эргэж ирдэг. Гадаадынхны сэтгэл нь тийм гоё. Манай монголчууд болохоор стресстэй, ширүүн хүмүүс юм шиг байгаа. Орж ирэхэд нь “Сайн байна уу” гээд угтахад, хариу зөлдөгээр мэндлэх хүн ховор ш дээ. Өмнө нь бөхөлзөөд байхаар гарахынхаа үед сэтгэл нь арай өөр болдог/инээв/.

-Жижиг, дунд үйлдвэрлэлийг сүүлийн жилүүдэд маш их дэмжиж байгаа. Та хоёрын хувьд жижиг, дунд бизнесийн зээлд хэр хамрагдаж байна вэ?

С.Байгальмаа:

-Мэдээж бизнес явуулахад зээлгүй бол хэцүү. Бид нар чинь ямар өв хөрөнгө өвлөж ирсэн биш. Сүүлийн үед банкууд утасдаад “Танайх зээл авах уу, бид нар ийм ч бага хүү санал болгож байна” гээд байгаа л даа. Ер нь бол зээлээр л үйлдвэрлэлээ босгосон.

Э.Урьхан:

-Бизнесийн ганц түлхэц нь зээл болдог. Жижиг, дунд бизнесийн зээлд байнга л хамрагдаж байгаа. Зээл авах чинь нэг талаасаа их зөв юм билээ. Хүнээс юм авчихсан болохоор заавал буцааж өгөх ёстой гэж өөрсдийгөө шахааж ажилладаг сайн талтай.

С.Байгальмаа:

-Тийн шүү, зээлтэй байх чинь өөрийгөө шахааж шаардахад хэрэгтэй байдаг. Миний нэг танил хэлж байсан. Зээлээ төлөөд дуусчихсан чинь юмаа хийх сонирхолгүй болчихлоо гэж /инээв/. Бурхны номд өр бүү тавь, зээл бүү хий гэдэг юм билээ. Гэхдээ бидний хувьд зээл хэрэг болсон. Хүү нь бага л байх юм бол бид цаашаа илүү ихийг хийнэ. Хүүнд баригдах тал бий. Түүнээс биш, хийх зүйл бол маш их байна.

Э.Урьхан:

-Биднийг зээлийн хүүгээр дэмжээд өгөх юм бол гар урлалын салбарт маш ихийг хийх боломж бий. Бидэнд нэгдүгээрт, хүн хүч дутагддаг. Хоёрдугаарт, хөрөнгө мөнгө нь алга. Өөрсдийнхөө хүчээр яваад байна гэдэг бол бид яст

PPP
Булан
С.Бэхбатын



PPP түншлэлээр 10 орчим төслийг хэрэгжүүлэхэд бэлэн боллоо



ТӨХ-ны зөвлөх Д.Байлихүүтэй уулзаж, түншлэлийн төслүүдийн талаар тодрууллаа.

-Концессын тухай хууль батлагдаад нэг жил боллоо. Энэ хугацаанд ямар ажил, арга хэмжээ явуулав аа?

-Концессын хууль нь манай улсад шинэ зүйл. 1980-иад оны Мардайн ураны ордод хийсэн Концессын гэрээг эс тооцвол өмнө нь хийж байгаагүй ажил. Бид төр хувийн хэвшил, түншлэлийн талаар баримтлах бодлого болон энэ чиглэлийн хуулийг гаргах гэж бараг 10 шахам жилийг зарцуулсан. Одоо хууль болон бодлого нь гарсан боловч амьдралд хэрэгжүүлэхэд бидэнд мэдэхгүй чадахгүй зүйл их байна. Бид төр, хувийн хэвшил, түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслөө зөв сонгохоос эхлээд хийх ажил үнэхээрийн олон бий. Өнгөрсөн жил Засгийн газраас ойрын жилүүдэд төр, хувийн хэвшил, түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж болох төслүүдийн жагсаалтыг батлан гаргасан ба энэ жагсаалтад 120 гаруй төсөл орсон. Гэтэл үүнээс яг аваад хэрэгжүүлэх бэлэн төсөл нь 10 ч хүрэхгүй цөөхөн байна. Одоогоор дээрх төслүүдээс хоёрыг нь сонгоод нийтэд зарласан. Бидний хүсч буй шаардлагыг хангасан оролцогч хир зэрэг олон ирэхийг одоо хэлэхэд эрт байна. Хувийн

хэвшлийнхэн чинь өөрт нь ашиггүй л бол төрийн зүгээс хийлгэх ажилд тэр бүр орохгүй шүү дээ. Үүнээс гадна дэд бүтцийн төслүүдэд төрийн зохицуулалтын орчин нь тодорхой, ойлгомжтой, өөрөөр хэлбэл, урт хугацаанд тогтвортой байж л бусдын ялангуяа бидний хүсдэг том хөрөнгө оруулагчид орж ирнэ. Гэтэл дээрх төслийн ихэнх хувь нь энэ талд тун хангалтгүй байна. Бид энэ талаар цаашдаа их зүйл хийх шаардлага байгаа. Үүнээс гадна манай зүгээс өөрийн хүмүүсийг сургаж бэлтгэх талаар манайд тусалдаг донор орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтарч хэд хэдэн төсөл хэрэгжүүлж байгаа. Эдгээр төслүүдийн хүрээнд 20 гаруй мэргэжилтнийг гадаад орнуудад сургаж дадлагажуулах ажлыг зохион байгууллаа. Мөн дотоодоо холбогдох яамд болон орон нутгийн засаг захиргааны ажилтнууд, хувийн хэвшлийнхэнд зориулсан сургалтыг 10 гаруй удаа хийсэн байна.

-Одоо ямар төслийг хувийн хэвшлийнхнээр гүйцэтгүүлэхээр зорьж байна вэ?

-Өмнийн говьд авто зам барих хоёр төслийн тендер зарлаад байна.

-Концессын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зүйл ажиглагдсан гэж зарим бизнесмэн ярьж байна лээ. Ер нь энэ хууль хэр чанартай болсон бэ?

-Хуулийн хувьд олон жил ярьж хэлэлцэж байж батлагдсан шүү дээ. Гадныхан туслалцаа ч авсан. Ялангуяа АХБ анхаарал ихэд хандуулж, туслалцаа үзүүлсэн. Энэ утгаараа сайн хууль болсон. Ойрын үед энэ хуулийг шууд өөрчлөх шинэчлэх тухай асуудал гарахгүй байх. Харин зарим төслийг хэрэгжүүлэх явцад тодорхой болгох зүйл гарахыг үгүйсгэхгүй.

- PPP түншлэлийн төслийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод явуулах чиглэлээр ямар санаа оноо байгаа бол?

-Яг одоогоор хэрэгжээд эхэлсэн төсөл байхгүй байна. Зарласан төслийг нийтэд сурталчлах, шалгаруулах, ялагчийг сонгох болон хэрэгжилтийн явцын талаар үнэхээр нийтэд тогтмол мэдээлж ил тод байх нь төслийг үр дүнтэй болгох хамгийн чухал зүйл. Одоо ил тод байх талаар маш их ярьдаг, шаардах ч болсон цаг. Иймд энэ асуудалд том ахиц гарах байхаа. Бид ч их хичээж байгаа.

Төслүүдийн жагсаалт

Засгийн газраас баталсан төр, хувийн хэвшил, түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалт

№	Концессын зүйлийн нэр	Концессын зүйлийн тодорхойлолт	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх
Нэг. Орон сууц, барилга байгууламжийн төслүүд						
1	Орон сууцны ХIY хороолол төсөл	Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх	Барих-өмчлөх-ашиглах	Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
2	Орон сууцны ХIY хорооллын дэд бүтэц	Орон сууцны хорооллын дэд бүтэц барих	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
3	“Зүүн сэлбэ” хороолол төсөл	Орон сууцны хороолол болгон хөгжүүлэх	Барих-өмчлөх-ашиглах	Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
4	“Зүүн сэлбэ” хорооллын дэд бүтэц	Орон сууцны хорооллын дэд бүтэц барих	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
5	Орон сууцны YII хороолол төсөл	Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх	Барих-өмчлөх-ашиглах	Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
6	Орон сууцны YII хорооллын дэд бүтэц	Орон сууцны хорооллын дэд бүтэц барих	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
7	МҮОНРТ орчмын хороолол төсөл	Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх	Барих-өмчлөх-ашиглах	Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
8	МҮОНРТ орчмын хорооллын дэд бүтэц	Орон сууцны хорооллын дэд бүтэц барих	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
9	“Гандантэгчинлэн хүрээ хийд” хороолол төсөл	Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх	Барих-өмчлөх-ашиглах	Орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний төв, спорт цогцолбор, ногоон байгууламжийн хамт барих	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
10	“Гандантэгчинлэн хүрээ хийд” хорооллын дэд бүтэц	Орон сууцны хорооллын дэд бүтэц барих	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Цахилгаан, дулаан, усан хангамж, зам зэрэг инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барих, санхүүжүүлэх, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах

(Энхүү 120 гаруй төслийн жагсаалтыг цувралаар хүргэх болно)

Тэрбумтнуудын халаас руу өнгийе

Д.Наташа

“Forbes” сэтгүүл бөмбөрцгийн толгой баячуудын чансааг тодорхойлсоор 25 дахь жилтэйгээ золгож буй. Энэ онд уг сэтгүүлийн 50 гаруй сурвалжлагч дэлхийн 13 оронд ажиллаж, тэрбумтнуудын компани, үл хөдлөх хөрөнгө, дарвуулт завь, үнэт зүйлс, урлагийн бүтээл, бэлэн мөнгө зэргийг нь үнэлж, нэг үгээр хэлбэл баячуудын халаас руу өнгийснөөр нэлээд сонирхолтой дүгнэлтэд хүрчээ. Юу гэвэл шинэ үеийн чинээлэг хүмүүс хөгжингүй гүрнүүдээс биш, хөгжиж буй орнуудаас “мэндлэх” болсон байна.

2011 оны дэлхийн тэрбумтнуудын жагсаалт 1210 хүнийг багтааж буй нь түүхэнд байгаагүй өндөр үзүүлэлт болохыг “Forbes” сэтгүүлийн хамт олон онцолжээ. Гэвч зөвхөн тооны хувьд бус чанарын хувьд ч нэлээд ахиц гарсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Дээрх 1210 хүний эзэмшиж буй хөрөнгө 4.5 их наяд ам.долларт хүрснээр ХБНГУ-ын нийт эдийн засагтай дүйцэж, мөн л рекорд тогтоосон байна. “Тэрбумтнуудын томоохон нийлүүлэгчид хөгжиж буй орнууд болжээ” хэмээн “Forbes” тэмдэглээд, Бразил, ОХУ, Энэтхэг болон Хятад улс жагсаалтад шинээр орж ирсэн 214 тэрбумтны 108-ыг “төрүүлсэн” тухай онцлов. Ази-Номхон далайн бүс нутагт 332 тэрбумтан амьдарч байгаа нь өнгөрсөн жилийнхээс даруй 98-аар их үзүүлэлт ажээ. Хөгжиж буй орнуудад өндөр ашигтай бизнес явуулах боломжтойгоос гадна ийм улсуудын ДНБ-ийг авч үзэхэд л хөгжингүй орнуудынхаас хэд дахин хурдацтай өсч байгааг сануулах юун. Харин АНУ эсрэгээрээ байр сууриа алдсаар. Хэдийгээр тус улс хамгийн олон тэрбумтантай орон хэвээр байгаа ч хэзээ нэгэн цагт энэ суудлаа алдахгүй гэхийн аргагүй. Эдүгээ “Forbes” сэтгүүлийн жагсаалтын гурван хүн тутмын нэг нь Америкийн иргэн байна. Гэвч 10 жилийн өмнө хоёр хүний нэг нь америк байсныг дурсахад илүүдэхгүй болов уу.

Жагсаалтын эхний гурван хүний нэр өнгөрсөн жилийнхээс өөрчлөгдсөнгүй, харин тэдний эзэмшиж буй хөрөнгийн хэмжээ л нэмэгджээ. 2010 онд “Forbes”-ын жагсаалтын түрүү магнайд Мексикийн тэрбумтан Карлос Слим орсноор дэлхийн толгой баянаар анх удаа америк биш хүн тодорсон билээ. Харин энэ жил мексик эр үзэгдээд өнгөрөх биш, удаан хугацаагаар ирснээ харуулж, манлайлагчийн байр сууриа улам бататгасан юм. Ганц жилийн дотор Слимийн хөрөнгө 20.5 тэрбум ам.доллараар нэмэгдэж, эдүгээ 74 тэрбум ам.доллар хэмээн үнэлэгджээ. Харин аман хүзүүдэж буй Билл Гейтс “өрдөө” 56 тэрбум ам.доллартай байгааг тооцоолж үзвэл Слим тэргүүний сэнтийгээс ойрын хэдэн жилдээ буухгүй байх хандлагатай. Олон жилийн турш бөмбөрцгийн хамгийн баян хүн хэмээн цоллуулж байсан Гейтс жагсаалтад өөрийн дараа орж

буй найз Ворен Баффетын хамт хөрөнгөө буяны ажилд зарцуулснаар Мексикийн бизнесмэнийг урдуураа оруулчихсан гэх үндэслэл бий.

Дэлхийн хамгийн баян 10 хүнийг авч үзэхэд ихэвчлэн тэтгэврийн насныхан байна. Гэхдээ эндээс зөвхөн хижээл насныхан тэрбумтан болдог гэсэн дүгнэлтэд хүрч болохгүй. Жагсаалтад орж буй “Facebook”-ийн үүсгэн байгуулагч Марк Зукерберг, Дастин Москович нар 27 настайгаа ч золгоогүй байх жишээтэй. Дашрамд сонирхуулахад, 2011 оны хамгийн амжилттай компаниар “Facebook” шалгарсан байна. Эдүгээ зах зээлийн үнэлгээ нь 50 тэрбум ам.долларт хүрсэн тус компани дэлхийн баячуудын жагсаалтад зургаан залуу тэрбумтан “бэлэглэсэн” тухай “Forbes” онцолжээ.

Харин хорвоогийн хамгийн баян бүсгүйчүүдийн танилцуулгаас мөн л сонирхолтой дүр зураг ажиглагдах аж. Хөрөнгийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлэх 20 эмэгтэйн жагсаалтаас харахад зөвхөн Хятадын иргэн Ву Яхун л өөрийн чадлаар мөнгө хуримтлуулж чаджээ. Түүний үүсгэн байгуулсан “Longfor Properties” компани урд хөршийн барилгын салбар томорч байгаатай зэрэгцэн өргөжиж буй аж. Харин бусад нь хөрөнгөө өвлөж авсан нь сонирхол татна. Бөмбөрцгийн хамгийн баян эмэгтэйн байр суурийг сүүлийн жилүүдэд хадгалж буй Кристи Волтон 26.5 тэрбум ам.доллараар ерөнхий жагсаалтын 10 дугаарт бичигдсэн байгаа юм. Тэрбээр өөрийн нөхөр Жон Волтоныг нас барахад “Wal-Mart” дахь эзэмшлээ өвлөж авчээ.

Мексик эр дэлхийн толгой баяны суудлаа хоёр дахь жилдээ хадгалж үлдсэний зэрэгцээ Билл Гейтсээс даруй 18 тэрбум ам.доллараар их хөрөнгө эзэмшиж байна. Түүний мөнгө ганц жилийн дотор 20.5 тэрбум ам.доллараар нэмэгдэхэд Мексикийн хөрөнгийн зах зээл 19 хувиар өсч, песогийн ханш чангарсан нь багагүй түлхэц болжээ. Мөн Карлос Слимийн мэдэлд байдаг “Grupo Carso” амжилттай ажилласан байна. Тэрбээр харилцаа холбооны компани Латин Америкийн “America Movil” компанитай



1 Карлос Слим Элу

Хөрөнгө: 74 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Telcel”
Нас: 71
Иргэншил: Мексик

нэгтгэснээр хөрөнгөө үлэмж ихээр арвижуулж чаджээ. Карлос Слим эдүгээ худалдааны “Saks” сүлжээ дэлгүүр болон “New York Times” сонинд хувь эзэмшдэг. Саяхан тэрбээр Мехикод “Soumaya” гэдэг музей нээж, урлагийн бүтээлийн агуу цуглуулгаа дэлгэн тавьжээ. Энэхүү музейд хүмүүс үнэгүй зочилж болох юм байна.

“Microsoft”-ын үүсгэн байгуулагч, Америкийн хамгийн баян иргэн Билл Гейтс өөрийн найз Воррен Баффетын хамт “Giving Pledge” гэх буяны хөтөлбөрийг санаачилж, одоогоор 60 тэрбумтныг сайн үйлсийн төлөө нэгдэхийг ятгаж дөнгөсөн билээ. Гейтс өөрийн буяны санд 30 тэрбум ам.доллар зарцуулсан болохоор эдүгээ “Forbes” сэтгүүлийн жагсаалтыг тэргүүлж чадахаа байсан аж. “Bill & Melinda Gates Foundation” сангийн хөрөнгийг сүрьеэ, маляри зэрэг халдварт өвчлөлттэй тэмцэж, ДОХ-ын эсрэг вакцин гаргаж авах ажлыг түргэвчлэхэд зарцуулдаг юм байна. Түүнчлэн ганд тэсвэртэй үр тариа бий болгох ажлыг санхүүжүүлж, дунд сургуулийн багш нарын ур чадварыг дүгнэх систем боловсруулахад нэлээд анхаарч байгаа гэнэ.



2 Билл Гейтс

Хөрөнгө: 56 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Microsoft”
Нас: 55
Иргэншил: АНУ



3 Воррен Баффет

Хөрөнгө: 50 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Berkshire Hathaway”
Нас: 80
Иргэншил: АНУ

12 нас хүрэхдээ л хөрөнгө оруулалтын тухай бараг бүх номыг уншиж дуусгасан Воррен Баффет бизнесийн гараагаа эрт эхэлжээ. Колумбын их сургуульд байхдаа тэрбээр домог болсон хөрөнгө оруулагч Бенжамин Грэмтэй танилцсанаар амьдралаа эрс өөрчилсөн гэдэг. 1965 онд бөс барааны “Berkshire Hathaway” үйлдвэрийг авч, төд удалгүй хүнс, даатгал, эрчим хүч, үйлдвэрлэлийн асар том холдинг болгосон байна. “Berkshire Hathaway” компанийн зах зээлийн үнэлгээ өнгөрсөн онд л гэхэд 15 хувиар өсч, Баффетын хөрөнгийг гурван тэрбум ам.доллараар нэмэгдэхэд нөлөөлжээ. 80 настай “буурал” маань одоо ч томоохон хэлэлцээрүүдийн араас хөөцөлдсөөр. Гэхдээ олсон ашгаа сайн үйлсэд зориулахаа ч мартсангүй. Билл

Гейтсийн хамт дэлхийн толгой баячуудыг хөрөнгийнхөө талыг буяны үйлст зарцуулахыг ятгадаг нэгэн билээ. 2009 онд Баффет 26 тэрбум ам.доллараар “Burlington Northern Santa Fe” төмөр замыг худалдаж авч байв.



4 Бернар Арно

Хөрөнгө: 41 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: LVMH
Нас: 62
Иргэншил: Франц

Чинээлэг амьдрал, тансаг хэрэглээний хаан Бернар Арно Европын хамгийн баян хүний суудлаа дахиад л хадгалж үлдлээ. LVMH (Louis Vuitton, Moët & Chandon и Hennessy) холдингийн зах зээлийн үнэлгээ хоёр дахин өссөн нь дэлхийн эдийн засгийн хямрал цаашилж, Азийн орнуудад олноороо төрж буй саятан, тэрбумтнуудын хэрэглээ нэмэгдсэнийх биз ээ. Ганц жилийн дотор Бернар Арногийн хөрөнгө 13.5 тэрбум ам.доллараар өссөн байна шүү дээ. “Dom Perignon” оргилуун дарс, “Hennessy” коньяк, “Tag Heuer” брэндийн цаг болон “Louis Vuitton”-ы бараа, бүтээгдэхүүн... Дээдсийн амьдралын бэлгэ тэмдгийг бий болгогч Бернар Арно утаатай Улаанбаатарт нэгэн эзэмшилтэй болсон нь манай Сүхбаатарын талбайн дэргэд орших “үнэтэй” дэлгүүр юм. Тэрбээр мөн дарвуулт завь үйлдвэрлэгч “Royal Van Lent”, Францын сүлжээ дэлгүүр болох “Carrefour”, аялал жуулчлалын “Go Voyages” компанийн эзэмшигч билээ. Өнгөрсөн онд LVMH холдинг “Hermès”-ийн 20 хувийг худалдаж авсан байна.



5 Ларри Эллисон

Хөрөнгө: 36 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Oracle”
Нас: 66
Иргэншил: АНУ

“Oracle” компанийн үүсгэн байгуулагчийн хөрөнгө сүүлийн нэг жилийн хугацаанд 11.5 тэрбум ам.доллараар нэмэгдсэнд тус компанийн хувьцааны ханш 30 хувиар өссөн нь нөлөөлжээ. Ер нь Ларри Эллисон нийт 40 тэрбум ам.доллараар 75 компани худалдаж авсан байдаг. Америкийн хамгийн өндөр цалинтай захирлуудын тоонд ордог Эллисон сүүлийн таван жилийн хугацаанд 960 сая ам.долларын орлоготой ажиллажээ. Гэхдээ саяхнаас яагаад ч юм бэ цалингаа нэг ам.доллар болтол гэнэт бууруулсан. Дарвуулт завины спорт сонирхдог тэрбээр өөрийн үнэ цэнэтэй цагаасаа бүхэл бүтэн 10 сар болон 100 сая ам.доллар зарцуулж, Америкийн тэмцээнээс цом

авахаар өрсөлдсөн байна. Үр дүнд нь 66 настай эр 2010 оны хоёрдугаар сард түүнийгээ авч чаджээ. 39.5 тэрбум ам.долларын эзэн Ларри Эллисон өөрийн хөрөнгийн 95 хувийг буяны ажилд зарцуулна гэдгээ мэдэгдээд буй.

6 Лакшми Миттал

Хөрөнгийн хэмжээ: 31.1 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: гангийн үйлдвэрлэл
Нас: 60
Иргэншил: Энэтхэг

7 Амансио Ортега

Хөрөнгийн хэмжээ: 31 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Zara”
Нас: 74
Иргэншил: Испани

8 Эйке Батиста

Хөрөнгийн хэмжээ: 30 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: уул уурхай, газрын тос
Нас: 54
Иргэншил: Бразил

9 Мүкеш Амбани

Хөрөнгийн хэмжээ: 27 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: нефть, хий
Нас: 53
Иргэншил: Энэтхэг



10 Кристи Волтон

Хөрөнгө: 26.5 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Walmart”
Нас: 56
Иргэншил: АНУ

“Wal-Mart”-ын эзэмшигч Жон Волтон 2005 онд авто ослоор нас барахад хөрөнгийг нь эхнэр Кристи нь өвлөж үлджээ. Гэхдээ Кристи зүгээр суусангүй. Нарны эрчим хүчний “First Solar” компанид хөрөнгө оруулснаар мөнгөө нэлээд өсгөж, дэлхийн хамгийн баян эмэгтэй болж чадсан юм. 2006 онд IPO хийсэн тус компанийн үнэлгээ 500 гаруй хувиар нэмэгдсэн гээд бод доо. Гэвч Кристи Волтоны хөрөнгийн гол эх үүсвэр нь мэдээж “Wal-Mart” дахь эзэмшил нь билээ. Өнөөдөр “Wal-Mart”-ын борлуулалт 420 тэрбум ам.долларт хүрч байгаагаас гадна 2.1 орчим сая хүнийг ажлын байраар хангаж байгаа юм. Кристи мөн л буяны ажилд гар татдаггүй нэгэн бөгөөд боловсрол, соёл, байгаль орчныг дэмждэг ажээ.

11 Ли Ка Шин

Хөрөнгө: 26 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: олон салбарт үйл ажиллагаа явуулдаг
Нас: 82
Иргэншил: Хонконг

12 Карл Албрехт

Хөрөнгө: 25.5 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Aldi”
Нас: 91
Иргэншил: ХБНГУ

13 Стефан Перссон

Хөрөнгө: 24.5 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “H&M”
Нас: 63
Иргэншил: Швед

14 Владимир Лисин

Хөрөнгө: 24 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: Гангийн үйлдвэрлэл
Нас: 54
Иргэншил: ОХУ

15 Лилиан Бетанкур

Хөрөнгө: 23.5 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “L’Oreal”
Нас: 88
Иргэншил: Франц

16 Шелдон Адельсон

Хөрөнгө: 23.3 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: казино
Нас: 77
Иргэншил: АНУ

17 Дэвид Томсон

Хөрөнгө: 23 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: ХЭВЛЭЛ, мэдээлэл
Нас: 53
Иргэншил: Канад

18 Чарльз Кох


Хөрөнгө: 22 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: олон салбарт үйл ажиллагаа явуулдаг
Нас: 75
Иргэншил: АНУ

19 Дэвид Кох

Хөрөнгө: 22 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: олон салбарт үйл ажиллагаа явуулдаг
Нас: 70
Иргэншил: АНУ

19 Жим Волтон

Хөрөнгө: 21.3 тэрбум ам.доллар
Эх үүсвэр: “Walmart”
Нас: 63
Иргэншил: АНУ



Амжилтын түүх

“Би дэлхийг илүү нээлттэй болгохыг хичээж байна”

Ц.Болормаа

Дэлхийн 12 хүн тутмын нэг нь компьютерийнхээ ард суухдаа цэнхэр өнгө бүхий цахим хуудсыг нээх зуршилтай болжээ. Тийм ээ, энэ бол “Facebook”! Нарт хорвоод мэндлээд найм дахь жилтэйгээ золгож буй “Facebook” эдүгээ 600 сая хэрэглэгчтэй болж амжжээ. Хэрвээ “Facebook” улс байсан бол хүн амын тоогоороо дэлхийд гуравдугаарт эрэмбэлэгдэх юм. Интернет ертөнцөд хувьсгал хийсэн уг сүлжээг “Time” сэтгүүлийн “2010 оны хүн”, “Vanity Fair” сэтгүүлийн “Хамгийн нөлөөтэй хүн”, мөн “Esquire”-ын тодруулж байснаар “Хамгийн онцгүй хувцасладаг” 26 настай буржгар үст, сэвхтэй залуу Марк Зукерберг үүсгэн байгуулсан билээ. Их сургуульд орохдоо болзоонд явах анхны ойлголтгүй байсан бүрэг ичимхий түүнийг дэлхийн хагас тэрбумаас ч илүү хүний талархлыг хүлээсэн цахим хуудсыг бий болгоно гэж хэн ч санаагүй болов уу. Энэ түүх Харвардын их сургуулийн дотуур байранд хоёрдугаар дамжааны оюутан өрөөний гурван найзтайгаа хамтран шинэ санаагаа бодит амьдрал дээр хэрэгжүүлж байгаагаар эхэлнэ.

Анх Харвардын их сургуулийн

оюутнуудын хооронд мэдээлэл солилцох гүүр болж байсан ч цаашдаа бусад сургуулийг, бүр дэлхийн бүх насны хүмүүсийг хамарч чадсан хүчирхэг сүлжээг Марк Зукерберг хэрхэн бий болгов оо? Өдөр бүр 700 мянган хэрэглэгч “Facebook” сүлжээнд шинээр нэгдэж байгаа бөгөөд 2012 он гэхэд нэг тэрбум болж бүл нэмнэ гэсэн тооцоо ч гарчээ. Энэ гуравдугаар сарын байдлаар Монгол Улс л гэхэд “Facebook”-ийн 132 мянган хэрэглэгчтэй болсон байх жишээтэй.

Байнга холбоо барьж чаддаггүй нэгэнтэйгээ харилцах, бөмбөрцгийн нөгөө талд байгааг ч үл харгалзан хүсэл сонирхлоороо нэгдэх гээд маш олон боломжийг “Facebook” бидэнд олгодог. Энэхүү цахим хуудсанд 600 сая хүн сар бүр 30 тэрбум мэдээлэл оруулж, 700 тэрбум цагаа зарцуулж буй. Цэнхэр цахим хуудсанд гар утаснаасаа холбогдогчдын тоо 200 саяас ч давжээ. Энэ янзаараа “Facebook” сүлжээнд донтох “өвчин” ч гарч магадгүй бололтой. Гэсэн ч 50 жил холбоо тасарсан найзаа олсон, Японд болсон газар хөдлөлтийн үеэр хүмүүсийн мэдээллээ солилцох гол хэрэгсэл нь болж чадсан зэргээр “Facebook”-ийн ач холбогдлыг

дурдвал дуусахгүй урт жагсаалт гарах вий. Хэрвээ уг цахим хуудсын нийт хэрэглэгчдийг байрлалаар нь төсөөлж цэнхэр өнгөөр будвал дэлхий нэлдээ цэнхэр өнгөтэй болох биз. Ер нь цэнхэр өнгө нь их учир жанцантай. Юу гэвэл Марк Зукерберг зарим өнгийг сайн ялгаж чаддаггүй, хамгийн сайн хардаг өнгө нь цэнхэр юм гэсэн.

Маш сандруу Марк Зукерберг нэлээд хугацааг хөх углааштайгаа үдсэн байна. Хөл нь “агаар амьсгалж” байхад арай илүү тайван байж чаддагаа ч тэрбээр нууддаггүй. “Энгийн, ичимхий” гэж өөрийгөө хоёр үгээр тодорхойлсон Марк Зукерберг дэлхийн хамгийн баян залуу болсон ч хөлсний байранд амьдарч, хэлхгэр жинсэн өмд, хямдхан богино ханцуйтай цамц өмсдөг хэвээрээ. Гэтэл ажилчид нь түүнээс ч ганган машинтай гэнэ билээ. Марк Зукерберг өөрийн 2000 гаруй ажилчдадаа орчноо хүссэнээрээ тохижуулж, тоглоом тоглож, бүр хувцсаа цэвэрлэгээнд өгөх боломж олгон “эрхлүүлдэг”. Хариуд нь зөвхөн “Ажлаа хийвэл хийсэн шиг хий, үгүй бол гэртээ харь” гэх шаардлага тавьдаг ажээ. Энэ нь түүний хэр зарчимч хүн болохыг

Facebook -ийг үүсгэн байгуулагчид

Марк Зукерберг,
Дастин Московиз,
Крис Хагис



харуулах шиг.

Марк Зукерберг нэрээрээ олны танил болсон Марк Эллиот Зукерберг 1984 оны тавдугаар сарын 14-нд Нью-Йоркийн Доббс Ферри тосгоны эмчийн гэр бүлд төржээ. Эцэг Эдвард Зукерберг нь нэгэнтээ түүнийг байнга л “яагаад” гэж шалгадаг хүүхэд байсан тухай дурссан байдаг. Зукийн амьдралын түүхийг сөхвөөс гэнэт л “цойлоод” гарч ирсэн биш, угаасаа агуу сэтгэгч гэдэг нь ойлгомжтой болно. Түүний авьас билиг дунд сургуульд байхад нь л тодорчээ. Сурагч байхдаа Марк Зукерберг “Synapse Media Player” нэртэй хөгжим тоглуулагч зохион бүтээсэн нь “Slashdot” цахим хуудас, онлайн сэтгүүл болох “PC Magazine”-д хэвлэгдэж байв. Түүнийг нь “Microsoft” болон “AOL” компани худалдаж авах санал тавьж, Зукербергийг ажилд урьсан удаатай. 2002 онд Харвардад суралцахаар элссэн тэрбээр хоёрдугаар дамжаанд суралцаж байхдаа оюутнуудын анги сонголтод тус болох “CourseMatch” программаа зохиож байсан аж. Гэвч Зукерберг удалгүй сургуулиа орхиж, Билл Гейтс, Стив Жобсын адилаар амьдралын замаа “дээд боловсролгүй” хөөсөн юм.

АНУ-ын Засгийн газрын нууцыг дэлгэсэн сөрөг агуулгатай мэдээллүүдийг цацаж байсан “Wikileaks” цахим хуудсын эзэн Жулиан Ассанжийг “Time” сэтгүүлийн 2010 оны хүнээр тодорно гэж олон хүн таамаглаж байв. Гэсэн ч оны хүний ярилцлагад өнөөх л саарал богино цамцтайгаа Марк Зукерберг сууж байх нь тэр. Тэр хоёрыг нэг зоосны хоёр тал гэх нь ч бий. Хоёр нээлттэй байдлыг эрхэмлэдэг ч нэг нь хорвоо ертөнц дайснаар дүүрэн гэж үзэж байхад нөгөөх нь хүн бүр найз болж болно гэх үзлийг сурталчилж байгаа болохоор тэр биз ээ. Гэхдээ тэрбээр Жулиан Ассанжаас нийгэмд

илүү зэрэг нөлөөтэйгээрээ давуу талтай. 2010 оны есдүгээр сард л гэхэд Неваркын сургуульд 100 сая ам.доллар хандивласан тусч, өгөөмөр залуу билээ.

Түүний амьдралыг харуулсан “Social network” кино 2010 оны аравдугаар сард нээлтээ хийсэн. Ер нь кино цахим хуудастай байх нь энгийн үзэгдэл. Харин цахим хуудас кинотой байх тохиолдол тийм ч олон биш болов уу. Гэхдээ дээрх кинонд гардаг үйл явдлын тал хувь нь зохиомол болохыг уран бүтээлчид нь хүлээн зөвшөөрсөн байдаг.

“Facebook” байнга л шинэ зүйлсээр баяжиж, олныг байлдан дагуулсаар. И-мэйл, мессеж бичих, чатлах боломжтой болсон нь энэ төрлийн үйлчилгээний компаниудыг шоконд оруулсан юм. Сүүлийн үед л гэхэд тус сүлжээний хэрэглэгч бүр Холливудын “Warner Bros” компанийн бүтээлийг үзэх боломжтой болжээ. “Warner Bros” компанийн төлөөлөгч Томас Гевеке үүнийг “Тоон системийг ашиглан киногоо арилжих үйл ажиллагааны маань нэг хэлбэр” хэмээн тайлбарлажээ. Энэ нь одоогоор зөвхөн АНУ-ын нутаг дэвсгэрт боломжтой ч ойрын хугацаанд бусад оронд нэвтрэх аж. Энэ мэт “Facebook”-ийн давуу талын жагсаалт цаашид ч хөвөрсөөр байх нь дамжиггүй.

2005 онд “Facebook”-ийг “MTV Networks”-оос 75 сая ам.доллараар худалдан авах санал тавьсны дараа “Yahoo” болон “Microsoft” толгой эргэм мөнгө амласан ч бүтэлгүйтсэн юм. “Yahoo”-гийн захирал Терри Семел “Би өмнө нь 22 настай хэрнээ тэрбум ам.долларын саналд түвэггүйхэн үгүй гэж хэлж байсан хэн нэгэнтэй таарч байсангүй” гэхэд Марк Зукерберг “Энэ бол зөвхөн үнийн тухай асуудал биш. Facebook бол миний хүүхэд л гэсэн үг. Би түүнийг цааш нь хөгжүүлж,

өсгөмөөр байна” хэмээн хариулж байсан гэдэг. Түүнчлэн “Microsoft”-ын Билл Гейтс түүнд “Microsoft office 2007”-г хамтран бүтээх санал тавихад Марк Зукерберг татгалзаж байжээ. Хэрэв зөвшөөрсөн бол тэрбээр 23 настайдаа дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгөтэй болох байв. Гэсэн ч өөрийн гэсэн шинэ брэнд бий болгох хүсэл нь биелж, өдгөө тэр хамгийн баян залуу болоод байгааг сануулах юун.

2009 онд Марк Зукербергийн “Facebook”-ээс эзэмших хувь хоёр тэрбум ам.долларт хүрч, түүнийг хамгийн залуу тэрбумтан болгосон билээ. Тэрбээр 2011 оны гуравдугаар сарын байдлаар “Forbes” сэтгүүлийн гаргасан Америкийн хамгийн баян хүмүүсийн жагсаалтын 19 дугаарт 13.5 тэрбум ам.доллараар бичигдэж байгаа юм. Мөн Марк Зукербергийн өсгөсөн “Facebook” хамгийн амжилттай компаниар шалгарсан байна. Эдүгээ зах зээлийн үнэлгээ нь 50 тэрбум ам.долларт хүрсэн тус компани дэлхийн баячуудын жагсаалтад зургаан залуу тэрбумтан “бэлэглэсэн” тухай “Forbes” онцолжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама өнгөрсөн нэгдүгээр сард “Facebook”-ийг Америк шинэ сэдлийн жишээ гэж магтсанаас сарын дараа технологийн салбарын “акул”-ууд болох “Google”-ийн Эрик Шмит, “Twitter”-ийн Дик Костоло нарын олон “томчууд” уригдахад хоолны ширээний ард Ерөнхийлөгч Обамагийн хажууд “Apple”-ийн Стив Жобс, “Facebook”-ийн Марк Зукерберг нар зэрэгцэн суусныг хэвлэл мэдээллийнхэн ихэд онцолж байсан билээ. Хэрвээ хэн нэгэн Марк Зукербергт сонирхолгүй зүйл яривал “Тийм шүү” гэсэн хэрнээ огт өөр зүгт хараад зогсож байх хэнэггүй зантай. Энгийн, ичимхий тэрбээр найз бүсгүй Присцилла Чантайгаа долоон жил үерхсэн байна. “Facebook”-ээ хүүхэд шигээ санаж, өрөөлөөс харамлан “өсгөж” буй залуу хос маань үрийн зулай үнэрлэж амжаагүй л явна. Гэхдээ тэд саяхнаас гөлөг тэжээж эхэлсэн бөгөөд түүндээ ч “Facebook” хуудас нээхээ яаж мартаж билээ. Марк Зукерберг өөрийн “цэнхэр” хуудсандаа “Би дэлхийг илүү нээлттэй болгохыг хичээж байна” хэмээн онцолжээ. Түүний хичээл зүтгэл ч талаар болохгүй, “Facebook” улам л хүрээгээ тэлж байгааг бид харж байна.

Хөрөнгө оруулалт ба лидер байхын “урлаг”



“Андрей Зотов” /“ADJ Consulting” компанийн удирдагч/

М а н а й
компани хөрөнгө
оруулалтын зөвлөх
үйлчилгээний зах
зээлд 10 дахь жилдээ
ажиллаж байна. Бид
аливаа бизнест дүн
шинжилгээ хийж,
цаашдын хөгжлийн

төлөвлөгөөгөө боловсруулахад нь оролцдог гэх үү дээ. Жил бүр бид 100 гаруй төсөл судалдаг боловч 20 орчмыг нь л ажил хэрэг болгодог бөгөөд тэдэнд хөрөнгө оруулагч олж өгдөг юм. Сонголт хийхдээ манай компани таван зүйлийг харгалзан үздэг бөгөөд энэ удаад гол асуудлыг буюу лидер ямар байх хэрэгтэйг товч танилцуулъя.

Ямарваа нэг төслийг бодож олсон, зохион байгуулсан, амьдралд хэрэгжүүлэхээр зорьсон нэг хүн байдаг. Хэрэв төслийг машин гэж үзвэл тэр хүн хөдөлгүүр нь гэсэн үг. Хөрөнгө оруулагчдын дунд ерөнхий стейкхолдер (хувь эзэмшигч) гэдэг үг ч бий. Гэхдээ энэ нь этгээд сонсогддог, тэгээд ч англи үг болохоор бид “лидер” гэж тэр хүнийг нэрлэе.

Таван жилийн дараа...

Лидертэй анх уулзах үедээ л “Энэ хүн төслийнхөө хэр удаан амьдрахыг мэдэж, багцаалж байна уу” гэдгийг бид ойлгохыг хичээдэг. Төсөл амжилттай байх, эсэх нь түүний хүсэл сонирхол, зорилготой нягт уялдаатай гэдгийг лидер хүн сайн ойлгож, энэ бүхнийг яах гэж хийж буйгаа бусдад ойлгуулан тайлбарлаж чаддаг байх ёстой. “Таван жилийн дараа Таны бизнес ямар хэмжээнд очсон байх вэ?” гэсэн асуултад жинхэнэ лидер түвэггүй хариулчихна. Хөрөнгө оруулагчийн энэ асуултад тодорхой, шийдмэг хариулж чадахгүй байгаа бол төсөл үндсэндээ байхгүй гэсэн үг юм. Жишээ татъя л даа, “Таван жилийн дараа...” гэсэн асуултад Оросын нэгэн бизнесмэн “Бид одоо үйлдвэрлэж буй тоног төхөөрөмжөө дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүргэж, их хэмжээгээр үйлдвэрлэнэ” гэж хариулж. Харин хөрөнгө оруулагчид энэ эрхэм тийм ч зоримог биш гэж бодсон уу, ирээдүйд гарч ирэх боломжийг олж харсангүй юу, юутай ч татгалзжээ. Нэг талаар бизнесмэрийн зөв байсан ч байж болох юм. Энэ компани одоо хүртэл үйл ажиллагаа явуулж буй агаад үнэхээр л үйлдвэрлэлээ таван жилийн өмнөхтэй харьцуулахад одоо өргөтгөсөн. Гэхдээ жилийн өмнө яг энэ бүтээгдэхүүнийг Хятадад хийгээд эхэлчихсэн юм.

Ирээдүйн хувьцаа эзэмшигчид

Үйлдвэр дөнгөж хаалгаа нээсэн ч “том” компани шиг ажиллах ёстой. Дотоод дүрэм журмыг ажилтан бүр сайн ойлгодог, дуртайяа дагаж мөрддөг байх хэрэгтэй. Бидэнтэй хамтарч ажиллаж байсан нэг компанийн ахлах

менежер ажлаа хэр сайн хийж буйгаа “Паша юу гэж бодож байгаагаар” дүгнэдэг тухайгаа ам алдчихсан юм. Паша гэдэг нь тэр бизнесийн эзэн л дээ. Аз болж түүний үг биднийг бодит байдлыг мэдэрч, хамтын ажиллагаагаа эргэж харахад тусалсан. Ер нь нэг л хүнээс хамаарсан, нэг хүн дээр төвлөрсөн ажил, бизнес өргөжин хөгжиж, “том” болоход хэцүү. Сайн лидер бол бизнесийг өөрийнхөө төлөө биш, ирээдүйн хувьцаа эзэмшигчдэдээ зориулан босгож байгаа гэдгээ ухамсарлах ёстой. Үгүй бол хөрөнгө оруулалтын эрсдэл нэмэгдэнэ.

Хүмүүсийг араасаа дагуулж чадах уу

Лидер яаж ажиллаж байна, түүний зан авир, хүмүүстэй харилцаж байгаа байдал, ажилдаа хэрэглэж буй арга барил нь ёс суртахууны хэм хэмжээнд нийцэж байна уу? Энэ нь энгийн ажилтны ч нүдэнд өртөх чанар юм шүү дээ. Сайн лидер ажилчдынхаа итгэлийг хүлээсэн байх ёстой. Хамгийн наад зах нь орлогчоо тэр бүр солиод байдаггүй. Мөн сайн лидерийн ажилтнууд өсөн дэвшиж, амжилтад хүрдэг. Гэхдээ “парадокс” нь юу гэвэл ийм ажилтнууд өөр хүний удирдлага руу ч амархаан хөрвөчих талтай. Тиймээс ч сайн лидер дахиад л “цэргүүд” бэлдэх чадвартай байх ёстой юм.

Нэгэн өвчнийг анагаах төхөөрмөж зохион бүтээсэн Василий Петрович жинхэнэ суут ухаантан байлаа. Бизнесийн төлөвлөгөөгөө боловсруулсан тэрбээр ажилчдыг хэрхэн сонгох, зохион байгуулах талаар мэдлэггүй, мэдэхийг ч хүсдэггүй нэгэн байв. Тиймээс хүмүүсийн эвийг олчихдог, гүйлгээ ухаантай нэгэнд энэ асуудлаа хариуцуулчихжээ (Бидний зөвлөсний дагуу). Тэр ажилчидтайгаа тулж ажилладаггүй ч түүнийг бүгд хүндэлдэг, боловсруулсан төсөл, арга барилыг нь ёсчлон дагадаг. Хамгийн гол нь түүний бизнес одоо ч “гялалзаж” байгаа юм.

Түншийн хувьд итгэл даах уу

Та энэ хүнд итгэж байна уу? Хэрэв тийм бол түүнтэй ярьж тохирч чадах уу? Ямар ч үед өөрийгөө зөвтгөж чаддаг хүнийг лидер гэхгүй. Хөрөнгө оруулагчдаас хүссэн зүйлээ салгаж чаддаг хүнийг ч лидер гэх нь буруу. Учир нь хөрөнгө оруулагч лидерт итгэхгүй байгаа тохиолдолд сайтар боловсруулсан бизнес төлөвлөгөө ч амжилтын баталгаа болж чадахгүй шүү дээ.

Хөрөнгө оруулагчидтай хийдэг ээлжит хэлэлцээрийнх нь дараа “Геннадий, тэдэнд ярьсан зүйлдээ чи өөрөө итгэж байна уу” гэж даргаасаа асуусан нэг ажилтныг санаж байна. Тэр бүү хэл найман сар үргэлжлээд хөрөнгө оруулалтын үндсэн нөхцөлүүдийг тохиролцож чадаагүй тохиолдол ч байсан юм. Хоёр тал бие биедээ итгэхгүй байгаагаас, эрсдэлээс айснаар ийм сунжирсан хэлэлцээрийн дараа хүртэл ямар ч үр дүн гараагүй юм.

Бүр тохиролцоонд хүрэх ямар ч боломжгүй мэт санагдах үед ч шинэ шийдэл, арга сэдэж чаддаг хүн бол жинхэнэ лидер. Ямарваа нэгэн гэрээ түүний, эсвэл нөгөө талын эрх ашгийг хамгаалах бус, хоёр талын хүсэл сонирхолд нийцсэн байх ёстойг лидер ойлгож байдаг.



Усны жилд

Улаанбаатарчууд нүүх үү, үлдэх үү?

Эрт цагт Туул гэж нэгэн үзэсгэлэнт бүсгүй байжээ. Тэр бүсгүй Байгаль нуурт хадамд гарч, жил бүр ханш нээх цагаар төрхөмдөө ирж золголт хийдэг байсан бөгөөд улмаар энэ нь загас урсгалаа сөрж, нүүдэг цаг үетэй давхцдаг байжээ. Үзэсгэлэнт бүсгүй Туулын инж нь Туулын шугуй, тотем нь Загас байжээ. Туулын усыг эм ус өөрөөр хэлбэл, эр хүнд хамгийн зохимжтой гэж ярьдаг байна. Тиймээс ч ардын дуунд ...Туулын тунгалаг уснаас амсан байж мордсон юм..." хэмээн цэрэг эрс дайн тулаанд эсвэл Манжийн амбаны хугацаагүй цэргийн албанд мордохдоо дуулдаг ч байсан байж болох. Эцэг хүн эмэгтэй үрдээ мөнх амьдралыг бэлэгдэж, амьд бүхний эх ус, Туул голын нэрийг хайрласаар иржээ.

Тиймээ, нийслэлчүүд бидний амьдралын эх булаг болсон Туул гол эдүгээ ямар байдалтай болчихоод байна вэ. Дуунд, домогт мөнхөрсөн Улаанбаатар хотын чимэг болсон голын ирээдүй ямар байна вэ. Улмаар нийслэлчүүдийн ундны усны эх болсон энэ голын урсац ямар байна вэ? Эдгээр асуултад ямар нэг баримт дурдахгүйгээр хариулахад ч бэлэн байна. Туул голын маань ирээдүй, улаанбаатарчуудын ирээдүй үнэхээр бүрхэг, хэцүүхэн л харагдаж байгаа шүү дээ. Үүнд нийслэлчүүд бид өөрсдөө л түмэн буруутай. Жил бүрийн хавар эргээ даган халин урсан ирж, хүн бүхний магнайг тэнийлгэдэг Туул гол сүүлийн жилүүдэд энд тэндээ тасарч, байгалийн жам ёсоор аргагүйн эрхэнд л нэг ирдэг болж байх шиг. Энэ нь ердөө л бидэнд гомдсоны шинж.

Бусад улс орон хотынхоо дундуур урсах гол мөрнөө ямар их хайрлан хамгаалдаг нь харагддаг. Тэгвэл манайхан харин ч эсрэгээр хог новшоор дүүргэж, хувцас хунар, хивсээ, машин тэргээ хүртэл угааж бохирлоно. Бизнесийн шуналд автагсад голын эргийг нь тултал хашаа хатгасан нь ч бий. Үйлдвэр аж ахуйн газрууд нь болохоор химийн бодис бүхий.... Голын эхэнд алтны, уул уурхайн үйлдвэрлэл явуулж, гол мөрнийг ямар нэг хэмжээгээр бохирдуулж байна. Хайрлах хамгаалах сэтгэлээр хандаж байгаа жишээ бараг л алга. Хааяа нэгхэн эрэг хавийн хог шороог нь цэвэрлэх төдийхнээр хайрлаж хамгаалж байгаа

бус уу.

Туул гол ширгээд алга болбол нийслэлчүүд бид хаанаас ундны усаа залгуулах вэ. Улаанбаатарчууд нүүх үү, үлдэх үү гэсэн сонголтын дэргэд тулж ирснийг Монголын эдийн засгийн чуулганы Хотын хөгжил салбар хуралдааны үеэр анхааруулан онцлон ярьж байсан шүү. Хэрвээ бид манай улсын хамгийн тулгамдсан усны асуудлаа л шийдэж чадахгүй юм бол хөгжил, шийдэл, гарцын тухай яриад ч яах юм. Дэлхийн банк "Туул голын экосистемийн эдийн засгийн үнэ цэнэ" судалгааны бүтээлдээ Улаанбаатар хот 10 жилийн дараа усны хомсдолд орж болзошгүй гэсэн дүгнэлт хийсэн. 2009 онд хийсэн судалгаа гэж үзвэл найман жилийн дараа нийслэлчүүд усны эрэлд явж магадгүй гэсэн үг. Засгийн газрын судалгаагаар өдөрт хэрэглэх усны хэмжээ өнөөдөр 212 мянган шоо метр байгаа бол 2010 онд 286, 2020 онд 438, 2050 онд 708 мянган шоо метр болж өсөх хандлагатай буй аж. Тэгвэл нийслэлд буй бүх худаг хүчин чадлаараа ажиллахад өдөрт 300 мянган шоо метр л усаар хангахаар төлөвлөжээ. Тэгэхээр улаанбаатарчууд ундны усны эрэлд явах цаг ойртсоор буйг энэ баримт харуулна. Дээрх судалгаагаар Туул голын экосистемийг хамгаалж, тогтвортой ашигласан тохиолдолд голын урсацын суурь хэмжээ, газар дорх усны түвшинд мэдэгдэхүйц өөрчлөлт гаргахгүйгээр хамгаалж болохоор байна гэсэн дүгнэлт хийсэн нь бий.

Нэмээд хэлэхэд төр, засаг л гол мөрнөө хамгаалах бодлого явуулах ёстой гэсэн сэтгэлгээнээсээ салж, монгол хүн бүхэн өвөг дээдсийнхээ байгаль эхээ хайрлан хамгаалах уламжлалт үйлсийг сахин дэлгэрүүлж, дор бүрдээ мөрдөж ажиллаж, амьдармаар байна.

Ингээд усны мэргэжилтний баримт бүхий материалыг та бүхэнд хүргэж байна.

Туул голын ус зүй, экологийн байдал, усны бохирдол, хүн амын ус хангамж, шийдэх арга замууд

Туул голын ус зүй хэтийн төлөв

Хан Хэнтий нурууны далайн төвшнөөс дээш 2000 гаруй метр өндөр орших Чисаатяйн сарьдаг, Шороотын давааны

өврөөс урсах Намъяа, Нэргүй хоёр голын уулзварыг Туул голын эх гэж үздэг бөгөөд 50400 км.кв талбайгаас усжиж 704 орчим км урсаж Орхон голд цутгадаг. Туул голын сав газар нь Улаанбаатар хот, Төв аймгийн 20, Булган аймгийн 5, Архангай аймгийн нэг, Өвөрхангай аймгийн 2, нийтдээ Улаанбаатар хот болон дөрвөн аймгийн 27 сумыг дамжин урсдаг бөгөөд голын ус хурах талбай нь 49616 ам.км байна. Туул голын ай савд 84 гол, горхи, 58 том жижиг нуур, 106 булаг бүртгэгдсэнээс сүүлийн жилүүдэд 10 гол, 18 нуур, 20 гаруй булаг ширгэжээ.

Туул голын усны горим, нөөцийг 1945 оноос Ус судлалын Туул гол-Улаанбаатар харуул байгуулан, горимын байнгын ажиглалт, судалгааг хийж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Туул голын дагуу Босгийн гүүр, Улаанбаатар, Алтанбулаг, Лүн болон Сэлбэ голын дагуу Санзай, Дамбадаржаа, Тэрэлж, Улиастай гол дээр байнгын харуулууд Ус, цаг уурын албаны хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Урсацын олон жилийн хэлбэлзлээс үзэхэд Туул гол 1945-1957 онд ус багатай, 1958-1975 онд ус элбэг, 1976-1981 онд ус багатай, 1982-1995 онд ус элбэг үе зонхилж үүнээс хойш ерөнхийдөө ус багатай үе үргэлжилж байна. Туул голын усны горимын хувьд голын усны тэжээлийн 25 хувийг ул хөрсний ус, зургаан хувийг хайлсан цасны ус, 69 хувийг хур борооны ус эзлэх ба усны горимын хэв шинж нь хаврын шар усны ба зуны хур борооны үерийн горимтой голд хамаарна. Туул голын усны үндсэн тэжээл нь зун, намрын хур борооны ус байдаг учир голын усны төвшин ихээхэн тогтворгүй байна.

Туул голын ус зүйн хувьд дараахи өөрчлөлт гарч байна.

1. Хур борооны нэг үерийн үргэлжлэх хугацаа 1940-өөд онд 15 хоног байсан бол одоо 12 хоног болж, сүүлийн буурсаар байна.

2. Сүүлийн 60 жилд хоногийн урсацын хувьслын итгэлцүүр 9 хувиар, стандарт хазайц 15.6 шоо м/сек тус тус нэмэгдэж, урсац ихээхэн тогтворгүй хуваарилалттай болжээ.

3. Улаанбаатар хотын агаарын бохирдол, хөрсний элэгдэл зэрэг хүний үйл ажиллагааны шууд нөлөөлөл ба уур амьсгалын дулаарах явцыг дагаж Улаанбаатар хот орчимд Туул голын мөс эрт хайлах нөхцөл бүрдэж байна. Туул гол мөсөн бүрхүүлтэй байх хоногийн тоо сүүлийн 60 жилд 12, мөсний үзэгдэлтэй байх хоногийн тоо найм хоногоор тус тус цөөрчээ.

4. Гол бага устай байх хоногийн тоо болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр агаарын температур нэмэгдсэнтэй уялдаж усны температур сүүлийн 60 жилд 1.9C нэмэгдэж, мөсний зузаан 40 см-ээр багасаж, түүний ажиглагдах хугацаа 22 хоногоор эрт ажиглагдах зэрэг хандлагатай болжээ.

5. Туул голын гадаргын урсацын алдагдал буюу газрын доорхи урсацыг тэжээх хэмжээ Улаанбаатар хотын усан хангамжийн худгуудын орчимд нэмэгдэж, урсацын алдагдлын бүс голын дагуу Тэрэлж, Туулын бэлчир хүртэл өгсөх хандлагатай, улирлын хөдлөлзүйтэй болж байна.

6. 60 орчим жилд 2-3 хоногоор богиносож байна. Туул гол жилдээ 10 орчим удаа үерлэдэг. Иймээс Туул гол жилийн дунджаасаа бага устай байх хоногийн тоо 24 орчим хоногоор нэмэгджээ. Энэ нь гол ус багатай байх үеийн үргэлжлэх хугацаа уртсаж, голын сав газарт унасан хур тунадас богино хугацаанд эрчимтэй урсац үүсгэж байгааг харуулж байна. Туул голын үерийн хамгийн их урсац жил тутам 20 гаруй шоо м/сек хэмжээгээр нэмэгдэж, үерийн гамшигт хүргэх нөхцөл бүрэлдсээр байна.

Туул голын сав газрын ус ашиглалт

2008 оны байдлаар туул голын ай сав газарт нийт 92741,0 мянган/м3 ус хэрэглэсэн байна. Улаанбаатар хотод 78284,8 мянган/м3 ус хэрэглэсэн бөгөөд үүний 80 хувийг газрын доорхи, 20 хувийг гадаргын усаар хангаж байна. Улаанбаатар хотын газрын гүний усний боломжит нөөц нь хоногт 240.0 мянган/м3 бөгөөд Ус сувгийн удирдах газрын өгсөн мэдээгээр хоногт 155.0-165.0 мянган/м3 ус хэрэглэж байна. Туул голын хамгийн том ус хэрэглэгч, ашиглагч нь Улаанбаатар хот юм.

Улаанбаатар хотод 1032353 хүн ам, 384824 толгой мал, 129 га бүхий 4 жижиг инженерийн хийцтэй услалтын систем, 4000 гаруй жижиг дунд үйлдвэр, 16000 аж ахуйн нэгж, 630 га бүхий ногоон байгууламж, 30 гаруй жуулчны бааз, 3 томоохон ДЦС ажиллаж байгаа бөгөөд хотын усан хангамжид 1515 гаруй гүний худаг ашиглаж байна.



Туул голын сав газрын ус хэрэглээний т л в

Усны хэрэглээ	2008	2010	2015	2020	2025	2030
Хүн ам	41223,4	49536,3	60274,2	56698,2	58973,2	67809,2
Уул уурхай	8200,1	8699,4	10084,8	8222,7	6704	5438
Аж үйлдвэр	26636,3	31068,5	45649,5	67073,9	94074,2	131943,5
УБ хотын албан байгууллага	9725,6	10118,4	11169	12329	13343	14731
Мал аж ахуй	5339	5158,4	4453,1	4282,6		
Услалтын систем	1331,6	1471,7	1909	2459,7	3169,1	4083,3
Ногоон байгууламж	253	328,5	520	712	904	1200
Аялал жуулчлал	32	42,3	84,8	170,4	342,3	688,1
	92741,0	106423,5	131144,4	151948,5	177509,8	225893,1

Туул голын бохирдол, тулгамдсан асуудлууд:

Туул голын сав газарт улсын нийслэл Улаанбаатар хот оршдог бөгөөд манай улсын нийт хүн амын 50 гаруй хувь нь оршин суудаг тул Туул голын экологийг хэвийн хадгалах явдал хамгийн тулгамдсан асуудал юм. Туул голын хувьд урсацын эхнээс эхлээд Орхон голд цутгах хэрэгтлэх хэсэгт асуудлууд хуримтлагдсаар байна. Энгийн дурьдвал: Хэдийгээр Туул голын урсац бүрэлдэх эх Тусгай хамгаалалттай газар нутагт багтдаг боловч тэнд сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр аялал, жуулчлалын баазууд байгуулагдаж, түүнийг дагаж автомашин зэрэг тээврийн хэрэгсэл ихэсч, малтай айл иргэдийн тоо ч нэмэгдэх хандлага байна. Тиймээс одоо байгаа жуулчдын баазуудад бүхэлд нь байгаль орчны нарийвчилсан нөлөгөө хэрэгтэй байгаа юм.

Туул голын усыг бохирдуулагч үндсэн эх сүвэрүүд нь

Туул голын сав дагуух хотжилт, Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал, Өйлдвэр комбинатын суурин дээр бий болсон хоцрогдсон технологи бөхий өйлдвэрүүд, хөдөө аж ахуй, уул уурхай, агаарын бохирдол хур тунадас гэж тодорхойлж болно.

Усны н цийг арвижуулах, усны эхийг хамгаалах зорилгоор:

- “Туул-Сонгино” усан цэнэгт цахилгаан станцыг байгуулж, ашиглалтад оруулах
- Туул голын усны эхийг тусгай хамгаалалтад авах, ойжуулах, моджуулах өйл ажиллагааг улсын болон Улаанбаатар хотын төсвээр дэс, дараатай хэрэгжүүлэх
- Туул голын усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан Засгийн газраар батлуулах
- Ус бохирдуулсны хариуцлагыг чангатгах, усны экологи-эдийн засгийн нөлгөөний дагуу усыг бохирдуулсан, усны нөхцлийг хомсдуулсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаар учирсан экологийн хохирлыг арилгуулдаг журамд шилжих
- Усны хяналт-шинжилгээний сэлжээг байгуулж, ажиллуулах зардлыг улсын төсвөөс гаргаж хэрэгжилтийг хангах.
- Усны дахин хэрэглээ, саарал усыг ашигладаг технологийг хувийн болон шинээр баригдах нийтийн орон сууцуудад хэрэгжүүлэх ажлыг туршилтын журмаар хэрэгжүүлэх
- Хөрсний усыг хотын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, зам, талбайг услах, усан сан, өвлийн улиралд гулгуурын талбай байгуулах зэрэг өйл ажиллагаанд ашиглаж хэвшүүлэх
- Сууцны дээврийн усыг зуны улиралд цуглуулан ахуйн зориулалтаар үгaalга, хувийн ногооны аж ахуйг ашигладаг практикийг иргэд, өрхөөдөд хэвшүүлэх

Унд - ахуйн усан хангамжийн эх өөсвэрийн тэжээлийн дотоод муж болон дэвсгэр талбайг бөхөлд нь ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бөсөд оруулж барилга байгууламж барих, зэгс, шагшуурга мод огтлох, ашигт малтмал хайх олборлох, элс хайрга чулуу авах, хөдөө аж ахуйн бөтээгдэхөөн өйлдвэрлэх цэг байгуулах, инженерийн хийцтэй барилга байгууламж барих зэрэгт газар олгохыг хатуу хориглох санал тавьж байна.

Туул голын сав газрын зөвлөлийг 2010 оны 11 дөгээр сарын 17-нд байгуулсан. Нийт 15 гишөөнтэй энэ зөвлөл өнгөрсөн оны сөллчээр

Ундны усны төвийн эх сүэр дээр хог хаягдал их байна

ШУА-ийн Геоэкологийн хөрээлэнгийн судалгаагаар Ундны усны төвийн эх өөсвэр дээр ахуйн болон барилгын хатуу хог хаягдал маш их байна. Нийт 10-12 га газрыг хамарсан 25-30 мян.м3 орчим хог хаягдал байгаагийн 30 орчим хувь нь нураасан барилгын бетон, тоосгоны хаягдал, 20 тн орчим ахуйн гаралтай хог хаягдал байгаа нь тогтоогдсон байна. Гөний худгийн усны шинж чанарт гадаргын хог хаягдлаас гадна хөрсний шинж чанар, газар доорхи усны төвшин, гадаргын элэгдэл эвдрэлийн байдал нөхцөлж байдаг. Газрын гадаргын элэгдэл эвдрэл нийт нутаг дэвсгэрийн 60 хувьд хөчтэй, 30 хувьд дунд зэрэг, 10 хувьд бага зэрэг илэрчээ.

Судалгаанд хамрагдсан талбайн хөрсний нянгийн бохирдол дунд зэрэг. Нянгаар бохирдоог й цэвэр хөрс илрээг й. Нийт хөрсний 27,9 хувь нь бага бохирдолтой, 48,8 хувь нь бохирдолттой, 23,3 хувь нь их хэмжээний бохирдолттой байна. Хөрс нь хөнд металлын (Pb, Cd, Hg, Cr, Zn, Ni, Cu, Co) бохирдолтоор бага, нийлбэр бохирдолтын коэффициент (Zc) дунджаар 2.5 буюу бохирдоог й хөрстэй харьцуулбал 2.5 дахин их байна.

Бохирдол хойд талын хугдуудаар арай илүү байгаа нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өйл ажиллагаатай холбоотой юм. Одоогийн байдлаар

ихэнх гөний худгийн ус бохирдоог й, стандартын төвшинд байгаа боловч 27, 36-р хугдуудын усанд нянгийн тоо, 36-р худагт гэдэсний өвчин өөсгэгч бактери зөвшөөрөгдөх хэмжээнээс тус тус илүү илэрсэн байна. Зун их хэмжээний бороо орсон тохиолдолд бусад худгын ус бохирдох аюулд хөрч болзошг й.

Төвийн эх өөсвэрийн худгийн усны шинж чанарын ихэнх өзөллөлт стандартын төвшинд буюу зөвшөөрөгдөх хэмжээнд бол Дунд гол, Нарантуул, Амгалангийн гэр хороололтой хамгийн ойрхон орших хугдуудын усны шөлтлэг, хуурай өзэгдэл, кальци, магни, сульфат, хлорид, нитрат зэрэг эрдэсжилттэй холбоотой өзөллөлт дэвшөөрөгдөх хэмжээнээс ялимгүй /бага зэрэг/ их байна. Энэ нь хөрсний гадаргын бохирдлоос гадна гэр хорооллын бохир /муу/ ус, Сэлбэ голын савын газрын доорхи усны бохирдлын нөхцөлөөс хамаарч байна гэж өзөхөндэстэй юм.

Ундны усны Төвийн эх өөсвэр орчмын нутагт одоогийн байдлаар хөрсний нянгийн бохирдолитэй, хөнд металлын бохирдолт бага төвшинд, гадаргын элэгдэл, эвдрэл, хөрс ургамалан нөмрөгийн талхагалт их, бохирдол эвдрэлийн хэмжээулам бөр нэмэгдэх хандлагатай байна. Цаашид ундны усны эх өөсвэрийг бохирдлоос онцгой хамгаалах шаардлага дээрх судалгаа харуулжээ.

анхны хурлаа хийсэн билээ. Сав газрын зөвлөлийн өндсөн зорилт нь Туул голын сав газрын усны нөхцлийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулах батлуулах, сав газрын хэмжээнд усны эх, голын урсацыг хамгаалах ажлыг төрийн болон албан байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах, ус ашиглалт, хэрэглээнд хяналт тавих, усны нөхцлийг бохирдуулах, хомсдуулах аливаа илэрлийг таслан зогсоох талаар холбогдох эрх бөхий байгууллагад уламжлах зэрэг өйл ажиллагаа явуулж байна. 2011 оны төгсөлд Туул голын сав газрын зөвлөлийн менежментийн төлөвлөгөөг Нидерландын Засгийн газрын тусламжтайгаар хэрэгжиж байгаа “Монгол орны усны нөхцлийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх нь” төслийн баг боловсруулж дуусгах

юм. Сав газрын зөвлөл энэхөө ажилд бололцооны хирээр туслах, усны нөхцлийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг өндүлаанбаатар хотын 2020 он хөртөлх өрөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, орон нутгийн болон бөсийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан зохиох улмаар нийслэл болон орон нутгийн хөгжлийн зорилтыг хангах юм. Энэхөө төлөвлөгөө гарч, хэрэгжсэнээр Туул голын сав газрын хөрээнд ус хангамж, усны нөхцлийн бохирдол, хомсдолтой холбоотой асуудлууд цогцоор шийдэгдэх юм.

Я.Цэдэнбалжир
/Туул голын сав газрын зөвлөлийн нарийн бичгийн дарга/



Д.Энхбатын БУЛАН

Асуудал

Туулын хөндий дэхь бидний соёл иргэншилд хэр хугацаа үлдсэн бэ ?

Улаанбаатар хотын чимэг Туул голд урь оржээ. Хэдийгээр Туул голын мөс хайлж эхэлж байгаа ч хаврын гол дээр очих сайхан. Мөс нь хайлан, шоржигнон урсах чимээг чагнан, эрүүл агаарыг цээж дүүрэн амьсгалах нь сайхан ч голын ус урьд жилүүдээс улам багасч буйд сэтгэл жаахан эвгүйрхэх. Тэгээд бас голын ойр орчмоор хогоор дүүрч өмнөх шигээ сайхан байхаа больжээ.

Голын урсгал татарч, хогонд дарагдан, ус нь хүчилтөрөгчгүйдэж, хэт бохирдож байгаагаас болж, загас өвчилж олноороо үхэх боллоо гэж эрдэмтэд хэлж байна. Хүн төрөлхтөний 5000 жилийн соёл

иргэншлийн бүх түүх гол усаа дагаж өрнөж ирсэн байдаг. Хаана ус их байна тэнд хүнс тэжээл элбэг, хүн ам нь олон, улс үндэстэн нь хүчирхэг байдаг. Хөх мөрөн, Шар мөрний хөндийд хятадууд, Нил, Ефрат мөрнийг даган арабууд суурьшиж өнөөдөр олон зуун сая хүнтэй их үндэстнүүд болсон гэдгийг бид түүхээс уншиж ирсэн. Монгол орон усны нөөцөөр ядуу, дулааны улирал богинотой учир түүхийн турш хүн ам бага суурьшсан нутаг байсаар ирсэн билээ. Ус бол соёл иргэншлийг тэтгэгч байгалийн их “эрчим хүч” юм. Ус нь алга болсон нутгийн соёл иргэншил мөхөж, хот суурин нь хоосорч, хүмүүс нь нүүдэллэн орхин

явдаг их түүх үргэлжилсээр л байна.

Туулын хөндийд орших Улаанбаатар хот бол монголчуудын анхны том суурьшил. Энд шинэ цагийн Монгол үндэстэн төвлөрч, хамтын суурин амьдралд суралцан, төр, засгаа байгуулан, үйлдвэрлэлээ хөгжүүлэн амьдарч байна. Харин бидний “эрчим хүчний” нөөц улам багассаар байна. Бид ч өөрсдөө түүнийгээ хайр найргүй багасгасаар байна. Туулын хөндий дэхь бидний соёл иргэншилд хэр хугацаа үлдсэн бэ ? Та энэ цаг хугацааг мэдэрье гэвэл Туул гол дээр очоорой.

Дэлхийн усны өдөрт

“No water no business”

Та усгүй нэг өдөр өнжиж чадах уу. Ер нь усгүйгээр ажил амьдралиа төсөөлж үзсэн үү? Таны бизнес усгүйгээр урагшлах болов уу. Тэгсэн мөртлөө та яагаад усанд хайр гамгүй, сэтгэлгүй ханддаг юм бэ. Шүдээ угаахдаа хэдэн литр ус зарцуулдаг тооцож үзсэн үү. Тэгвэл та яагаад жижиг саванд усаа хийгээд угаах болохгүй гэж. Ажилдаа дээрээ ч хүртэл та устай үнэхээрийн хайр гамгүй харьцдаг шүү дээ. Тэгвэл та бидний амьдралыг тэтгэгч усны нөөц дуусах болов уу гэж бодож байсан уу.

Дэлхийн цэнхэр гаригийн зарим улс оронд ундны цэвэр ус олдохгүй улмаас усгүйн гачланд унах боллоо. Цэвэр усны нөөцтэй нэгэн нь газрын баялаг шигээ усаа экспортлон худалдаж хөгжих тухай ярьж байна. Өөрөөр хэлбэл, газрын баялгаас илүүтэй цэвэр усны нөөцтэй улс орон дэлхийн хамгийн баян орон болох тухай эрдэмтэн судлаачид тэмдэглэж байна. Манай улсын хувьд цэвэр усны нөөцөөр тийм ч хангалуун орон биш шүү дээ. Тэгсэн мөртлөө усыг хайр гамгүй, хэрэглэж ашиглаж хатуугаар хэлбэл, ямар ч сэтгэл зүрхгүй хүмүүс



шиг л хандах болсон. Дээд тал нь суудлаа олохгүй бол доод тал нь гүйдлээ олохгүй гэдэг шиг байгаль дэлхийд хандах хандлагаараа ямар ч сэтгэлгүй бүхэл бүтэн залуу үе өсөж өндийж байна. Яах вэ?

Бага насны хүүхдүүдэд цэцэрлэг сургуулиас нь эхлэн байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах талаар тусгай хичээл ордог болгох талаар холбогдох төрийн байгууллагаар яваад дийлэхгүй байна гэсэн асуудлыг усны зарим холбоодын удирдлагууд ярьж байсан. Манай улсын хувьд ийм хичээлийг цэцэрлэг сургуулиудад тусгай хөтөлбөрөөр зааж, ойлгуулах цаг нь иржээ. Харин усыг хамгийн ихээр хэрэглэдэг бизнесийнхэн сүүлийн үед цөөн уулзалдаж, усны хэрэглээ, цаашдын төлөвийн талаар бага ч болов ярьдаг болсон нь сайшаалтай. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим дээр “No water no business” нэртэй уулзалт болсон юм. Тус уулзалт “саарал ус” буюу дахин цэвэршүүлсэн ус хэрэглэх, усанд хэмнэлттэй шинэ технологийг ашигласнаар зардлаа хэмнэх, бизнесийн байгууллагын нийгэмд хүлээх хариуцлага зэрэг өргөн хүрээтэй асуудлаар саналаа солилцсон. Ялангуяа бизнесийн салбарынхан усанд хандах хандлагаа өөрчлөх цаг ирснийг энэ уулзалтаар ойлгуулахыг хичээсэн гэж хэлж болно. Усыг хамгийн их хэрэглэгчид нь бизнесийнхэн гэсэн судалгаа байдаг. Тухайлбал, нэг литр ундааг үйлдвэрлэхийн тулд есөн литр ус зарцуулдаг тооцоо бий. Хэрвээ усаа хэмнэж чадвал зардлаа 50-10 түүнээс ч илүү хувиар хэмнэх боломжтой тухай ч мэргэжилтнүүд ярьсан юм. Уулзалтын үеэр санал бодлоо илэрхийлсэн зарим хүний үгийг хүргэе.

С.Дэмбэрэл: /МУХАУТ-ын дарга/

-Ногоон хөгжил рүү орох зайлшгүй шаардлагатай. Зөвхөн усны, модны гэж биш бүхэлд нь экосистемийн үйлчилгээний төлбөр гэж авах нь зүйтэй. “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний дэд хөтөлбөр буюу “Таван 20”-ын зарчмыг боловсруулсан. Тодруулбал 2020 он дуустал хугацаанд эрчим хүчний үр ашгийг 20 хувиар нэмэгдүүлэх, байгальд оруулах хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг суурилагдсан чадлын 20 хувьд хүргэх зэрэг юм.

З.Батбаяр: /Усны газрын дарга/

-Усны хэрэглээг багасгая гэвэл усны үнийг нэмэгдүүлэх бус үнэлэмжийг нь нэмэгдүүлэх ёстой. Аж ахуйн нэгжүүд шинэ технологи нэвтрүүлснээр ашгаа нэмэгдүүлэх боломжтой. Нэгж бүтээгдэхүүнд ямар хэмжээний ус зарцуулж байгаагаа тооцох хэрэгтэй.

Яан Борн: /“Монгол оронд усны нөөцийг бэхжүүлэх нь” төслийн зөвлөх багийн зохицуулагч/

-НҮБ-аас өнгөрсөн жилийн есдүгээр сарын 30-нд усны эрхийг хуульчилж өгсөн. Тодруулбал хүн бүр аюулгүй цэвэр усаар хангагдах эрхтэй гэж. Гэтэл энэ эрхийг бизнес эрхлэгчид хамгийн их зөрчдөг. Бизнес эрхлэгчдийн усны хэрэглээ ил тод байх ёстой. Өөрийн бүтээгдэхүүнээр дамжуулан усыг хамгаалах нь зүйтэй. Хэрэв усанд ээлтэй үйлдвэрлэлийн үйл явцтай бол энэ нь хэрэглэгчдэд таалагдах сайхан сурталчилгаа болдог.

Ж.Гэрэлчулуун: /УННБ төслийн усны эдийн засгийн мэргэжилтэн/

-Усны тоолуур хэрэглэснээр зардлаа багасгах боломжтой. Дөрвөн ам бүлтэй өрх тоолуур тавиулбал


ойролцоогоор сард 130 мянган төгрөгийг хэмнэх боломжтой. Тоолуургүй бол нэг хүн өдөрт 230 литр ус хэрэглэдэг гэж тооцон төлбөр авдаг. Гэтэл судалгаагаар орон сууцны нэг хүн өдөрт дунджаар 120 литр ус хэрэглэдэг. Мөн орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх шаардлагатай байна.

Г.Түмэнжаргал: /МУХАУТ-ын Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газрын дарга/

-Бид ногоон хөгжил гэж зүгээр л яриад байна. Байгальд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ногоон аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгтэй. Манай орны онцлогоос шалтгаалаад оёмол сүлжмэл болон арьс ширний үйлдвэр ихтэй, тэдгээр үйлдвэрүүд бусад орныхтой харьцуулахад хэд дахин их ус зарцуулдгийг анхаарах хэрэгтэй.

Д.Басандорж: /Усны нөөцийн нэгдсэн менежментийн сургалт судалгааны төвийн захирал/

-Аж ахуйн нэгжүүдийн орлогод татвар ногдуулдаг биш ногоон татварын бодлого буюу байгаль орчны бохирдуулалтад нь ногдуулдаг байх хэрэгтэй. Хэрэв усаа буцаан ашиглаж байгаа бол урамшуулдаг больё. Манай газар дор байгаа усны нөөц маш бага иймд гадаргын усыг ашиглах, усны сан байгуулах хэрэгтэй.



“Mongolian Economy” сэтгүүл бизнесмэнуудээс хамгийн сүүлд ямар ном уншиж байгааг нь сонирхдог билээ. Бид харин энэ удаа уншигчдадаа шинэ ном танилцуулахаар шийдэж, “Интер ном” дэлгүүртэй хамтран ажиллахаар боллоо. Уншигчдынхаа өмнөөс тус дэлгүүрийн Шинэ номын тасгаас сонголт хийхдээ зөвхөн бизнесмэний сонирхол татах ном гэхээсээ илүүтэй тал талаас нь бодолцлоо. Тэдний үр хүүхэдтэйгээ ч тоглох завгүй байдгийг нь бодож бяцхан үрд чинь зориулж гоё ном сонголоо. Мөнхийн завгүй танд бидний хүргэсэн номын мэдээлэл явдлынхаа далимаар номын дэлгүүрээр шударч, хайртай үрээ баярлуулахад тань туслах болов уу. Мөн бизнесмэн хүний хувьд эрүүл мэндийн асуудал нэгдүгээрт тавигдах учраас “Эр хүн Та”, “Эрүүл эмэгтэй” гэсэн номууд хэрэг болох нь мэдээж. Эрүүл мэндтэй холбоотой эдгээр ном нь Март, Цэргийн баярын үеэр гүйлгээ сайтай байсан тухай “Интер ном” дэлгүүрийн Шинэ номын тасгийн худалдагч бүсгүй онцолсон шүү.

Хүүхдэд зориулсан “Урлаг” ном


Их Британийн дэлхийд алдартай “DK” хэвлэлийн газраас гаргасан уг номын онцлог нь хүн төрөлхтний урлагийн түүхийг үүслээс нь эхлээд өнөөг хүртэлх хөгжлийн үе тус бүрийн онцлогийг харуулжээ. Ингэхдээ гол гол бүтээл хийгээд төлөөлөгчдийн гэрэл зургийг товч, тодорхой тайлбартайгаар хүүхдийн нас, сэтгэхүйд тааруулан оруулсан нь тун сонирхолтой. Мөн уран

бүтээлчдийн намтрыг тухайн он цаг, нийгмийн хөгжлийнх нь онцлогтой үзүүлжээ. Хүүхэд байтугай, томчуудын ойлгоход төвөгтэй урлагийн олон урсгал чиглэл, төрөл зүйлийг тоочихоос зайлсхийж хэв маяг, сэдэв, дүр, дүрслэгдэхүүн талаас нь оновчтойгоор ангилсан байна. Мөн уран бүтээлчдийн арга барилыг энгийнээр тайлбарлаж хүүхдүүд

өөрсдөө туршиж үзэх боломжийг ч олгох давуу талтай. Урлагт хүүхэд хэрхэн дүрслэгдэхүүн болсныг сонирхолтойгоор харуулсан бөгөөд зарим эртний бүтээлийг өөрөө насаа “хэлэхээр” зохиомжилсон нь үнэхээр өвөрмөц. Хэрвээ Та энэ номыг хүүхдэдээ авч өгөх бол 17800 төгрөг шаардлагатай.

“Дэлхийг өөрчилсөн 12 ном”

Эл номын зохиогч Мэлвин Брэгг хэлэхдээ “Бид түүхийн аугаа үйл явдлуудын талаар эргэцүүлэн тунгаахуйд дайн тулаан, хувьсгал, улс төрийн эргэлт, өөрчлөлт, эсвэл байгалийн гамшиг руу хэлбийх нь элбэг байдаг. Харин байлдааны талбарт, төрийн орд харшид эсвэл байгалийн эзэрхийлэлд бус зөвхөн номын хуудаснаа өрнөсөн нэн ач холбогдолтой алтан хормууд л түүхийг бүхэлд нь тодорхойлсоор иржээ” гэсэн байдаг. Зохиогч нэлээд урт жагсаалт гаргаж үзсэний эцэст англи зохиолчдын бичсэн дэлхийг өөрчилсөн



гэж хэлж болох арван хоёр номыг сонгожээ. Харин энэхүү дэд дэвтэрт нь Исаак Ньютон “Математик зарчмууд” /1687/, Мэри Стопс “Гэр бүлийн хайр” /1918/, Английн удирдагч ангийн гишүүд “Магна Карта” /1215/, Английн нийтийн сургуулийн төгсөгчид “Хөл бөмбөгийн холбооны дүрмийн ном” /1863/, Чарльз Дарвин “Зүйлийн үүсэл” /1859/, Уильям Уилберфорс “Боолын худалдааг халах нь” /1789/ зэрэг номын талаар өгүүлнэ. Уг номын зохиогч Мэлвин Брэгг нь BBC радиогийн алдартай хөтөлгөч бөгөөд “Лир хаан Нью-Йоркт”, “Английн замнал”, “Английн адал явдал” зэрэг бестселлер номын зохиогч юм.

“Эрүүл Эмэгтэй”, “Эр хүн та”



Бүх насны эмэгтэйчүүд, эрчүүдэд түгээмэл тохиолддог өвчин эмгэгүүдийн үүсэх шалтгаан, ялгах шинж тэмдэг, хэрхэн сэргийлэх зэрэг зайлшгүй мэдэх ёстой бүхий л асуудал тус хоёр номд багтжээ. Үүнээс гадна гоо сайхан, эрүүл ахуй, зөв хооллолт, эрүүл жин хасалт зэрэг өдөр тутмын зөв амьдрах хэв маягийг мэргэжлийн үүднээс үнэн зөв тайлбарласан байна. Хүний их эмч С.Оюунцэцэг уг хоёр номоо шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн судалгаануудыг оруулан бичсэн аж. Зөвлөгөө мэдээллийг энгийн хэллэгээр, зургаар тайлбарлан үзүүлсэн ба та энэхүү номыг уншсанаар өөрийн биед гарах өөрчлөлтүүдийг ажиглаж бүхий

л төрлийн өвчин эмгэгээс өөрийгөө сэргийлж чадах хэмжээний мэдлэгийг олж авах боломжтой юм. Дээрх хоёр ном нь Эмэгтэйчүүдийн баяр, Цэргийн баяраар хамгийн борлуулалт сайтай байсан гэж “Интер ном”-ын шинэ номын тасгийн худалдагч эмэгтэй онцолсон.



Валютын зах

Дотоодын бэлэн бус валютын зах

Валют	Код	3/15		2/15		Өөрчлөлт (авах ханш)
		авах	зарах	авах	зарах	
Доллар	USDMNT	1,225	1,237	1,249	1,259	-1.9%
Евро	EURMNT	1,705	1,735	1,675	1,715	1.8%
Иен	JPYMNT	14.95	15.28	15	15.3	-0.3%
Юань	CNYMNT	186.3	187.8	188.7	191.7	-1.3%
Фунт	GBPMNT	1,946	2,038	1,973	2,064	-1.4%
Рубль	RUBMNT	42.5	44.1	42.2	43.8	0.7%
Вон	KRWMNT	1.06	1.14	1.09	1.17	-2.8%

Дотоодын бэлэн валютын зах

Валют	Код	3/15		2/15		Өөрчлөлт (авах ханш)
		авах	зарах	авах	зарах	
Доллар	USDMNT	1,233.00	1,235.00	1,254.00	1,258.00	-1.7%
Евро	EURMNT	1,720.00	1,730.00	1,690.00	1,710.00	1.8%
Иен	JPYMNT	15.05	15.12	15.10	15.25	-0.3%
Юань	CNYMNT	187.20	187.80	190.00	191.00	-1.5%
Фунт	GBPMNT	1,990.00	2,010.00	1,980.00	2,030.00	0.5%
Рубль	RUBMNT	42.00	43.00	42.70	43.00	-1.6%
Вон		1.12	1.14	1.15	1.17	-2.6%

Монгол банкнаас зарласан ханш

Валют	3/15	2/15	Өөрчлөлт
Доллар	1,238.00	1,257.64	-1.56%
Евро	1,725.52	1,702.84	1.3%
Иен	15.08	15.12	-0.3%
Юань	188.39	190.66	-1.19%
Фунт	1,986.87	2,019.96	-1.6%
Рубль	43.19	43.00	0.4%
Вон	1.10	1.12	-1.8%

Олон улсын валютын зах

Суурь валют	3/15		2/15		Өөрчлөлт
1 EUR =	1.3982	USD	1.351	USD	3.5%
1 USD =	80.8535	JPY	83.4065	JPY	-3.1%
1 GBP =	1.6062	USD	1.605	USD	0.1%
1 EUR =	113.0453	JPY	112.683	JPY	0.3%
1 USD =	6.5723	CNY	6.592	CNY	-0.30%
1 USD =	28.7531	RUB	29.273	RUB	-1.8%
1 USD =	1130.85	KRW	1120.43	KRW	0.9%

Төгрөгийн тогтвортой байдал ямар үнэтэй вэ

Монгол Улсын гадаад валютын нөөц 2.4 тэрбум ам.долларт дөхөж очжээ. 2010 онд манайд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.5 тэрбум ам.долларт хүрсэн нь жилийн өмнөхөөсөө 2.8 дахин өссөн үзүүлэлт болов. Үүний зэрэгцээ алт, зэс, нүүрсний үнэ өндөр байгаа нь Монголын гадаад худалдаанд сайнаар нөлөөлж буй. Энэ бүхнээс шалтгаалан төгрөгийн ханш цаашид чангарах төлөвтэйг мэргэжилтнүүд анхааруулсаар. Гэтэл яагаад манай мөнгөн дэвсгэртийн ханш өсөхгүй байна вэ? Өнгөрсөн хоёрдугаар сарын 15-наас гуравдугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд төгрөгийн бусад валюттай харьцах ханш тогтвортой байсныг хүснэгтээс харна уу.


Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш хэт чангарч, уул уурхайгаас бусад салбар өрсөлдөх чадвараа алдах нь Голланд өвчний шинж тэмдэг гэдэг. 2010 онд төгрөгийн ханш ам.долларын эсрэг 15 хувиар нэмэгдсэнээр дэлхийн хамгийн өндөр өсөлттэй валютаар шалгарч байлаа. Өнгөц харахад сайхан дуулдах энэ мэдээ саарыг дагуулах аюул тун ч өндөр. Голланд өвчнөөс сэргийлэхийн тулд Монголбанк өдрөөс өдөрт дээшээ тэмүүлж буй төгрөгийн ханшийг тогтвортой байлгахын тулд бүх чадлаа дайчилж буй аж.

2010 онд зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн тогтвортой байдлыг хангахын тулд 180 тэрбум төгрөг буюу 140 сая ам.доллар зарцуулсан тухай Төвбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан Монголын эдийн засгийн форумын үеэр онцолсон юм. Монголбанк долоо хоногт хоёр удаа гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулдаг бөгөөд сүүлийн үед энэ нь зах зээлд илүүдээд буй ам.долларыг татан авч, төгрөгийн ханшийг тогтворжуулах гол хэрэгсэл болсон нь нууц биш ээ. Манай гадаад валютын нөөц тэнгэрт хадсан нь ч үүнтэй холбоотойг мэргэжилтнүүд тайлбарлаж буй. Товчхондоо, гадаад валютын ханш буурах нөхцөл бүрдсэн ч эдийн засагт сөрөг үр дагавар бий болгохгүйн тулд Төвбанк төгрөгийн ханшийг бодлоготойгоор “дарж” буй ажээ.

Мөнгөний зах зах

Монголын Санхүүгийн Зах Зээлийн Холбоо нь олон улсын санхүүгийн мэдээллийн тэргүүлэгч компани болох Томсон Ройтерстой хамтран UBIBOR буюу Улаанбаатарын банк хоорондын суурь хүүг 2007 оны 3-р сараас эхлэн тооцоолж, зах зээлд оролцогчдод түгээх болсон. Энэхүү суурь хүүг тооцоолж нийтэд мэдээлж эхэлсэнээр нийт санхүүгийн зах зээлд хөвөгч хүүтэй санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн үнийг тогтоох боломжтой болсон билээ.

UBIBOR (1 жил)




UBIBOR буюу Улаанбаатарын банк хоорондын захын суурь хүү өнгөрсөн хоёрдугаар сарын 21-нээс гуравдугаар сарын 21-ний хооронд огцом өөрчлөлтгүй байлаа. Сарын дундаж өдрийн хүү 7.0173, сарын хүү 8.1532, жилийн хүү 10.0784 байсан нь өмнөх сарынхаас дундаар 0,03 хувиар өссөн үзүүлэлт юм.

Бондын зах

Улс	Валют	Хугацаа	Купон	Өгөөж	Купон	Өгөөж
			3/15		2/15	
Монгол	Төгрөг	3 сар	-	11.25	-	11.25
АНУ	Доллар	3 сар	-	0.08	-	0.12
	Доллар	2 жил	0.75	0.53	0.75	0.85
	Доллар	5 жил	2.12	1.86	2.12	2.37
	Доллар	10 жил	3.37	3.25	3.37	3.63
Герман	Евро	3 сар	-	0.72	-	0.65
	Евро	2 жил	1.25	1.64	1.25	1.40
	Евро	5 жил	2.50	2.51	2.50	2.46
	Евро	10 жил	3.25	3.23	3.25	3.30
Англи	Фунт	6 сар	-	0.71	-	0.75
	Фунт	2 жил	3.25	1.23	3.25	1.52
	Фунт	5 жил	5.00	2.29	5.00	2.68
	Фунт	10 жил	4.50	3.57	4.50	3.84
Япон	Иен	6 сар	-	0.14	-	0.14
	Иен	2 жил	0.30	0.22	0.30	0.24
	Иен	5 жил	0.70	0.51	0.70	0.59
	Иен	10 жил	1.30	1.23	1.30	1.31

Хувьцааны зах

Dow Jones



Хөрөнгийн бирж дэх “хөөс” хагарав


2010 онд 138 хувиар өсч, дэлхийг алмайруулсан Top 20 индекс туулай жилийн гараагаа ч амжилттай эхэлж, өсөлтийн хурдаа сааруулахгүй хэсэг “давхисан” билээ. Гэвч сүүлийн нэг сарын хугацаанд байдал эсрэгээрээ эргэв. Өнгөрсөн хоёрдугаар сарын 15-наас гуравдугаар сарын 15-ны хугацаанд уг индекс 19.1 хувиар доошилсон байна. Яагаад тэр вэ?

Бодит байдалтай уялдахгүй байгаа өсөлтийг эдийн засагчид “хөөс” гэж нэрлэдэг. Тухайн компанийн үйл ажиллагаа, амжилт хийгээд алдаанаас хамаарч хувьцааных нь ханш хэлбэлзэх учиртай. Гэтэл Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын ихэнх нь мэдээллээ ил тод байлгадаггүй, санхүүгийн тайлангаа ч нийтэд зарладаггүй. Тиймээс хөрөнгө оруулагчид хувьцааг “сохроор” худалдаж авах нь элбэг. Өөрөөр


хэлбэл, өнгөрсөн оноос эхэлсэн үнэт цаасны үнийн өсөлт “хөөс” байсныг мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

2010 оны сүүлчээс Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын хувьцааны ханш өдөртөө л 15 хувиар өссөөр, нүд ирмэхийн зуур хэд дахин нугарч амжсан. Тэгвэл хоёрдугаар сарын 15-наас гуравдугаар сарын 15-ны хооронд “Адуун чулуун”-ын үнэлгээ 46, “Багануур”-ынх 42, “Могойн гол”-ынх 40 орчим хувиар навс унасан


Nikkei 225



DAX




Top 20




FTSE 100

II.15 - 6,060.09 ; III.15 - 5,775.24 ; Өөрчлөлт: -4.7%




Shanghai

II.15 - 3,060.62 ; III.15 - 3,019.06 ; Өөрчлөлт: -1.4%




Hang Seng

II.15 - 23,016.50 ; III.15 - 22,595.60 ; Өөрчлөлт: -1.8%




RTS

II.15 - 1,881.87 ; III.15 - 1,958.76 ; Өөрчлөлт: 4.1%



Kospi

II.15 - 2,012.92 ; III.15 - 1,923.92 ; Өөрчлөлт: -4.4%








Нэр	Код	3-сарын 15	Нэг сарын өөрчлөлт (хувиар)	Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)
Тавантолгой	TTL	1,200,000	-5.0%	631.98
Багануур	BAN	24,400	-42.0%	511.82
Шивээ-Овоо	SHV	33,150	-16.0%	444.84
АПУ	APU	3,000	-3.2%	222.86
Шарын гол	SHG	19,500	-38.7%	141.01
Монголын цахилгаан холбоо	MCH	3,400	-10.5%	87.96
Адуун чулуун	ADL	16,983	-45.9%	53.52
Говь	GOV	6,100	-4.7%	47.59
Би ди сек	BDS	4,300	34.4%	47.3
Могойн гол	BDL	39,800	-20.8%	33.02
Монголиа девелопмент ресорсез	MDR	1,530	-10.0%	23.38
Улсын их дэлгүүр	UID	580	-31.0%	21.35
Ээрмэл	EER	5,151	5.1%	17.92
Хөх ган	HGN	174	-2.8%	17.63
Ремикон	RMC	138	-5.5%	17.61
Улаанбаатар зочид буудал	ULN	40,000	21.2%	13.41
Баянгол зочид буудал	BNG	27,100	-14.5%	11.47
Махимпэкс	MMX	2,750	-25.3%	10.45
Женко тур бюро	JTB	98	-3.0%	9.8
Дархан нэхий	NEH	7,500	-30.4%	8.29

Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хувьцааны ханхи

Нэр	Бирж	Код	03/15/2011 (ам.доллар)	Нэг сарын өөрчлөлт (хувиар)	Зах зээлийн үнэлгээ (сая ам.доллар)
Ivanhoe Mines	NYSE, TSX	IVN	25.17	-11.5%	16,448.3
Mongolian Mining Corp	HKEx	975	1.24	-6%	4,609.9
Centerra Gold	TSX	CG	15.1	-14.9%	3,550.8
SouthGobi Energy Resources	TSX, HKEx	SGQ, 1878	15.29	-1.1%	2,813.2
Mongolia Energy Corp	HKEx	276	0.19	-23.6%	1,189.9
Aspire Mining Limited	ASX	AKM	0.66	6.3%	450.8
Entrite Gold	TSX, AMEX	ETG, EGI	2.78	-13.6%	315.4
Petro Matad	LSE	MATD	1.92	-7.2%	301.6
Hunnu Coal	ASX	HUN	1.25	1.4%	227.6
Erdene Resource Development	TSX	ERD	1.25	-15.8%	111.4
Haranga Resources	ASX	HAR	0.43	-31.4%	79.6
Xanadu Mines	ASX	XAM	0.47	-26.9%	79.3
Khan Resources	TSX	KRI	0.31	-42.6%	17.0

Эх сурвалж: MICC
Mongolia's Investment Bank

Таваарын зах



“Хар алт”-ны ханш тэнгэрт хадлаа

Газрын тосны үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд 30 орчим хувиар нэмэгджээ. Манай импортын 25 гаруй хувийг зөвхөн нефтийн бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд дэлхийн зах зээл дэх “хар алт”-ны үнэ нэг хувиар өсөхөд Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 0.1 хувиар буурна гэсэн тойм тооцоо ч байдаг. Гэтэл баррель нефтийн ханш 100 ам.долларт хүрсэн нь түлш, шатахууны хэрэгцээгээ 100 хувь гаднаас хангадаг монголчуудын хувьд таатай мэдээ лав биш. WTI маркийн баррель нефтийн ханш өнгөрсөн хоёрдугаар сарын 15-наас гуравдугаар сарын 15-

ны хугацаанд 16.8 хувиар огцом өсч, 99 ам.доллараас давсныг хүснэгтээс харна уу. Энэ нь дэлхийн зах зээлд газрын тосны хомсдол бий болж байгаатай холбоотойг мэргэжилтнүүд тайлбарлав. Олон улсын эрчим хүчний агентлаг (ОУЭХА)-ийн тооцоолсноор 2011 онд нефтийн хэрэглээ өдрийн 1.5 сая баррелиар буюу 1.7 хувиар нэмэгдэж, 89.3 сая баррельд хүрэхээр байна. АНУ-ын эдийн засаг сэргэж, Азийн орнуудын хэрэглээ мэдэгдэхүйц өсөхөөр байгааг тус агентлагийн шинжээчид анхааруулжээ.

Гэтэл ОПЕК буюу нефть

экспортлогчдын холбоо олборлолтоо нэмээд нэмээд 29.8 сая баррельд л хүргэж байгаа юм. “Дайран дээр давс” гэгчээр Ойрх Дорнодын үймээн, Японы гамшиг “хар алт”-ны үнэ улам өсөхөд нөлөөлж буйг шинжээчид тайлбарлав. Газрын тосны үйлдвэрлэлээр дэлхийд толгой цохидог Ливи улсад нефть олборлолтын хэмжээ огцом буурчээ. Энэ тухай Ливийн төрийн өмчит Үндэсний газрын тосны корпорацийн захирал Шокри Ганем мэдэгдсэн байна.

ОУЭХА-ийн үзэж буйгаар 2013 онд нефтийн үнэ санхүү, эдийн засгийн хямралаас өмнө тогтоосон рекордоо эвдэж магадгүй аж. Баррель нь 147 ам.доллараас давах хандлагатай гэсэн үг. Ер нь цөөнгүй судлаач 2015 он гэхэд эрчим хүчний хямрал болно хэмээн таамаглаж байгааг сануулах юун. Тэр хүртэл ч хол байна гээд тайван сууж болох ч өдрөөс өдөрт өсч байгаа газрын тосны үнэ түгшүүр зарлаж байна. Гэтэл монголчуудын түлш, шатахууны хэрэглээ улам нэмэгдсээр. 2003 онд бид 441 мянган тонн нефтийн бүтээгдэхүүн импортолж байсан бол эдүгээ энэ үзүүлэлт хоёр дахин нэмэгдээд буй. За тэгээд уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэлж буйтай холбоотойгоор газрын тосны бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ улам л өсөх төлөвтэй. Хамгийн “даруухнаар” бодоход л 2012 онд 1.1, 2015 он гэхэд 1.5 сая тонн нефтийн бүтээгдэхүүн шаардлагатай гэсэн тооцоог мэргэжилтнүүд гаргажээ.

Түлш, шатахуун нь стратегийн чухал ач холбогдол бүхий эдийн засгийн суурь үнийг бүрдүүлэгч бүтээгдэхүүний нэг билээ. “Монголчууд болж өгвөл дотоодын хэрэгцээнийхээ 50 хувийг, болохгүй бол ядахдаа 30 хувийг өөрсдөө хангах хэрэгтэй” хэмээн Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжил, хөрөнгө оруулалтын



Сэтгүүлийн талаарх сэтгэгдэл

Л.Ганпүрэв

/Тайж группийн ерөнхийлөгч/

“Mongolian Economy” гэдэг маш сайхан сэтгүүл мэндэлсэнд баяртай байна. Монголд ийм эдийн засаг, бизнесийн төрөлжсөн сайн сэтгүүл үгүйлэгдэж байсан. Эдийн засаг, бизнесийн сэтгүүл бол төв байх ёстой. Танай сэтгүүл мэдээллийн хувьд ч өнгө дизайны хувьд ч тэр шалгуурт нийцэж байна лээ. Баяр хүргэе.

Б.Жавхлан

/Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч/

–Сүүлийн үед эдийн засаг, бизнес, уул уурхай салбарын янз янзын сэтгүүл гарч байгаа ч танайх экономист талдаа байгаа нь олзуурхууштай санагдсан. Мэдээлэл сайтай байсан шүү. Цааш цаашдаа сэтгүүлээ улам сайжруулаад явбал ирээдүй харагдаж байна шүү гэж хэлэх байна.

Н.Дашзэвэг

/Монгол дээд сургууль/

–Монголын эдийн засгийн хөгжил хурдсаж буй энэ цаг үед эдийн засгийн сэтгүүл гарч байгаад талархалтай байна. Монголд эдийн засгийн сэтгүүл гарах зайлшгүй шаардлагатай цаг үе ирээд байсан юм. Сэтгүүл бол өдөр тутмын сонины нүүрэнд баригдалгүй цаг үеийн хөнгөн биш илүү гүнзгий асуудлыг хөндөж бичих давуу талтай.Цаашид Барууны орны Economist зэрэг эдийн засгийн сэтгүүлээс Монголд хэрэгтэй нийтлэлүүдийг орчуулж тавьдаг байх хэрэгтэй. Ингэвэл танай сэтгүүл улам чанаржиж, эдийн засгийн чиглэлийн 50-60 сургуулийн оюутнуудад их хэрэгтэй сэтгүүл болно.

Л.Энхтайван

/Санхүү, эдийн засаг, бодлогын судалгааны төвийн тэргүүн/

Ер нь бол доторх материалын агуулга, хэмжээ их аятайхан өргөн хүрээтэй болсон байсан. Зарим сэтгүүл хэт зузаан эсвэл нимгэн гараад байдаг шүү дээ. Гол гол материалаа англи хэл дээр болгосон нь ялангуяа гадаадынханд их хэрэгтэй юм. Харин цаашдаа агуулгын хувьд практик, онолын чиглэлийн бусад орны туршлага, хөрөнгийн зээлийн үүсэл, хөгжил гэдэг ч юмуу зүйлсийг цувралаар оруулж байвал их хэрэгтэй болов уу. Судалгаа хийдэг байгууллагуудын судлаачдаас материал авч цувралаар гаргавал оюутан судлаачдад хэрэгтэй юм.

Д.Дүгэржав

/Санхүүгийн зохицуулах хорооны комиссар, дэд дарга/

Танай сэтгүүлийн анхны дугаарыг уншиж, сэтгэл үнэхээрийн хангалуун байлаа. Мэдээлэл сайтай, мэргэжлийн орчин үетэйгээ хөл нийлүүлсэн сайхан сэтгүүл болжээ. Сэтгүүлчдийн туршлага, мэргэшиж байгаа нь олзуурхууштай байлаа. Миний хувьд өөрөө эмэгтэй хүн болохоор бүсгүйчүүдийн ажил бүтээлийг харж баясах дуртай. Би хуульч мэргэжилтэй, иргэний эрх зүй, бизнесийн эрх зүй, санхүүгийн эрх зүйн чиглэлээр багшилж, ном бичдэг. Харин сүүлийн үед эдийн засаг, санхүүгийн чиглэлийн нийтлэл, материал, ярилцлага унших болсон. Ингээд танай сэтгүүлийг олон жил тогтвортой үйл ажиллагаа явуулж, уншигчид, мэргэжилтний ширээний сэтгүүл болоосой хэмээн хүсэн ерөөе.

